МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМ 2021

WHITE PAPER ON CRIME

Улаанбаатар хот
2022 он

ЗАХИАЛАГЧ

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ГҮЙЦЭТГЭГЧ

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ БАГ

Зөвлөх

О.Зоригт Хууль зүйн доктор, дэд профессор

Судалгааны багийн ахлагч

С.Гантулга Хууль зүйн доктор, дэд профессор

Судлаачид

Дотоод хэргийн их сургууль:

Б.Алтангэрэл, Б.Лхагвасүрэн, Б.Мөнхдорж, Л.Одхүү, Э.Хандармаа, Г.Ганхүлэг, Н.Сайнбаяр, Э.Дашгаадан, Д.Буяннэмэх, Ч.Батболд, М.Хүрэлбат, Н.Анар, М.Эрдэнэжаргал, Т.Анхбаяр, Б.Тулга

Хамтран ажилласан байгууллага:

Б.Одмандах (ГХУСАЗЗАА), Б.Баяндүүрэн (ГХУСАЗЗАА), Х.Эрдэм-Ундрах (ХЗҮХ), О.Энхүслэн (ХЗҮХ), Х.Буянбат (ХЗҮХ), Ц.Дулмаа (ҮСХ), Э.Ганцэцэг (ШЕЗ), И.Хүдэрцэцэг, Б.Дэлгэрсүрэн (УЕПГ), С.Энхбаатар (ЦЕГ), Г.Уянга (ЦЕГ), Д.Орхонсэлэнгэ (ШШҮХ), Ш.Баттунгалаг (ШШГЕГ),

АГУУЛГА

БОСГО ҮГ 4

ӨМНӨХ ҮГ 5

I. ЦАГДАА - POLICE
1. Товч танилцуулга 12
2. Гомдол, мэдээлэл 12
3. Гэмт хэрэг 14
4. Мөрдөн шалгах ажиллагаа 24
5. Зөрчил шалган шийдвэрлэлт 26
6. Замын хөдөлгөөний аюулгүй байдал 29
7. Эрүүлжүүлэгдсэн хүн 55
8. Урьдчилан сэргийлэх ажил 55

II. ПРОКУРОР - PROSECUTOR
1. Товч танилцуулга 61
2. Гомдол, мэдээлэл 62
3. Хяналт тавьсан эрүүгийн хэрэг, түүний шийдвэрлэлт 67
4. Хяналт тавьсан зөрчлийн хэрэг, түүний шийдвэрлэлт 86
5. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил 91

III. ШҮҮХ – COURT
1. Товч танилцуулга 95
2. Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт 100
3. Зөрчлийн шийдвэрлэлт 114
4. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил 119

IV. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ – CORRECTION
1. Товч танилцуулга 123
2. Хорих ялын шийдвэр гүйцэтгэл 125
3. Хорихоос өөр төрлийн ялын шийдвэр гүйцэтгэл 128
4. Баривчлах шийтгэлийн гүйцэтгэл 137
5. Цагдан хорих арга хэмжээний шийдвэр гүйцэтгэл 138

V. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР - ANTI CORRUPTION
1. Товч танилцуулга 141
2. Гомдол, мэдээлэл 141
3. Мөрдөн шалгах ажиллагаа 143
4. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил 145
5. Монгол Улсын Авлигын индекс 145
6. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил 146

VI. ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭ – FORENSIC
1. Товч танилцуулга 151
2. Шинжилгээний тоон мэдээ 151
3. Хэргийн газрын үзлэгт оролцсон байдал 159
4. Сан баяжуулалт, ашиглалтын статистик 161
5. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил 163

VII. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIME VICTIM
1. Цагдаагийн байгууллагын статистик 169
2. Авлигатай тэмцэх байгууллагын статистик 175
3. Прокурорын байгууллагын статистик 176
4. Шүүхийн статистик 177
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, хохирол нөхөн төлүүлэлт 177

VIII. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ 184

IX. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙГ ОЛОН УЛСАД ТАЙЛАГНАСАН БАЙДАЛ 197

НЭГДСЭН ДҮГНЭЛТ 210

ЭХ СУРВАЛЖ 216

ХАВСРАЛТ 220

БОСГО ҮГ

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2016 онд санаачлан “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном” товхимлыг 6 дахь жилдээ эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгож байна. 2021 оны ээлжит товхимлыг тус зөвлөлийн ажлын Албаны захиалгаар Дотоод хэргийн их сургууль нэгтгэн боловсруулав.

Гэмт хэргийг олон талаас нь судлах, түүнтэй тэмцэх төрийн бодлогыг үнэлэх, дүгнэх, гэмт хэргийн түвшний өөрчлөлтийг хэмжих, гэмт хэргийн онцлог, шинж чанарыг танин мэдэхэд гэмт хэргийн статистикийн бодит мэдээлэл нэн чухал билээ. Уг бүтээлд гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэх хэрэгцээ, шаардлагыг тусгаж, энэ чиглэлийн судалгааг Үндэсний статистикийн хороотой хамтран зохион байгуулж бүлгийн хэмжээнд тусгаснаараа онцлогтой.

“Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2021” товхимолд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны тоон үзүүлэлт, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн онцлог ажлыг өмнөх товхимлуудаас өргөн хүрээнд авч үзсэн ба тэдгээрийн үр дүнг харьцуулж, нэгтгэн дүгнэсэн, мөн гадаадын зарим улсын туршлагаас тусгаж, олон нийтэд илүү ойлгомжтой байдлаар номын бүтэц, агуулгыг боловсруулсан ач холбогдолтой болжээ.

Энэхүү бүтээлийг боловсруулахад шаардлагатай мэдээлэл, судалгааг ирүүлсэн Улсын Ерөнхий Прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Үндэсний статистикийн хороо, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, тэдгээрийн алба хаагч, ажилтан нарт болон Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн багш, судлаач, судалгааны багийн гишүүдэд талархал илэрхийлье.

Гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллийн үзэл баримтлал, тогтолцоог боловсронгуй болгоход холбогдох суурь судалгааг хийх, түүний үр дүнд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулахад энэхүү бүтээлийн ач холбогдол оршино хэмээн үзэж байна.

“Цагаан ном”-ын гэгээ тусаа өгөх болтугай.

Л.НЯМГЭРЭЛ

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

ӨМНӨХ ҮГ

Анх 1872 онд Лондонд болсон “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба таслан зогсоох” олон улсын чуулганы үеэр дэлхийн улсуудын гэмт хэргийн статистикийн ойлголт, тодорхойлолтын зөрүүтэй байдлаас шалтгаалж, олон улсын түвшинд гэмт хэргийн статистикийн мэдээллийг харьцуулан судлах боломжгүй байгааг цохон тэмдэглэсэн байдаг.

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын Эдийн засгийн комисс хамтран “Гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангилал”-ыг 2015 онд боловсруулан баталж, дэлхий нийтэд мөрдүүлсэн. Гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэхэд гэмт хэргийн статистикт зориулсан үндэсний ангилал болон судалгаа чухал үүрэг гүйцэтгэнэ.

Энэ ч үүднээс гэмт хэргийн статистикийн мэдээллийг гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, үйл ажиллагаанд ашиглах боломжийг нэмэгдүүлэх, олон улсын ангилал, жишигт нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны захиалгаар “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2021” товхимлыг Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн, судлаачид хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон статистикийн байгууллагатай хамтран боловсруулж, практик үйл ажиллагаа болон судалгааны эргэлтэд оруулж байна.

Уг товхимлыг эрхлэн гаргахад шаардлагатай статистик мэдээлэл, судалгааг ирүүлсэн, мэдээллийг нэгтгэн боловсруулахад хамтран ажилласан эрдэмтэн, судлаачид, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах статистикийн байгууллагын ажилтнуудад талархал илэрхийлье.

Судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийхэд өмнөх туршлагыг ахиулж, ач холбогдлыг нэмэгдүүлэн ажилласан судалгааны багийн гишүүдэд талархал илэрхийлж, цаашдын эрдэм судлалын ажилд нь амжилт хүсье.

Эрдэм номын цагаан буян түгэн дэлгэрэх болтугай.

П.БАТБААТАР

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ХУУЛЬ ЗҮЙН ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ТОВЧИЛСОН ҮГ

АТГ	Авлигатай тэмцэх газар
АТХХАБАЖЗГХ	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг
БГХ	Бүртгэсэн гэмт хэрэг
ГХМБТГ	Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар
МУГХУСАЗЗ	Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕЭЗК	Европын эдийн засгийн комисс
МХХ	Монголын хуульчдын холбоо
МША	Мөрдөн шалгах ажиллагаа
НААСЭГХ	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
НТАХЯ	Нийтэд тустай ажил хийлгэх ял
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОНАБАСЭГХ	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАБТХАЖЭГХ	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
ХБОЭГХ	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг
ХБМБ	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт
ХБЭЧХБЭГХ	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХТАБЭТЭГХ	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг
ХХУТЭЭЧЭГХ	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг
ХХЧБЭЭГХ	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг
ХЭМХБЭГХ	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦМАБЭГХ	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
SDG	Sustainable Development Goals
UNODC	United Nations Office on Drug and Crime

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЦАГДАА - POLICE

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
3. ГЭМТ ХЭРЭГ
4. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА
5. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭЛТ
6. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ХЭРЭГ
7. ЭРҮҮЛЖҮҮЛСЭН ХҮН
8. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ





МОНГОЛ УЛСАД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ (2021)

УЛСЫН ХЭМЖЭЭНД

25429 +10.3%




8880 +5.5%
ОРОН НУТАГТ


16534 +13.0%
НИЙСЛЭЛД



ГЭМТ ХЭРГИЙН БҮТЭЦ



АНГИЛАЛ



ЗОНХИЛОХ ТӨРӨЛ



ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ШИНЖ



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧ (2021)

НИЙТ ХОЛБОГДСОН

18078 +8.5%

НИЙСЛЭЛД **10568** +12.5%

ОРОН НУТАГТ **7510** +3.1%

ХҮЙС



ЭРЭГТЭЙ


15151 +10.0%



ЭМЭГТЭЙ

2927 +0.6%

НИЙГМИЙН БАЙДАЛ



НАС

ЭЗЛЭХ ХУВЬ

1326	70+, 65-69, 60-64, 55-59	7.3%
5155	50-54, 45-49, 40-44, 35-39	28.5%
10676	30-34, 25-29	59.0%
921	18-24, 14-17	5.0%



БҮЛЭГЛЭН ҮЙЛДСЭН

2526 -9.8%



СОГТУУГААР


5331 +0.1%




МАНСУУРСАН

172 -27.1%

АЙМГУУДАД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ



ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭСЭН ГЭМТ ХЭРЭГ



1.Цагдаагийн байгууллагын танилцуулга

Монгол Улсын цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ биелүүлэхдээ нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар хэрэгжүүлж ирсэн.

Цагдаагийн байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж буй 90 гаруй хуульд тусгагдсан хэм хэмжээгээр үүрэг хүлээж ажилладаг ба гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон олон тооны захиргааны үүргийг хэрэгжүүлдэг.

“Монголын цагдаагийн байгууллага” гэсэн тогтолцоо бие дааж бүрэлдэн тогтох үйл явц 1990 оны 4 дүгээр сард НАХЯ-ыг татан буулгаж, УЦСЕГ-ыг төрийн захиргааны төв байгууллагын түвшинд байгуулснаар эхэлж, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатайгаар хөгжих болсон.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийг 1993 онд баталж, 1994 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр шинэ үеийн цагдаагийн байгууллагын үндэс суурь бүрэлдэн тогтсон бөгөөд нийгмийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулан, 2017 онд “Цагдаагийн албаны тухай хууль”-ийг баталсан билээ.

Цагдаагийн байгууллага нь Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Экологийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын алба, Тээврийн цагдаагийн алба, Интерполын үндэсний товчоо, Санхүү, аж ахуйн алба, Захиргааны удирдлагын газар, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас бүрдэнэ.

2.Гомдол, мэдээлэл.

Цагдаагийн байгууллага нь 2021 онд хүн, хуулийн этгээдээс 267.221 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 71.495 буюу 26.8% нь гэмт хэргийн шинжтэй, 195.726 буюу 73.2% нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл иржээ. Өмнөх онтой харьцуулбал гомдол, мэдээлэл 6864 буюу 2.6%-иар өссөн, гэмт хэргийн шинжтэй гомдол 3.948 буюу 5.8%-иар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2.916 буюу 1.5%-иар тус тус өссөн нь статистик мэдээнээс харагдаж байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 23.139 буюу 32.4%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 44.165 буюу 61.8%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 752 буюу 1.1%-ийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэжээ. Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 134.146 буюу 68.5%-ийг зөрчлийн хэрэг нээж, 58.601 буюу 29.9%-ийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 1.183 буюу 0.6%-ийг харьяаллын дагуу шилжүүлжээ[1].

Хүснэгт №1. Цагдаагийн байгууллагад ирүүлсэн дуудлага, мэдээллийг бүртгэсэн нэгжээр нь харуулав.

№	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага		Өмнөх үлдэгдэл гомдол, мэдээлэл	Үүнээс	Тухайн онд шинээр хүлээн авсан гомдол, мэдээлэл	Нийт шалгасан гомдол, мэдээлэл
				Шийдвэрлэсэн		
А			1	2	3	4
1	Баруун бүс	Баян-Өлгий	7	7	2920	2927
2		Говь-Алтай	14	14	1997	2011
3		Завхан	20	20	2191	2211
4		Үүнээс: Тосонцэнгэл	3	3	839	842
5		Увс	22	22	3431	3453
6		Ховд	38	38	3478	3516
7		Үүнээс : Булган	7	5	503	510

[1] Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны “Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2021”. Уб., 2022. 4 дэх тал.

8	Хангайн бүс	Архангай	18	18	2301	2319
9		Баянхонгор	50	50	4466	4516
10		Булган	31	31	3300	3331
11		Орхон	77	77	5337	5414
12		Өвөрхангай	38	38	5991	6029
13		Үүнээс: Хархорин	5	5	1300	1305
14		Хөвсгөл	31	31	4263	4294
15	Төвийн бүс	Говьсүмбэр	6	6	1398	1404
16		Дархан-Уул	42	42	4450	4492
17		Дорноговь	39	39	2648	2687
18		Үүнээс: Замын-Үүд	16	16	1175	1191
19		Дундговь	19	19	1740	1759
20		Өмнөговь	40	40	4359	4399
21		Үүнээс:Цогтцэций сум	19	17	1115	1134
22		Сэлэнгэ	46	46	3603	3649
23		Үүнээс: Мандал	18	18	1360	1378
24		Төв	24	24	4715	4739
25		Үүнээс: Заамар	3	3	1306	1309
26	Зүүн бүс	Дорнод	85	85	4717	4802
27		Сүхбаатар	31	31	3047	3078
28		Хэнтий	23	23	4267	4290
29		Үүнээс: Бор-Өндөр	10	7	832	842
30	Нийслэл		1387	1386	184024	185411
31	Баянгол		191	191	29057	29248
32	I хэлтэс		79	79	11692	11771
33	II хэлтэс		112	112	11301	11413
34	Баянзүрх				6064	6064
35	I хэлтэс		411	411	46677	47088
36	II хэлтэс		179	179	15315	15494
37	III хэлтэс		123	123	11654	11777
38	Сүхбаатар		109	109	10969	11078
39	I хэлтэс				8739	8739
40	II хэлтэс		164	163	23753	23917
41	Сонгинохайрхан		111	111	8285	8396
42	I хэлтэс		52	52	9065	9117
43	II хэлтэс				6405	6405
44	III хэлтэс		333	333	37358	37691
45	Хан-Уул		199	199	15155	15354
46	I хэлтэс		89	89	9659	9748
47	II хэлтэс		45	45	7066	7111
48	Чингэлтэй				5478	5478
49	I хэлтэс		56	56	22623	22679
50	II хэлтэс		33	33	9631	9664
51	Багануур		23	23	7749	7772
52	Багахангай				5243	5243
53	Налайх		169	169	19601	19770
54	ИАТ				24	24
55	Төмөр зам		2	2	284	286
56	Мөрдөн байцаах алба		8	8	347	355
57	Эрүүгийн цагдаагийн алба		18	18	499	517
58	Тээврийн цагдаагийн алба		60	60	4091	4151
59	Экологийн цагдаагийн алба				419	419

60	НЦУГ	ХГХМХ			30	30
61		ХОХГХТХ			89	89
62		Халаасны хулгай			67	67
63	Хар тамхитай тэмцэх газар		11	11	162	173
64	НХЖХ, ОНАБХА		4	4	375	379
65	Улсын дүн		2191	2190	265030	267221

Мөн ирүүлсэн дуудлага, мэдээллийг төрлөөр нь ангилан авч үзвэл хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 24218, хулгайлах 22883, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг 69147, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 40148 байна.

3.Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллага 2021 онд нийт **25429**, Улаанбаатар хотод **16534 буюу** 65.0.%, орон нутагт 8880 буюу 34.9%, бусад газар /хилийн чанадад үйлдсэн/ 15 буюу 0.1% гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

-Улсын хэмжээнд нийт 2365 хэрэг буюу 10.3 хувиар,

-Нийслэлийн хэмжээнд 1901 хэрэг буюу 13.0 хувиар,

-Орон нутгийн хэмжээнд 460 хэрэг буюу 5.5 хувиар,

-Бусад газар /хилийн чанадад/-т 4 хэрэг буюу 36.4 хувиар тус тус өссөн байна.

3.1.Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг)

Цагдаагийн байгууллага 2021 онд нийт 25429 гэмт хэргийг шинээр бүртгэсэн. Тэдгээрээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 448 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 1.8%-ийг эзэлж байна. Энэ бүлгийн гэмт хэрэг нь өмнөх оноос 66 буюу 17.3%-иар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 79.5%-тай байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад 27.6%-иар өсжээ.

3.1.1.Хүнийг алах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл)

Хүнийг алах гэмт хэрэг 2021 онд 194 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 2 буюу 1%-иар өсжээ. Улсын хэмжээнд нийт бүртгэсэн 25429 гэмт хэргийн 194 буюу 0.8%-ийг хүнийг алах гэмт хэрэг эзэлж байна. Харин нийслэлийн хэмжээнд хүнийг алах гэмт хэрэг 109 бүртгэсэн нь өмнөх оноос 14 хэргээр буюу 14.7%-иар өсөж, орон нутгийн хэмжээнд 85 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 12 хэргээр буюу 12.4%-иар буурчээ.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 27 буюу 13.9% нь Даваа гарагт, 24 буюу 12.4% нь Мягмар гарагт, 32 буюу 16.5% нь Лхагва гарагт, 25 буюу 12.9% нь Пүрэв гарагт, 28 буюу 14.4% нь Баасан гарагт, 28 буюу 14.4% нь Бямба гарагт, 30 буюу 15.5% нь Ням гарагт тус тус бүртгэсэн. Цагаар нь авч үзвэл, 32 буюу 16.5 % нь 06:00-14:00 цагт, 34 буюу 17.5 % нь 14:00-19:00 цагт, 36 буюу 18.6 % нь 19:00-22:00 цагт, 92 буюу 47.4 % нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг үйлдсэн газрыг авч үзвэл, бүртгэсэн гэмт хэргийн 123 буюу 63.4% нь гэр, орон сууцанд, 34 буюу 17.5% нь гудамж, талбайд, 4 буюу 2.1% нь тус бүр олон нийтийн газар, аж ахуйн нэгжид, 2 буюу 1.0% нь тус бүр төрийн байгууллага, төрийн бус байгууллага, авто замд, 23 буюу 11.9% нь бусад газарт үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Хүнийг алах гэмт хэргийн 146 буюу 75.3% нь согтуугаар, 3 буюу 1.5% нь хүүхэд оролцож, 20 буюу 10.3% нь эмэгтэй хүн оролцож, 5 буюу 2.6%-ийг бүлэглэн үйлджээ.

Гэмт хэргийн илрүүлэлт. Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 95.3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 97.1% байгаа нь 2.9 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 93.1% байгаа нь 2.7 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүн. Хүнийг алах гэмт хэрэгт нийт 201 хүнийг холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 9 буюу 4.3%-иар буурсан, холбогдогчдын 22 буюу 10.9% нь эмэгтэй, 179 буюу 89.1% нь эрэгтэй, 3 буюу 1.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 5.3%-иар буурч, хүүхэд 3.0 дахин, эмэгтэй хүн 4.8%-иар тус тус өсжээ.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 206 иргэн хохирсоноос 171 хүн нас барж, 29 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 10 буюу 5.1%-иар, гэмтсэн хүн 5 буюу 20.8%-иар тус тус өсөж, нас барсан хүн 19 буюу 10%-иар буурсан байна.

Учирсан хохирол. Энэ төрлийн гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 1042.8 сая төгрөгийн хохирлын 88.2%-ийг нөхөн төлүүлж, 46.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 244.5 сая төгрөг буюу 30.6%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 232.4 сая буюу 33.8%-иар өсөж, битүүмжилсэн хөрөнгө 112.4 сая төгрөг буюу 70.9%-иар буурсан байна.

3.2.Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг)

Цагдаагийн байгууллага 2021 онд нийт 25429 гэмт хэрэг шинээр бүртгэсэн бөгөөд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 7637 шинээр бүртгэсэн нь нийт хэргийн 30.0%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд өмнөх оноос 232 хэргээр буюу 3.1%-иар өсөж, нийслэлийн хэмжээнд 4551 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 13 хэргээр буюу 0.3%-иар буурч, орон нутагт 3085 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 247 хэргээр буюу 8.7%-иар өсжээ.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг үйлдсэн гарагаар нь авч үзвэл, 1067 буюу 14.0% нь Даваа гарагт, 1084 буюу 14.2% нь Мягмар гарагт, 1079 буюу 14.1% нь Лхагва гарагт, 1079 буюу 14.1% нь Пүрэв гарагт, 1170 буюу 15.3% нь Баасан гарагт, 1056 буюу 13.8% нь Бямба гарагт, 1102 буюу 14.4% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 1432 буюу 18.8% нь 06:00-14:00 цагт, 1825 буюу 23.9% нь 14:00-19:00 цагт, 1554 буюу 20.3% нь 19:00-22:00 цагт, 2826 буюу 37.0% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг үйлдсэн газрыг авч үзвэл, бүртгэсэн гэмт хэргийн 2022 буюу 26.5% нь гудамж, талбайд, 3878 буюу 50.8% нь гэр, орон сууцанд, 519 буюу 6.8% нь олон нийтийн газарт, 7 буюу 0.1% нь нийтийн тээвэрт, 45 буюу 0.6% нь төрийн байгууллагад, 26 буюу 0.3% нь төрийн бус байгууллагад, 264 буюу 3.5% нь аж ахуйн нэгжид, 6 буюу 0.1% нь авто замд, 870 буюу 11.3% нь бусад газарт үйлджээ.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэсэн хэргийн 3646 буюу 47.7% нь согтуугаар, 230 буюу 3.0% нь хүүхэд оролцож, 775 буюу 10.1% нь эмэгтэй хүн оролцож, 295 буюу 3.9%-ийг бүлэглэн, 1377 буюу 18.0% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдсэн байна

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Холбогдогчдын 764 буюу 10.9% нь эмэгтэй, 6235 буюу 89.1% нь эрэгтэй, 270 буюу 3.9% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 283 буюу 4.7%-иар, хүүхэд 20 буюу 8.0%-иар тус тус өсөж, эмэгтэй хүн 64 буюу 7.7%-иар буурсан байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 8072 иргэн хохирч, үүнээс 27 нь нас барж, 7299 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 274 буюу 3.5%-иар, гэмтсэн хүн 97 буюу 1.3%-иар, нас барсан хүн 8 буюу 42.1%-иар тус тус өссөн. Гэмтсэн иргэдийн гэмтлийн зэргээр нь авч үзвэл, 6324 буюу 86.6% нь хөнгөн, 615 буюу 8.5% нь хүндэвтэр, 360 буюу 4.9% нь хүнд зэргийн гэмтэл учирсан байна.

Учирсан хохирол. Хэргийн улмаас иргэнд учирсан 8963.1 сая төгрөгийн хохирлын 80.8%-ийг нөхөн төлүүлж, 484.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 1167.8 сая буюу 15.0%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 894.8 сая буюу 14.1%-иар, битүүмжилсэн хөрөнгө 59.9 сая буюу 14.1%-иар тус тус өссөн байна.

3.2.1.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг. (Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл)

2021 онд цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 118 шинээр бүртгэсэн нь нийт бүртгэсэн гэмт хэргийн 0.5%-ийг эзэлж, өмнөх оноос 7 хэргээр буюу 6.3%-иар өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 16 буюу 13.6% нь Даваа гарагт, 22 буюу 18.6% нь Мягмар гарагт, 20 буюу 16.9% нь Лхагва гарагт, 20 буюу 16.9% нь Пүрэв гарагт, 14 буюу 11.9% нь Баасан гарагт, 9 буюу 7.6% нь Бямба гарагт, 17 буюу 14.5% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 31 буюу 26.3% нь 06:00-14:00 цагт, 38 буюу 32.2% нь 14:00-19:00 цагт, 22 буюу 18.6% нь 19:00-22:00 цагт, 27 буюу 22.9% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэсэн газрыг авч үзвэл, гэмт хэргийн 105 буюу 89.0% нь гэр, орон сууцанд, 3 буюу 2.5% нь гудамж талбайд, 1 буюу 0.8% нь тус бүр олон нийтийн газарт, аж ахуйн нэгжид, 2 буюу 1.7% нь төрийн бус байгууллагад, 6 буюу 5.2% нь бусад газарт үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэсэн хэргийн 60 буюу 50.8% нь согтуугаар, 7 буюу 5.9% нь эмэгтэй хүн оролцож, 1 буюу 0.8%-ийг бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 91 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 10 буюу 12.3%-иар өссөн. Холбогдогчдын 88 буюу 96.7% нь эрэгтэй, 3 буюу 3.3% нь эмэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 11 буюу 14.3%-иар өсөж, эмэгтэй хүн 1 буюу 25.0%-иар буурсан байна.

Хохирсон хүн. Гэмт хэргийн улмаас 127 иргэн, хохирч үүнээс 57 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 15 буюу 13.4%-иар өсөж, гэмтсэн хүн 5 буюу 8.1%-иар буурч, энэ гэмт хэргийн улмаас 76.3 сая төгрөгний хохирол учирсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 53, хамтран амьдрагч 34, нөхөр 4, төрсөн хүүхэд 12, дагавар хүүхэд 4, төрсөн эцэг, эх 4, бусад 16 хүн байна.

График №1.Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчид



3.2.2.Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйл)

Цагдаагийн байгууллагад 2021 онд хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг 370 шинээр бүртгэсэн нь нийт хэргийн 1.5%-ийг эзэлж, өмнөх оноос 69 хэргээр буюу 22.9%-иар, нийслэлийн хэмжээнд 198 гэмт хэрэг өмнөх оноос 36 хэргээр буюу 22.2%-иар, орон нутагт 172 гэмт хэрэг өмнөх оноос 33 хэргээр 23.7%-иар тус тус өссөн байна.

3.2.3.Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйл)

Цагдаагийн байгууллага 2021 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэг 6453 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 25.4%-ийг дангаараа эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 80 хэргээр буюу 1.3%-иар өсчээ.

Нийслэлийн хэмжээнд хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг 3909 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 64 хэргээр буюу 1.6%-иар буурч, орон нутагт 2544 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 147 хэргээр буюу 6.1%-иар өссөн байна.

3.3.Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг)

Монгол Улсад 2021 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 540 шинээр бүртгэсэн нь нийт бүртгэсэн гэмт хэргийн 2.1%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд шинээр бүртгэсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оноос

35 хэргээр буюу 6.9%-иар, нийслэлийн хэмжээнд 269 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 14 хэргээр буюу 5.5%-иар, орон нутагт 271 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 22 хэргээр буюу 8.8%-иар тус тус өссөн, гэмт хэргийн илрүүлэлт 57.0% байна.

3.3.1.Хүчиндэх гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл)

Хүчиндэх гэмт хэрэг 439 буюу 81.3%, Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 16 буюу 3.0%-ийг эзэлж байна. 2020 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг 3.6%-ийг эзэлж байсан бол 2021 онд 3.0%-ийг эзлэх болсон.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 59 буюу 13.4% нь Даваа гарагт, 67 буюу 15.3% нь Мягмар гарагт, 67 буюу 15.3% нь Лхагва гарагт, 80 буюу 18.2% нь Пүрэв гарагт, 56 буюу 12.8% нь Баасан гарагт, 56 буюу 12.8% нь Бямба гарагт, 54 буюу 12.2% нь Ням гарагт тус тус үйлдсэн. Цагаар нь авч үзвэл, 88 буюу 20.0% нь 06:00-14:00 цагт, 95 буюу 21.6% нь 14:00-19:00 цагт, 51 буюу 11.6% нь 19:00-22:00 цагт, 205 буюу 46.8% нь 22:00-06:00 цагт тус тус үйлдсэн.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Хүчиндэх гэмт хэргийг үйлдсэн газрыг авч үзвэл, бүртгэсэн гэмт хэргийн 311 буюу 70.8% нь гэр, орон сууцанд, 33 буюу 7.5% нь гудамж талбайд, 17 буюу 3.9% нь олон нийтийн газарт, 6 буюу 1.4% нь аж ахуйн нэгжид, 4 буюу 0.9% нь төрийн бус байгууллагад, 1 буюу 0.2% нь тус бүр нийтийн тээвэрт, төрийн байгууллагад, 66 буюу 15.1% нь бусад газарт үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэсэн хүчиндэх гэмт хэргийн 130 буюу 29.6% нь согтуугаар, 19 буюу 4.3% нь хүүхэд оролцож, 7 буюу 1.6% нь эмэгтэй хүн оролцож, 110 буюу 25.1% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 21 буюу 4.8% нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Хүчиндэх гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 54.5% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.9 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 48.9% байгаа нь 1.1 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 63.6% байгаа нь 0.2 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Хүчиндэх гэмт хэрэгт нийт 335 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 41 буюу 13.9%-иар өссөн. Холбогдогчдын 6 буюу 1.8% нь эмэгтэй, 329 буюу 98.2% нь эрэгтэй, 24 буюу 7.2% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 12.3%-иар, эмэгтэй хүн 6.0 дахин, хүүхэд 4 буюу 20.0%-иар тус тус өссөн байна

Хохирогч. Хүчиндэх гэмт хэргийн улмаас 458 иргэн хохирч, үүнээс 51 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс хохирсон хүн 52 буюу 12.8%-иар өсөж, гэмтсэн хүн 1 буюу 1.9%-иар буурсан.

Хохирсон иргэдийн 278 буюу 60.7% нь 17 хүртэлх насны хүүхэд байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон 10 хүний 6 нь хүүхэд байна гэсэн үг юм. Хохирсон хүүхдийг насаар нь авч үзвэл 18 буюу 6.4% нь 7 хүртэлх, 130 буюу 46.8% нь 8-13 насны, 130 буюу 46.8% нь 14-17 насны хүүхэд байна.

3.4.Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг)

2021 онд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 210 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.8%-ийг эзэлж байна.

Улсын хэмжээнд энэ төрлийн 210 гэмт хэрэг, нийслэлд 139 бүртгэсэн нь өмнөх оныхтой харьцуулахад, 9 гэмт хэрэг буюу 6.9%-иар, Орон нутагт 71 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оныхоос 12 хэргээр буюу 20.3%-иар тус тус өсжээ.

3.5.Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 14 дүгээр бүлэг)

2021 онд 2 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 3 хэргээр буюу 60.0%-иар буурч, Нийслэлийн хэмжээнд бүртгэгдээгүй байна.

3.6.Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлэг)

2021 онд 28 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 6 хэргээр буюу 27.3%-иар, нийслэлийн хэмжээнд 20 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 4 хэргээр буюу 25.0%-иар, орон нутагт 8 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оныхоос 2 хэргээр буюу 33.3%-иар тус тус өссөн байна.

3.7.Хүүхдийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэг) 2021 онд хүүхдийн эсрэг 31 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 14 хэргээр буюу 82.4%-иар, нийслэлийн хэмжээнд 27 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 14 хэргээр буюу 2.0 дахин тус тус өсөж, орон нутагт 4 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Энэ төрлийн гэмт хэргээс Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйл “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах” 16 (51.6%), 16.3 дугаар зүйл “Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх” 5 (16.1%), гэмт хэрэг бүртгэсэн нь нийт бүртгэсэн энэ бүлгийн гэмт хэргийн 67.7%-ийг эзэлж байна.

3.8.Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэг)

Цагдаагийн байгууллагад 2021 онд өмчлөх эрхийн эсрэг 13632 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь нийт хэргийн 53.6%-ийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 1571 хэргээр буюу 13.0%-иар, нийслэлийн хэмжээнд 9785 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 1430 хэргээр буюу 17.1%-иар, орон нутагт шинээр 3834 бүртгэсэн нь өмнөх оноос 131 хэргээр буюу 3.5%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3.8.1.Хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл)

Цагдаагийн байгууллагад 2021 онд Хулгайлах гэмт хэрэг 4579 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 18.0%-ийг эзэлж, өмнөх оноос 521 хэргээр буюу 10.2%-иар, нийслэлийн хэмжээнд 3283 бүртгэсэн нь өмнөх оноос 198 хэргээр буюу 5.7%-иар, орон нутагт 1296 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 323 хэргээр буюу 20.0%-иар тус тус буурсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 685 буюу 15.0% нь Даваа гарагт, 667 буюу 14.6% нь Мягмар гарагт, 691 буюу 15.1% нь Лхагва гарагт, 695 буюу 15.2% нь Пүрэв гарагт, 675 буюу 14.7% нь Баасан гарагт, 598 буюу 13.1% нь Бямба гарагт, 568 буюу 12.3 нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 1186 буюу 25.9% нь 06:00-14:00 цагт, 1351 буюу 29.5% нь 14:00-19:00 цагт, 570 буюу 12.4% нь 19:0`0-22:00 цагт, 1472 буюу 32.2% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг үйлдсэн газрыг авч үзвэл, үйлдсэн гэмт хэргийн 1824 буюу 39.8% нь гэр, орон сууцанд, 958 буюу 20.9% нь гудамж талбайд, 675 буюу 14.7% нь олон нийтийн газарт, 450 буюу 9.8% нь аж ахуйн нэгжид, 3 буюу 0.1% нь авто замд, 669 буюу 14.7% нь бусад газарт үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэсэн хэргийн 330 буюу 7.2% нь согтуугаар, 257 буюу 5.6% нь хүүхэд оролцож, 251 буюу 5.5% нь эмэгтэй хүн оролцож, 337 буюу 7.4% нь бүлэглэн үйлдсэн байна

Гэмт хэргийн илрүүлэлт. Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 35.7% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.7 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 32.9% байгаа нь 0.5 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 43.6% байгаа нь 3.4 нэгжээр тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүн. Нийт 2301 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 520 буюу 18.4%-иар буурсан. Холбогдогчдын 234 буюу 10.2% нь эмэгтэй, 2067 буюу 89.8% нь эрэгтэй, тэдний 379 буюу 16.5% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй 19.6%-иар, эмэгтэй 6.8%-иар, хүүхэд 21.0%-иар тус тус буурсан байна.

Хохирсон хүн, хуулийн этгээд. Гэмт хэргийн улмаас 4569 иргэн, 10 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 572 буюу 11.1%-иар, хуулийн этгээд 2 буюу 25.0%-иар тус тус өссөн. Хүн, хуулийн этгээдэд учирсан 11074.1 сая төгрөгийн хохирлын 35.0%-ийг нөхөн төлүүлж, 208.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс 54.7 сая төгрөг буюу 0.5%-иар, битүүмжилсэн хөрөнгө 142.8 сая төгрөг буюу 40.7%-иар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 533.5 сая буюу 15.9%-иар өссөн байна.

3.8.1.1.Мал хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл)

Энэ төрлийн гэмт хэргийг цагдаагийн байгууллага 736 бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 2.9 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 305 хэргээр буюу 29.3%-иар, нийслэлийн хэмжээнд 42 бүртгэсэн нь 21 хэргээр буюу 33.3%-иар, орон нутгийн хэмжээнд 694 бүртгэсэн нь 284 хэргээр буюу 29.0%-иар тус тус буурсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 96 буюу 13.0% нь Даваа гарагт, 118 буюу 16.0% нь Мягмар гарагт, 128 буюу 17.4% нь Лхагва гарагт, 101 буюу 13.7 % нь Пүрэв гарагт, 114 буюу 15.5% нь Баасан гарагт, 80 буюу 10.9% нь Бямба гарагт, 99 буюу 13.5% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 116 буюу 15.8% нь 06:00-14:00 цагт, 137 буюу 18.6% нь 14:00-19:00 цагт, 119 буюу 16.2% нь 19:00-22:00 цагт, 364 буюу 49.4% нь 22:00-06:00 цагт тус тус үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэсэн хэргийн 27 буюу 3.7% нь согтуугаар, 12 буюу 1.6% нь хүүхэд оролцож, 6 буюу 0.8% нь эмэгтэй хүн оролцож, 151 буюу 20.5% нь бүлэглэн, 422 буюу 57.3% нь тээврийн хэрэгсэл ашиглаж тус тус үйлдсэн байна

Гэмт хэргийн илрүүлэлт. Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 61.0% байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.7 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 20.0% байгаа нь 3.6 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 63.8% байгаа нь 13.2 нэгжээр тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 702 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 231 буюу 24.8%-иар буурсан. Холбогдогчдын 9 буюу 1.3% нь эмэгтэй, 693 буюу 98.7% нь эрэгтэй, 19 буюу 2.7% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 24.2%-иар, эмэгтэй хүн 47.1%-иар тус тус буурч, хүүхэд 90.0%-иар өссөн байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 755 иргэн, 1 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 299 буюу 28.4%-иар буурсан.

Учирсан хохирол. Хэргийн улмаас иргэдэд учирсан 3766.4 сая төгрөгийн хохирлын 51.3%-ийг нөхөн төлүүлж, 318.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 624.5 сая төгрөгөөр буюу 14.2%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 64.6 сая төгрөг буюу 3.2%-иар, битүүмжилсэн хөрөнгө 302.1 сая буюу 48.7%-иар тус тус буурсан байна.

Алдагдсан малын тоо. Адуу 2362, Үхэр 1654, Тэмээ 77, Ямаа 2117, Хонь 6647 байна.

3.8.2. Залилах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйл)

Энэ төрлийн гэмт хэргийг 2021 онд цагдаагийн байгууллага 6558 бүртгэсэн нь өмнөх оноос 2288 хэргээр буюу 53.6%-иар, нийслэлийн хэмжээнд 5240 гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 1619 буюу 44.7%-иар, орон нутагт 1306 гэмт хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 660 хэргээр буюу 2.0 дахин тус тус өссөн байна. Залилах гэмт хэрэг 6558 бүртгэсэн нь нийт бүртгэсэн гэмт хэргийн 25.8%-ийг эзэлж байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 1088 буюу 16.6% нь Даваа гарагт, 1118 буюу 17.0% нь Мягмар гарагт, 1035 буюу 15.8% нь Лхагва гарагт, 982 буюу 15.0% нь Пүрэв гарагт, 953 буюу 14.5% нь Баасан гарагт, 713 буюу 10.9% нь Бямба гарагт, 669 буюу 10.2% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 2847 буюу 43.4% нь 06:00-14:00 цагт, 2627 буюу 40.1% нь 14:00-19:00 цагт, 628 буюу 9.6% нь 19:00-22:00 цагт, 456 буюу 6.9% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг үйлдсэн газрыг авч үзвэл, бүртгэсэн гэмт хэргийн 2710 буюу 41.3% нь гэр, орон сууцанд, 805 буюу 12.3% нь гудамж талбайд, 508 буюу 7.7% нь олон нийтийн газарт, 716 буюу 10.9% нь аж ахуйн нэгжид, 1819 буюу 27.8% нь бусад газарт үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал. Нийт бүртгэсэн хэргийн 16 буюу 0.2% нь согтуугаар, 117 буюу 1.8% нь хүүхэд оролцож, 1527 буюу 23.3% нь эмэгтэй хүн оролцож, 184 буюу 2.8% нь бүлэглэн үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 48.5% байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.7 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 50.1% байгаа нь 8.3 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 41.8% байгаа нь 6.4 нэгжээр тус тус өссөн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 4007 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 1738 буюу 77.0%-иар өссөн. Холбогдогчдын 1355 буюу 33.8% нь эмэгтэй, 2652 буюу 66.2% нь эрэгтэй, тэдний 117 буюу 2.9% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эмэгтэй хүн 6.1 %-иар, эрэгтэй хүн 2.6 дахин, хүүхэд 69.6%-иар тус тус өссөн байна.

Хохирогч. Гэмт хэргийн улмаас 6523 иргэн, 9 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 2250 буюу 52.7%-иар, хуулийн этгээд 5 буюу 2.2 дахин тус тус өссөн.

Учирсан хохирол. Иргэн, хуулийн этгээдэд учирсан 104522.6 сая төгрөгийн хохирлын 43.0%-ийг нөхөн төлүүлж, 3004.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 38775.2 сая буюу 59.0%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 19756.3 сая буюу 78.5%-иар, битүүмжилсэн хөрөнгө 1568.7 сая буюу 2.0 дахин тус тус өссөн байна.

3.9.Эдийн засгийн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэг)

Цагдаагийн байгууллага 2021 онд 158 эдийн засгийн гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 35 хэргээр буюу 28.5%-иар өсөж, орон нутагт 28 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 25 хэргээр буюу 47.2%-иар буурч, харин нийслэлд 130 хэрэг бүртгэсэн нь өмнөх оноос 60 хэргээр буюу 85.7%-иар өссөн байна.

3.10.Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 19 дүгээр бүлэг)

2021 онд үндэсний аюулгүй байдлын эсрэг 2 гэмт хэрэг шинээр бүртгэсэн өмнөх оноос 1 нэгжээр буюу 2.0 дахин өссөн байна.

3.11.Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг)

2021 онд энэ бүлэгт заасан 756 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 3.0%-ийг эзэлж, өмнөх оноос 465 хэргээр буюу 2.6 дахин, нийслэлд 534 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 297 хэргээр буюу 2.3 дахин, орон нутагт 222 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 169 хэргээр буюу 4.2 дахин тус тус өссөн байна.

3.11.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйл)

2021 онд цагдаагийн байгууллага нийт 25429 гэмт хэрэг бүртгэсэн бөгөөд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 187 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт хэргийн 0.7%-ийг эзэлж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд 187 бүртгэсэн нь өмнөх оны мөн үеэс 15 гэмт хэргээр буюу 7.4 хувиар, нийслэлийн хэмжээнд 145 бүртгэсэн нь 33 гэмт хэргээр буюу 18.5 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 42 бүртгэсэн нь 18 гэмт хэргээр буюу 75.0%-иар өссөн байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл 37 буюу 19.8% нь Даваа гарагт, 34 буюу 18.2% нь Мягмар гарагт, 25 буюу 13.4% нь Лхагва гарагт, 32 буюу 17.1% нь Пүрэв гарагт, 36 буюу 19.3% нь Баасан гарагт, 12 буюу 6.4% нь Бямба гарагт, 11 буюу 5.8% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 44 буюу 23.5% нь 06:00-14:00 цагт, 49 буюу 26.2% нь 14:00-19:00 цагт, 35 буюу 18.7% нь 19:00-22:00 цагт, 59 буюу 31.6% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэсэн газрыг авч үзвэл, үйлдсэн гэмт хэргийн 75 буюу 40.1% нь гэр, орон сууцанд, 45 буюу 24.1% нь гудамж талбайд, 11 буюу 5.9% нь олон нийтийн газарт, 1 буюу 0.5% нь нийтийн тээвэрт, 2 буюу 1.1% нь төрийн байгууллагад, 3 буюу

1.6% нь төрийн бус байгууллагад, 1 буюу 0.5% нь аж ахуйн нэгжид, 4 буюу 2.1% нь автозамд, 45 буюу 24.1% нь бусад газарт үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэсэн хэргийн 2 буюу 1.1% нь согтуугаар, 7 буюу 3.7% нь хүүхэд оролцож, 9 буюу 4.8% нь эмэгтэй хүн оролцож, 28 буюу 15.0% нь бүлэглэн үйлдсэн.

Гэмт хэргийн илрүүлэлт. Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 75.2% байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.8 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 72.7% байгаа нь 8.5 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 83.3% байгаа нь 5.6 нэгжээр тус тус буурсан байна

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 210 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 59 буюу 21.9%-иар буурсан. Холбогдогчдын 13 буюу 6.2% нь эмэгтэй, 197 буюу 93.8% нь эрэгтэй, 7 буюу 3.3% нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 22.4%-иар, эмэгтэй хүн 13.3%-иар, хүүхэд 53.3%-иар тус тус буурсан байна.

2021 онд эд мөрийн баримтаар хураж авсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээг өмнөх онтой харьцуулахад “каннабис” – 26.579.22 грамм буюу 48.5 хувиар, “LSD” 79 ширхгээр, морфин - 79 ширхгээр, 259.6 граммаар, DXM – 122.3 граммаар тус тус өссөн бол “мөс” – 136.79 грамм буюу 8.3 хувиар, “гашиш” – 456.65 грамм буюу 65.8 хувиар, трамадол – 9 ширхэг буюу 27.3 хувиар, аппаурин - 5 ширхэг буюу 33 хувиар, алпразолам – 30 ширхгээр тус тус буурсан байна.

3.12.Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг)

Цагдаагийн байгууллагад бүртгэсэн 25429 гэмт хэргээс Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг 52 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.2%-ийг эзэлж байна.

Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүлэгт заасан гэмт хэрэг улсын хэмжээнд 52 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 28 хэргээр буюу 35.0%-иар, нийслэлд 34 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 16 хэргээр буюу 32.0%-иар, орон нутагт 18 шинээр бүртгэсэн нь өмнөх оныхоос 12 хэргээр буюу 40.0%-иар тус тус буурсан байна.

3.13.Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэг)

Цагдаагийн байгууллага 2021 онд Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг 232 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.9%-ийг эзэлж байна. Өмнөх оноос 21 хэргээр буюу 10.0%-иар, нийслэлийн хэмжээнд 136 хэрэг шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 12 хэргээр буюу 9.7%-иар, орон нутагт 95 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оноос 10 хэргээр буюу 11.8%-иар тус тус өссөн үзүүлэлтэй байна.

3.14.Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг)

Цагдаагийн байгууллага 2021 онд Хүрээлэн байгаа орчны эсрэг 601 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 2.4%-ийг эзэлж байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 601 шинээр бүртгэсэн нь өмнөх онтой харьцуулахад, 21 гэмт хэргээр буюу 3.4%-иар, орон нутагт 549 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 21 хэргээр буюу 3.7%-иар тус тус буурч, нийслэлд 52 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 84 буюу 14.0% нь Даваа гарагт, 85 буюу 14.1% нь Мягмар гарагт, 97 буюу 16.1% нь Лхагва гарагт, 105 буюу 17.5% нь Пүрэв гарагт, 80 буюу 13.3% нь Баасан гарагт, 75 буюу 12.5% нь Бямба гарагт, 75 буюу 12.5% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 193 буюу 32.1% нь 06:00-14:00 цагт, 255 буюу 42.4% нь 14:00-19:00 цагт, 79 буюу 13.1% нь 19:00-22:00 цагт, 74 буюу 12.4% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Гэмт хэрэг бүртгэсэн газрыг авч үзвэл, 251 буюу 41.8% нь ойн сан бүхий газар, 48 буюу 7.8% нь хууль бусаар алт олборлож байгаа газар, 124 буюу 20.6%

нь хөдөө хээр, 24 буюу 4.0% нь гол, усны ай сав газар, 10 буюу 1.7% нь аж ахуйн нэгжид, 144 буюу 24.1% нь бусад газарт үйлдсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэсэн хэргийн 3 буюу 0.5% нь согтуугаар, 23 буюу 3.8% нь эмэгтэй хүн оролцож, 101 буюу 16.8% нь бүлэглэн, 17 буюу 2.8% нь галт зэвсэгээр тус тус үйлдсэн байна.

Гэмт хэргийн илрүүлэлт. Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 58.9% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.3 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 60.8% байгаа нь 3.3 нэгжээр тус тус өсөж, нийслэлийн хэмжээнд 43.8 % байгаа нь 14.7 нэгжээр буурсан байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Нийт 570 хүн гэмт хэрэгт холбон шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 10 буюу 1.7%-иар буурсан. Холбогдогчдын 27 буюу 4.7% нь эмэгтэй 543 буюу 95.3% нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй 1.5%-иар, эмэгтэй 6.9%-иар тус тус буурсан байна.

Хохирсон хүн, хуулийн этгээд. Гэмт хэргийн улмаас 536 иргэн, 7 хуулийн этгээд хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 29 буюу 5.7%-иар, хуулийн этгээд 11 буюу 61.1%-иар тус тус буурсан.

Учирсан хохирол. Иргэн, хуулийн этгээдэд учирсан 5398.2 сая төгрөгийн хохирлын 38.8%-ийг нөхөн төлүүлж, 1066.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 2288.9 сая төгрөг буюу 73.6%-иар, нөхөн төлүүлсэн хохирол 289.9 сая буюу 16.1%-иар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 77.5 сая төгрөг буюу 6.8%-иар буурсан байна.

3.15.1.Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйл)

Цагдаагийн байгууллага 2021 онд нийт 25429 гэмт хэрэг бүртгэснээс Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг нийт гэмт хэргийн 0.69%-ийг эзэлж байна.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг улсын хэмжээнд 177 шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 48 хэргээр буюу 21.5%-иар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 39.0%-тай байна.

3.16.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг)

Цагдаагийн байгууллага бүртгэсэн нийт 25429 хэргээс соёлын өвийн эсрэг 8 гэмт хэрэг бүртгэсэн нь нийт гэмт хэргийн 0.03%-ийг эзэлж байна.

Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг 2021 онд 8 бүртгэсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 хэргээр буюу 60.0%-иар, нийслэлийн хэмжээнд 4 хэрэг шинээр бүртгэсэн нь 3 хэргээр буюу 4.0 дахин тус тус өсөж, орон нутагт 4 гэмт хэрэг бүртгэсэн өмнөх онтой мөн адил түвшинд байна. Энэ бүлэгт заасан гэмт хэргүүдэд холбогдуулан шалгасан этгээдүүд нь 29-34 насныхан байна.

3.17.Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг)

Цагдаагийн байгууллага 2021 онд Цахим орчинд үйлдэгдсэн 151 гэмт хэрэг бүртгэсэн. Бүртгэсэн гэмт хэргийн 133 буюу 88.1 хувь нь Улаанбаатар хотод, 18 буюу 11.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Өмнөх оноос 5 хэргээр буюу 3.4 хувиар өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Хэргийг гарагаар нь авч үзвэл, 30 буюу 19.9% нь Даваа гарагт, 25 буюу 16.5% нь Мягмар гарагт, 26 буюу 17.2% нь Лхагва гарагт, 26 буюу 17.2% нь Пүрэв гарагт, 22 буюу 14.6% нь Баасан гарагт, 13 буюу 8.6% нь Бямба гарагт, 9 буюу 6.0 % нь Ням гарагт үйлджээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл, 58 буюу 38.4% нь 06-14 цагийн хооронд, 39 буюу 25.8% нь 14-19 цагийн хооронд, 14 буюу 9.3% нь 19-22 цагийн хооронд, 40 буюу 26.5% нь 22-06 цагийн хооронд үйлдэж байна.

Гэмт хэрэг үйлдсэн газар. Энэ төрлийн гэмт хэргийн 64 буюу 42.4% нь гэр орон сууцанд, 2 буюу 1.3% нь гудамж талбайд, 2 буюу 2.0% нь төрийн байгууллагад, 1 буюу 0.7% нь тус бүр аж ахуйн нэгжид, олон нийтийн газарт, төрийн бус байгууллагад, 79 буюу 52.3% нь бусад газарт тус тус бүртгэсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэсэн хэргийн 10 буюу 6.6% нь хүүхэд оролцож, 2 буюу 1.3% нь эмэгтэй хүн оролцож үйлдсэн байна.

Гэмт хэрэгт холбон шалгасан хүн. Энэ төрлийн гэмт хэрэг 1 иргэн 2 ба түүнээс дээш тооны гэмт хэрэгт холбогдон шалгагдах нь түгээмэл байдаг бөгөөд 2 ба түүнээс дээш тооны гэмт хэрэгт шалгагдсан 76 иргэн байна.

Хохирсон хүн. Гэмт хэргийн улмаас 140 хүн хохирсны 69 буюу 49.3% нь эрэгтэй, 71 буюу 50.7% нь эмэгтэй хүн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт хохирогч 27 буюу 23.9%-иар, эрэгтэй хүн 6 буюу 9.5%-иар, эмэгтэй хүн 21 буюу 42.0%-иар тус тус өссөн байна.

3.18.Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг (Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлэг)

2021 онд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 915 гэмт хэрэг бүртгэсэн нь улсын хэмжээнд бүртгэсэн нийт гэмт хэргийн 3.6%-ийг эзэлж байна.

Шинээр бүртгэсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад, 70 хэргээр буюу 7.1%-иар, орон нутагт 472 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 82 хэргээр буюу 14.8%-иар тус тус буурч, нийслэлийн хэмжээнд 443 хэрэг шинээр бүртгэсэн нь өмнөх оноос 12 хэргээр буюу 2.8%-иар өссөн байна.

Гэмт хэрэг үйлдсэн цаг, гараг. Гэмт хэрэг бүртгэсэн гарагаар нь авч үзвэл, 129 буюу 14.1% нь Даваа гарагт, 123 буюу 13.4% нь Мягмар гарагт, 128 буюу 14.0% нь Лхагва гарагт, 143 буюу 15.6% нь Пүрэв гарагт, 135 буюу 14.8% нь Баасан гарагт, 132 буюу 14.4% нь Бямба гарагт, 125 буюу 13.7% нь Ням гарагт тус тус бүртгэсэн бол цагаар нь авч үзвэл, 246 буюу 26.9% нь 06:00-14:00 цагт, 264 буюу 28.9% нь 14:00-19:00 цагт, 189 буюу 20.7% нь 19:00-22:00 цагт, 216 буюу 23.5% нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар. Гэмт хэргийн 398 буюу 43.5% нь орон нутгийн замд, 447 буюу 48.9% нь хотын замд, 5 буюу 0.5% нь аж ахуйн нэгжийн замд, 27 буюу 3.0% нь бусад газарт үйлдсэн байна

Гэмт хэрэг үйлдсэн байдал. Нийт бүртгэсэн хэргийн 209 буюу 22.8% нь согтуугаар, 104 буюу 11.4% нь эмэгтэй хүн оролцож, 17 буюу 1.9% нь хүүхэд оролцож үйлдсэн байна.

3.18.1.Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйл)

Боловсролын хувьд гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 46.8% нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна.

Явган зорчигчийн буруугаас шалтгаалсан осол:

- Явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах
- Гэрлэн дохио зөрчиж зам хөндлөн гарах
- Ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх
- Зогсож буй автомашины урдуур буюу автобуснаас буугаад урдуур нь замын зорчих хэсэгт орох
- Замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн захаар дагаж явах согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорчих хэсэг дээгүүр явах, хэвтэх
- Замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шургах
- Замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй оролцох/зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, чихэвчний хөгжим сонсох, мессеж бичих/
- Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах /эцэг эх, асран хамгаалагчийн буруугаас автомашинд дайрагдах, мөргүүлэх хэлбэрээр хохирох тохиолдол бүртгэгдсээр байна.

График 9. Явган зорчигчийн бууутай үйлдлээс шалтгаалсан осол




Явган зорчигчийн бууутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 2021 онд улсын хэмжээнд 442 буюу нийт бүртгэгдсэн ослын 2%-ийг эзэлж байна. Явган зорчигчийн бууутай үйлдлээс шалтгаалсан 442 ослын 379 буюу 85.7% нь нийслэлд, 63 буюу 14.3% нь орон нутагт бүртгэгдсэн. Нийт явган зорчигчийн бууутай үйлдэл дотроо явган зорчигч замын хөдөлгөөнд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ, биеэ авч явах чадваргүй байдлаар оролцсон нь 36.9%, сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулсан 8.8%-ийг тус тус эзэлж байна.

Явган зорчигчид зориулсан зам, замын байгууламж нь стандартын дагуу хийгддэггүй, түүнд тавих хяналт байхгүй, мөн явган зорчигчдын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг хүсдэггүй, тэдэнд оногдуулах хууль сахиулах байгууллагаас тавих хяналт байхгүй, гаргасан зөрчилд хариуцлага хүлээлгэх механизм

хэрэгжихгүй байгаагаас явган зорчигч амь насаа алдах, гэмтэл авч хохирч байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол өнгөрсөн оны үзүүлэлтээс буурсан хэдий ч замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөх, хохирох үзүүлэлт буурахгүй байна.

График 10. Явган зорчигч зам тээврийн осолд өртсөн шалтгаан



Явган зорчигч нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцож хохирсон 163 осол бүртгэгдсэний 137 буюу 84.0% нь нийслэлд, 26 буюу 16.0% нь орон нутагт бүртгэгдсэн.

Сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулснаас нийслэлд 27, орон нутагт 12, нийт 39 зам тээврийн осол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 33.9%-иар буурсан байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол өнгөрсөн оны үзүүлэлтээс буурсан хэдий ч замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөх, хохирох явдал буурахгүй байна. Тэд замын сүлжээг аюулгүй ашиглахад төлөвшөөгүй байдаг. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны /КАРЕК/ улс орнуудын өнөөгийн авто замуудад судалгаа хийж үзэхэд явган зорчигчийн тав тух, аюулгүй байдалтай холбоотой дараах олон асуудлууд байна. Үүнд:

- Явган зорчигчийн (цагаан зураастай) гарцтай боловч жолооч нар түүнийг үл тоодог;
- Өргөн (олон эгнээтэй), өндөр хурдны авто зам дээр цагаан зураастай гарцуудыг олноор гаргасан;
- Явган зорчигчийн хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио, явган зорчигчийн гарцыг тэмдэглэлгүй уулзварын гэрлэн дохио;
- Гэрлэн дохионы асах хугацаа нь явган зорчигч зам гарахад хангалтгүй;
- Хөдөлгөөн ихтэй замын дагуу явган зорчигчдын удирдлагатай гэрлэн дохио хангалтгүй;
- Бусад хэлбэрийн гарц зам ашиглагчдад илүү таатай байхаар хэсэгт явган зорчигчийн гүүрэн болон доогуур гарц бариагүй;
- "Аюулгүй систем"-ийн зарчимд нийцээгүй хурдны хязгаарлалт;
- Суурин газрын дундуур өнгөрөх гол замын хурдны удирдлага зохицуулалт, "хөдөлгөөн сааруулах" зохицуулалт хангалтгүй;
- Орон нутгийн замд хурдыг зохицуулах, багасгах үйл ажиллагаа хангалтгүй;
- Явган зорчигчдын аюулгүйн арал, явган зорчигчийн налуу зам, хашлага, хажуугийн өргөтгөлүүд дутагдалтай;
- Явган зорчигчийн байгууламжийн засвар үйлчилгээ хангалтгүй (зурвас хуучирч бүдгэрсэн, тэмдэг байхгүй, гэрлэн дохио эвдэрсэн).

Явган зорчигчид бол замын хөдөлгөөнд оролцогчдын хамгийн том бүлэг бөгөөд өдөр, шөнийн аль ч цагт замын сүлжээнд явган зорчигчид тааралдаж болно. Явган зорчигч нь мөн зам ашиглагчдын хамгийн эмзэг бүлэгт тооцогддог. Ийм ч учраас авто замын осолд хамгийн хүнд гэмтэл авдаг. Явган зорчигч нь хууль ёсны замын хөдөлгөөнд оролцогчдын нэг юм. Тэдэнд зам дагуу явах, зам хөндлөн гарахад ээлтэй орчин хэрэгтэй[2].

[2] Карекийн замын хөдөлгөөний аюулгүй байдал инженерчлэлийн гарын авлага.(2020).Явган зорчигчийн аюулгүй байдал.4-р тал.

Улсын хэмжээнд 2021 онд хүүхэд өртсөн зам тээврийн осол 463 бүртгэгдсэний 240 буюу 51.8% нь нийслэлд, 223 буюу 48.2% нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Зам тээврийн ослын улмаас 51 хүүхэд нас барж, 485 хүүхэд гэмтэл авсны 114 хүүхэд нь хүнд, хүндэвтэр гэмтэл авчээ. Зам тээврийн ослын улмаас нас барсан 383 хүний 51 буюу 13.3%-ийг хүүхдийн нас баралт эзэлж байгаа бол нийт гэмтсэн хүний 19.6%-ийг хүүхдийн гэмтэл эзэлж байна.

Хүснэгт 42. Хүүхэд зам тээврийн осолд өртсөн хэлбэр

Д/д	Үзүүлэлт	Явган зорчигч	Зорчигч	Дугуйгаар зорчигч	Бусад
1	Улсын хэмжээнд	272	203	41	20
	Эзлэх хувь	50.7	37.9	7.6	3.7
2	Нийслэлийн хэмжээнд	165	87	22	2
	Эзлэх хувь	59.8	31.5	8	0.7
3	Орон нутгийн хэмжээнд	107	116	19	18
	Эзлэх хувь	41.2	44.6	7.3	6.9

Хүснэгт 43. Хүүхэд өртсөн зам тээврийн осол

Зам тээврийн осол	Нийт хохирсон хүүхэд	Нас барсан хүүхэд	Гэмтсэн хүүхэд
Улсын хэмжээнд			
463	536	51	485
Нийслэлд			
240	276	11	265
Орон нутагт			
223	260	40	220

Хүснэгт 44. Хүүхэд зам тээврийн осолд өртсөн нутаг дэвсгэрээр

Аймаг, дүүрэг	Нас барсан хүүхдийн тоо			Гэмтсэн хүүхдийн тоо		
	2021	Өсөлт бууралт /тоогоор/	Өсөлт бууралт/ хувиар/	2021	Өсөлт бууралт/ тоогоор	Өсөлт бууралт/ хувиар
Архангай	6	4	3	3	-9	-75
Баян-Өлгий	3	-1	-25	9	-4	-30.8
Баянхонгор	1	-1	-50	7		
Булган	2	2		5	1	14.3
Говь-Алтай	2	1	2	5	1	25
Говьсүмбэр				3	1	50
Дархан-Уул	2	1	2	18	4	28.6
Дорноговь	4	3	4	7	-2	-22.2
Дорнод		-9		18	-11	-37.9
Дундговь	1	1		7	-3	-30
Завхан	1			8	7	8
Орхон		-1		11	-4	-26.7
Өвөрхангай		-6		8	0	0
Өмнөговь	2	1		6	-7	-53.8
Сүхбаатар		-3		7		0
Сэлэнгэ	2	-3	-60	2121	10	90.9
Төв	6	-3	-33.3	43	10	30.3
Увс	1	-1	-50	5	-1	-16.7
Ховд	2	-2	-50	11	8	3.6
Хөвсгөл	3			2	-2	3
Хэнтий	2			10		


Баянгол дүүрэг	2	2		26	-16	-38.1
Баянзүрх дүүрэг	1	1		69	-26	-27
Сүхбаатар дүүрэг		-1		27	-9	-25
Сонгинохайрхан дүүрэг	2			60	-16	-21.1
Хан-Уул дүүрэг	4	1	33.3	39	-15	-27.8
Чингэлтэй дүүрэг	1	1		31	3	10.7
Багануур дүүрэг	1	1		4	2	2
Багахангай дүүрэг				1		
Налайх дүүрэг				8	2	33.3
Улаанбаатар	11	5	83.3	263	-75	-22.1
Орон нутаг	40	-17	-29.8	220	-1	0.5
Улсын хэмжээнд	51	-12	-19	485	-76	-13.5

Хүүхэд өртсөн осол нь Улаанбаатарт их бүртгэгдсэн ч ослын улмаас амь эрсдсэн хүүхдийн 78.4% нь орон нутгийн замд бүртгэгдсэн байна. Зам тээврийн осолд өртсөн 536 хүүхдийн 51 буюу 9.5% нь амь эрсдэж, 114 буюу 21.3% нь хүнд, хүндэвтэр, 371 буюу 69.2% нь хөнгөн зэргийн гэмтэл авсан тоон үзүүлэлттэй байна.

Хүүхэд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн чиглэлээр явж байгаад зам тээврийн осолд өртдөг байна. Энэ чиглэлээр яваҳдаа асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр осолд өртдөг хэдий ч жолоочийн хариуцлагагүй үйлдэл, зам, замын байгууламжаас хамаарч осолд өртөх тохиолдол гарсаар байна. Хүүхэд өртсөн байдлыг 2021 оны байдлаар төв, орон нутгаар харьцуулан авч үзэхэд Төв, Сэлэнгэ аймагт хүүхэд өртсөн зам тээврийн осол их бүртгэгдсэн байна.

Авто замын аюулгүй байдал нь замын хөдөлгөөний нэг хэсэг юм. Замын нөхцөл - Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөж иж бүрнээр /замын инженерийн байгууламж, хөдөлгөөн зохицуулах хэрэгсэл гэх мэт/ нь шийдвэрлэж байх шаардлагатай гэж олон улсад үздэг байна. Зам-орчин нь өөрөө замын хөдөлгөөний нэг бүрдэл болдог. Замын нөхцлөөс шалтгаалсан осол улсын хэмжээнд 48 бүртгэгдснээс нийслэлд 21, орон нутагт 27 осол бүртгэгджээ. Дээрх хүчин зүйлд техникийн гэмтэл, гадна гэрэл /замын гэрэл/, зам орчны нөхцлийг багтаан авч үзэж байгаа ч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад ослын акт тавигдаж арга хэмжээ тооцсон байдал хангалтгүй байгаагаас замын нөхцлөөс гарсан ослын үзүүлэлт бага хэвээр байна.

График 11. Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан осол



Замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцөлийн нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замын эвдрэл, гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол хэрэг гарах шалтгаан нөхцөл болдог байна. Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нух, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцөлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ

гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдлын бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна. Замын хөдөлгөөнд оролцогчдод сайхан зам дотроо аюулгүй зам хэрэгтэй байдаг учир замын байгууламж хариуцсан албад, гадна талбай, зогсоолын талбай зэрэг нийтэд үйлчлэх эзэмшлийн зам, талбайгаа цэвэрлээгүйгээс уг байгууллагын эзэмшлийн газарт замын нөхцөлөөс үүдэлтэй осолд аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага хүлээлгэвэл зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэж үзэж байна.

6.7.Зам тээврийн ослын хэлбэр

Зам тээврийн осол гарч буй хэлбэрийг:

- Тээврийн хэрэгслээр явган зорчигч мөргөх
- Тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх
- Тээврийн хэрэгслээр дугуйтай хүн мөргөх
- Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх
- Тээврийн хэрэгслээр онхолдох, замын хажуу руу унах, өнхөрөх зэргээр ангилан тоон үзүүлэлтээр гаргадаг байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 18563 буюу 82.6% нь мөргөлдөх, 1301 буюу 5.8% нь явган зорчигч мөргөх, 1020 буюу 4.5% нь онхолдох, 1150 буюу 5.1% үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/, 35 осол тээврийн хэрэгслээс зорчигч унагах, 93 унадаг дугуйтай хүн мөргөх, 195 осол нь мал, амьтан дайрах, 123 осол бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд явган зорчигч мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн зам тээврийн ослын 959 буюу 73.7% нь нийслэлд бүртгэгдсэн байна. Мөн улсын хэмжээнд онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн 1020 ослын 898 буюу 88% нь орон нутгийн замд бүртгэгдсэн байна.

Монгол Улсад 2021 онд бүртгэгдсэн зам тээврийн осол гарсан хэлбэрийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад:

Нийслэлд:

- Зорчигч унагах, онхолдох, мөргөлдөх, мал амьтан дайрах хэлбэрээр бүртгэгдсэн зам тээврийн осол 2.5-17.6%-иар өссөн байхад явган зорчигч, дугуйгаар зорчигч мөргөх, үл хөдлөх зүйл мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн осол 2.6-8.5%-иар тус тус буурсан тоон үзүүлэлттэй байна.

Орон нутагт:

- Онхолдох, мөргөлдөх, явган зорчигч мөргөх, үл хөдлөх зүйл мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн зам тээврийн осол 1.1-5.5%-иар өссөн байхад дугуйгаар зорчигч мөргөх, тээврийн хэрэгслээс зорчигч унагах, мал амьтан дайрах хэлбэрээр бүртгэгдсэн осол 2.5-63.6%-иар буурсан тоон үзүүлэлттэй гарсан байна.

Нийслэл болон орон нутагт бүртгэгдсэн ослын хэлбэр

Улаанбаатар хотод:

- Мөргөлдөх - 17091 буюу 88.9%,
- Явган зорчигч мөргөх -959 буюу 5.0%,
- Онхолдох – 122 буюу 0.6%,
- Тээврийн хэрэгслээс зорчигч унагах - 23 буюу 0.1%,
- Дугуйтай хүн мөргөх - 76 буюу 0.4%,
- Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх - 906 буюу 4.7%,
- Мал, амьтан дайрах – 40 буюу 0.2 хувийг эзэлж бүртгэгдсэн байна.

Орон нутагт:

- Мөргөлдөх – 1474 буюу 45.2%,
- Явган зорчигч дайрах – 342 буюу 10.5%,
- Онхолдох – 898 буюу 27.5%,
- Зорчигч унагах – 12 буюу 0.4%,
- Дугуйтай хүн мөргөх - 17 буюу 0.5%,
- Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх –244 буюу 7.5%,
- Мал амьтан дайрах - 155 буюу 4.7%,
- Бусад хэлбэрээр 122 буюу 3.7 %-ийг эзэлж бүртгэгдсэн байна.

Нийслэлд автомашин мөргөлдөх, явган зорчигч мөргөх хэлбэрээр мөн орон нутагт автомашин мөргөлдөх, онхолдох хэлбэрээр осол их бүртгэгдсэн.

Тээврийн хэрэгслээр онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн осол

Улсын хэмжээнд: - Онхолдох хэлбэрээр 1020 зам тээврийн осол бүртгэгдсэний 898 буюу 88% орон нутгийн замд бүртгэгдсэн байна. Онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн ослын улмаас орон нутагт 141 хүн, нийслэлд 9 хүн нийт 150 хүн нас барсан байна.

График 12. Орон нутагт бүртгэгдсэн хүн нас барсан осол



График 13. Орон нутагт бүртгэгдсэн зам тээврийн осол



Орон нутагт онхолдох хэлбэрээр гарч буй зам тээврийн осол нь бүрэн бус мотоциклоор замын хөдөлгөөнд оролцох, согтуугаар жолоодох, хурд хэтрүүлэх, замын нөхцөлөөс шалтгаалсан байх магадлалтайгаас гадна замын нөхцөлд хурд тохируулан яваагүйгээс шалтгаалсан байна.

Онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн зам тээврийн ослын улмаас Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт 4, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт 3, Чингэлтэй болон Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт тус тус 1 хүн нас барсан байна.

Зам тээрийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл

Зам тээврийн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн 19450 буюу 86.5% нь суудлын, 2071 буюу 9.2% нь ачааны, 365 буюу 1.6% нь автобус, 35 буюу 0.2% нь механизм 476 буюу 2.1% нь мотоцикл, 85 буюу 0.4% нь унадаг дугуйгаар үйлдэгдсэн байна.

Манай улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 62.8%-ийг суудлын автомашин эзэлж байгаатай холбоотой зам тээврийн осолд холбогдсон автомашины 86.5% буюу дийлэнх хувийг суудлын автомашин эзэлж байна.

Хүснэгт 45. Зам тээврийн осолд холбогдсон автомашины төрөл

№	Үзүүлэлт	ЗТО холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл					
		Суудлын	Ачааны	Автобус/том, багаврын/	Механизм	Мотоцикл	Унадаг дугуй
Улсын хэмжээнд							
1	Тоон үзүүлэлт	19450	2071	365	35	476	85
	Эзлэх хувь	86.5	9.2	1.6	0.2	2.1	0.4
Нийслэлд							
2	Тоон үзүүлэлт	17034	1591	350	27	139	77
	Эзлэх хувь	88.6	8.3	1.8	0.1	0.7	0.4
Орон нутагт							
3	Тоон үзүүлэлт	2416	480	15	8	337	8
	Эзлэх хувь	74	14.7	0.5	0.2	10.3	0.2

Улсын хэмжээнд 71677 мотоцикл бүртгэлтэйгээс түүний 9834 буюу 14.5% нь нийслэлд, 57962 буюу 85.5% нь орон нутагт бүртгэлтэй байна. Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Төв, Увс аймгийн мотоциклын хэрэглээ бусад аймгаас их байна.

Монгол Улсад 2021 онд бүртгэгдсэн мотоциклын тоо өнгөрсөн оны үзүүлэлтээс 3881 буюу 5.7%-иар өссөн нь орон нутгийн мотоциклын хэрэглээ 4.8%, нийслэлийн хэрэглээ 11.3%-иар тус тус өссөн. Улсын хэмжээнд мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн осол 462 бүртгэгдэж, 93 хүн нас барж, 246 хүн гэмтсэн байна. Тухайн ослын 70.8% нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Хүснэгт 46. Мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн ослын байдал

Аймаг, дүүрэг	Бүртгэгдсэн осол			Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
	2021	Өсөлт буурал/тоогоор/	Өсөлт буурал/хувиар/	2021	Өсөлт буурал/тоогоор	Өсөлт буурал/хувиар	2021	Өсөлт буурал/тоогоор/	Өсөлт буурал/хувиар/
Архангай	12	-11	-47.8	5	4	5	8	-11	-57.9
Баян-Өлгий	23	4	21.1	3			11	-3	-21.4
Баянхонгор	22	-13	-37.1	5	-3	-37.5	13	-4	-23.5
Булган	16	2	14.3	5	5		7	-3	-30
Говь-Алтай	9	-11	-55	3	1	50	3	-9	-75
Говьсүмбэр	3	-10	-76.9	1	-2	-66.7	1	-7	-87.5
Дархан-Уул	4	1	33.3				3	1	50
Дорноговь	16	2	14.3	3	2	3	9		
Дорнод	20	5	33.3	6			12		
Дундговь	16	-1	-5.9	3	-7	-70	10	1	11
Завхан	10	-5	-33.3		-1		6	-7	-53.8
Орхон	2						2		
Өвөрхангай	28	-5	-15.2	10	4		15		
Өмнөговь	21	-4	-16	9	1	12.5	6	-4	-40
Сүхбаатар	14	-15	-51.7	2	-3	-60	7	-13	-65
Сэлэнгэ	16	8	2	2	2		14	7	2
Төв	31	7	29.2	10	6	2.5	20	6	42.9
Увс	13			6	4	3	2	-5	-71.4
Ховд	14	-5	-26.3	2	-2	-50	6	-1	-14.3
Хөвсгөл	13	-10	-43.5	3			6	-3	-33.3
Хэнтий	24	1	4.3	9	6	3	9	-4	-30.8

Баянгол дүүрэг	13	6	85.7				10	5	2
Баянзүрх дүүрэг	36	15	71.4		-2		20	6	42.9
Сүхбаатар дүүрэг	21	6	40				9	-3	-25
Сонгинохайрхан дүүрэг	17	6	54.5	3		3	9		
Хан-Уул дүүрэг	33	17	2	3	2	3	18	7	63.6
Чингэлтэй дүүрэг	9	2	28.6				8	1	14.3
Багануур дүүрэг	3						1	-1	-50
Багахангай дүүрэг	1	-3	-75				1	-2	-66.7
Налайх дүүрэг	2	-6	-75					-3	
Нийслэл	135	43	46.7	6	2	50	76	10	15.2
Орон нутаг	327	-60	-15.5	87	17	24.3	170	-59	-25.8
Улсын хэмжээнд	462	-17	-3.5	93	19	25.7	246	-49	-16.6

Мотоциклоор үйлдэгдсэн ослын улмаас :

- Зам тээврийн осол - 462
- Гэмтсэн хүн - 246
- Нас барсан хүн - 93

Мотоциклоор үйлдсэн зам тээврийн осол бүртгэгдсэн тохиолдлоос үзэхэд нийт ослын 28 буюу 5.7% нь Өвөрхангай аймагт, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймагт тус бүр 34 осол бүртгэгдсэн байна.

7.Эрүүлжүүлэгдсэн хүн

2021 онд нийт 70.479 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.384 буюу 24.9 хувиар буурчээ.

Эрүүлжүүлэгдсэн хүний 55.002 буюу 78.0 хувь нь нийслэлд, 15.477 буюу 22.0 хувь нь орон нутагт эрүүлжүүлэгдсэн байна.

Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 63.967 буюу 90.7 хувь нь эрэгтэй, 6.512 буюу 9.3 хувь нь эмэгтэй, 193 буюу 0.3 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

Архины албадан эмчилгээнд 353, хүн, сайн дурын эмчилгээнд 331 хүнийг хамруулсан байна.

8.Цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан урьдчилан сэргийлэх ажил

Цагдаагийн байгууллага 2021 онд Цагдаагийн албаны тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, улсын хэмжээнд зохион байгуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжил, арга зүй, удирдлагаар ханган, үр дүнг тооцож ажиллалаа.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд нэгдсэн 22, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд 756, хэсэгчилсэн 1496, нийт 2274 ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна.

“Хүн худалдаалах” гэмт хэрэгт өртөж хохирсон охид, эмэгтэйчүүдийг олж тогтоох, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дээрх гэмт хэргийн хор уршгийг олон нийтэд таниулах зорилгоор “**Мөрөөдлийн шүхэр**” аян, арга хэмжээг зохион байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрхийн төв, Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хүрээлэн болон төрийн, төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийн 2020 оны судалгааны тайланд үндэслэн арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагууд зөвлөмж, ажлын чиглэлийг хүргүүлсэн. Арга хэмжээний хүрээнд нийт 13 төрлийн 39.000 ширхэг тараах материалыг хэвлүүлэн байршуулж, цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн “Судалгаа, хяналтын

бүртгэл, судалгаа” цэсийн обьектын судалгаанд 187 аж ахуй нэгжийг, субьектын судалгаанд 354 биеэ үнэлэгч, зохион байгуулагч, энэ төрлийн хэрэгт холбогдож болзошгүй этгээдийн талаарх мэдээллийг нэмж оруулсан.

“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж аймаг, нийслэлийн онцгой байдал, мэргэжлийн хяналт, прокурор, цагдаагийн байгууллага хамтран Амьтны болон Байгалийн ургамлын тухай, Усны тухай болон Ойн тухай холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, хамгаалалтын чиглэлээр 4 төрлийн 27 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд байгууллагын болон дүүрэг, хороодын цахим хаягаар 46 видео шторк, 321 постер, 321 фото болон видео мэдээ, мэдээллийг түгээж, гудамж талбай, олон нийтийн газарт байрлах 44 лед дэлгэцээр 23 видео шторкийг нэвтрүүлж, 92 самбарт сэрэмжлүүлэг хэвлүүлэн голын эрэг, олон нийт ихээр зорчдог цэгүүдэд байршуулж, 431 ширхэг гарын авлага, 2533 зурагт хуудас, 1384 санамж, сэрэмжлүүлэг тарааж, телевизэд 1, радиод 3, цахим хуудаст 106 удаа мэдээ, мэдээлэл өгч, телевизээр 18 шторкийг олон нийтэд хүргэсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар алба хаагчдын албандаа хандах хандлага, ухамсар, соёлыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “**Харилцаа, хандлага**” нөлөөллийн аяныг зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллагын удирдах 213 албан тушаалтнаар шинэ томилогдсон болон одоо ажиллаж залуу алба хаагчдад сургамжит яриа, нэвтрүүлэг бэлтгэж, цагдаагийн байгууллагын алба хаагчдын хаалттай группт түгээлт хийж, 8800 алба хаагчид мэдээллийг хүргэсэн.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран замын хөдөлгөөнд оролцож байгаа иргэд, жолооч нарт зам тээврийн осол, хэргийн шалтгаан, нөхцөл, хор уршиг, учирч болзошгүй эрсдлийг таниулах, эрх зүйн боловсрол олгох, жолоочийн хариуцлагыг дээшлүүлэх, хөдөлгөөний соёл, зөв дадал, хандлагыг төлөвшүүлэх замаар иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “**Ирээдүйгээ хамгаалъя**” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд үүрэн телефоны Мобиком, Жи-Мобайл компаний 2.5 сая хэрэглэгчдэд “Хамгаалах бүсээ зүүж, хурдаа тохируулъя, хайртай гэр бүлийн тань амь нас эрүүл мэнд зөвхөн танаас шалтгаална”, “Ирээдүйгээ хамгаалъя ЦЕГ” гэсэн зорилтот сэрэмжлүүлэг мессежийг хүргэж, Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв, Оюутолгой ХХК, автомашин, мотоциклийн мэргэжлийн холбоодтой хамтран хөдөлгөөнт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж үйл ажиллагааг 10 цахим хуудас, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээллийг шууд хүргэж, тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарт “Хамгаалах бүсээ бүслэ”, ”Бүсээ бүү март”, утасны дугаар бичигч болон арга хэмжээний хүрээнд бэлтгэн гаргасан сэрэмжлүүлэг бүхий CD зэрэг нийт 5 төрлийн 15000 ширхэг санамж сэрэмжлүүлэг, гарын авлага зөвлөмж өгч, тээврийн хэрэгслээр зорчиж явсан 20 хүүхдэд хамгаалалтын суудлыг хүлээлгэн өгсөн.

Иргэдийн амь нас, эд хөрөнгийг үер, усны осол, аюулаас урьдчилан сэргийлэх **“Сэрэмжилье-Болгоомжилъё”** нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, 44 телевиз, 7 радио, 4 цахим хуудастай хамтран ажиллаж, богино хэмжээний үер, усны осол, аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх бичлэг 34, нэвтрүүлэг 3, лайв 3 удаа хийн олон нийтэд хүргэн, 245 төрлийн постер 83,759 ширхэгийг хэвлэн иргэдэд тараан, 1,436,300 дагагч бүхий 883 цахим хуудаст сэрэмжлүүлэг бичлэг, постеруудыг түгээж, иргэд ихээр цугладаг, аялал жуулчлалын бүс дахь нуур, цөөрөм, голын эрэг, тогтоол усны дагуу 264 сэрэмжлүүлэг бүхий самбарыг байршуулж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд явган, морьт, мотоциклт, машинт эргүүлийг дангаараа болон онцгой байдлын хэлтэстэй хамтран 16 нуур, цөөрөм, голд

завьт эргүүлийн үүргийг давхардсан тоогоор 593 удаа 4554 цаг зохион байгуулж, 39 хүнийг авран хамгаалсан.

Арга хэмжээ зохион байгуулсан хугацаанд улсын хэмжээнд насанд хүрсэн 13, хүүхэд 4 нийт 17 хүн усанд осолдож нас барсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 7 нэгж буюу 35 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй ”**Байна уу байна**” арга хэмжээний хүрээнд дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдээс өдөр бүр 07:00-10:00, 17:00-21:00 цагийн хооронд хүн олноор цуглардаг зах, худалдааны төв, автобусны буудал орчмын газруудад дуут дохио бүхий чанга яригчаар 15000 иргэд, том оврын 532 автобусны гадна, дотор талд сэрэмжлүүлэг, мэдээллийг байршуулж, халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэж болзошгүй 26 этгээдийн үйлдлийг таслан зогсоож, бүртгэл судалгаанд авч, 46 гэмт хэргийг үйлдэл дээр нь илрүүлэн, нийт 556 алба хаагчийн профайл нүүр зургийг шинэчлэн солиулж, 4 төрлийн сэрэмжлүүлэг видеог дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдийн цахим хуудас, фэйсфүүкийн олон гишүүнтэй 568 группт түгээлт хийж, гудамж талбайн 13 LED дэлгэц, дүүргүүдийн Тамгын газрын гадна талын дэлгэцээр түгээж, иргэд олон нийтэд мэдээллийг хүргэн ажилласан.

Түүнчлэн, арга хэмжээний хүрээнд хийсэн видео, контент, постеруудыг Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас болон Нийслэлийн цагдаагийн удирдах газрын цахим хуудас, дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн цахим хуудсууд, “Гэр бүлийн радио-104.5”, “Арга билэг-95.7”, “Авто радио-96,3”, “Формула-98.1”, “Vibe-105.5”, **12** телевизэд, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 цахим хуудаст байршуулж нийт 11858 хүнд түгээсэн.

Их, дээд болон коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2021-2022 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан оюутан, сурагч, хүүхэд багачуудыг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг, эх асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 203 сургууль, 694 цэцэрлэг орчмын газруудад 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 07:00-13:00 13:00-18:00 цагийн хооронд нийт 173 чиглэлд 416 алба хаагчийг явган эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 зурагт хуудас бүхий зөвлөмж 3000 ширхэгийг эцэг, эхчүүд, сурагчдад тарсан.

Мөн “**Хичээл эхэллээ**” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Монгол Улсын MNS 6423:2019 стандартыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, нийт 32 их, дээд сургуулийн оюутны байрны гадна орчныг хянах 24, дотор орчныг хянах 66, нийт 90 телекамерын хэвийн үйл ажиллагааг шалгаж бичлэг хадгалах хугацаа 30-аас бага хоног хадгалдаг 12 зөрчлийг илрүүлэн их, дээд сургуулиудын оюутны холбоо, дотуур байрны удирдлагуудад “Шаардлага” хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах чиглэлээр 15 мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг бэлтгэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс цахим хуудаст байршуулсан.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа зохион явуулж байгаа төдийгүй, эрдэм шинжилгээ, судалгаа, дүн мэдээнд суурилсан арга хэмжээг зохион байгуулж байна. Гэмт хэрэг үйлдэгдсэний дараа илрүүлэхээс өмнө буюу гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, гэмт явдал бий болох нөхцлийг бүрдүүлэхгүй байх нь хохирол учрахгүй байх, зардал хэмнэх, бусад эрсдлээс сэргийлэхэд ач холбогдолтой билээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ПРОКУРОР - PROSECUTOR

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
3. ХЯНАЛТ ТАВЬСАН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ, ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТ
4. ХЯНАЛТ ТАВЬСАН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ, ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТ
5. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ





2021 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ

70232

- ХЭРЭГ НЭЭХЭЭС ТАТГАЛЗСАН — **38061**
- ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРЭГ НЭЭСЭН — **23157**
- ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ ЯЛЛАГДАГЧААР ТАТСАН — **9014**

2021 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ

91079

- ХЭРЭГ НЭЭХЭЭС ТАТГАЛЗСАН — **59029**
- ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЭЭСЭН — **30155**
- ЭРҮҮГИЙН ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРЭГ НЭЭСЭН — **1699**
- ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЖ ЯЛЛАГДАГЧААР ТАТСАН — **136**

2021 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫН ХЭРЭГ

61217

- ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН — **1663**
- ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛСЭН — **12582**
- НЭГТГЭСЭН — **5025**
- ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРГИЙГ ХААСАН — **15052**

ТУХАЙН ЖИЛ ШИНЭЭР ҮҮСГЭСЭН ХЭРГИЙН ТОО - 34166

ЗОНХИЛОХ ГЭМТ ХЭРГИЙН ТӨРЛҮҮД:

- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг - **65.42%**
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг - **18.46%**
- Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг - **4.91%**
- ХАБ, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг - **2.57%**

2021 ОНД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВЬСАН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ

2046624

- **1900153** ГАЗАР ДЭЭР НЬ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙТГЭЛ ОНОГДУУЛСАН
- **116461** БҮРТГЭЖ, ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙТГЭЛ ОНОГДУУЛСАН
- **30010** ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭЛТИЙН ХЭРЭГ НЭЭСЭН

ЗОНХИЛОХ ЗӨРЧЛИЙН ТӨРЛҮҮД:

- Мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил - **4.02%**
- Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил - **5.88%**
- Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил - **1.08%**

1.Прокурорын байгууллагын товч танилцуулга

1.1.Прокурорын байгууллагын түүхийн товчоон

1930 оны 4 дүгээр сард хуралдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын 6 дугаар Их Хурлын шийдвэрийн дагуу Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1930 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор “Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргийн дүрэм”-ийг баталснаар Монгол Улсад прокурорын байгууллага үүсэж хөгжсөн түүхтэй.

Прокурорын хяналтын хуулийг 1993, 2002, 2017 онд шинэчлэн баталсан бөгөөд эдгээр хуулиуд нь нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжил, эрх зүйн шинэчлэлтэй уялдан прокурорын байгууллагыг бэхжүүлэх, прокурорын эрх, үүрэг, хяналтын арга хэлбэр, үйл ажиллагааны баталгаа, хариуцлагын тогтолцоо зэргийг тухай бүр нь шинэчлэн зохицуулж байснаараа онцлогтой юм[1].

1.2.Прокурорын байгууллагын үндсэн чиг үүрэг

2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Прокурорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт зааснаар Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн.

Прокурорын тухай хуулийн 22 дугаар зүйлд прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа:

-Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;

-Ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн эсэх;

-Ял эдлүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэх;

-Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэхийг хянана гэж заасан[2].

Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийн дагуу 2021 онд гүйцэтгэсэн үйл ажиллагаа:

Улсын хэмжээнд 22 хорих анги, 1 сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, 28 цагдан хорих байр, 25 баривчлах байр, 29 саатуулах байрны үйл ажиллагаа болон хорихоос өөр төрлийн ял, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нийт 46 прокурор хяналт тавьж ажилласан байна.

2021 оны эцэст хорих ялтай 3044 хоригдлын 58.6 хувь нь нээлттэй дэглэмд, 40.9 хувь нь хаалттай дэглэмд, 0.5 хувь нь сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаагийн 167 нь эмэгтэй, 26 нь гадаадын иргэн, 15 нь өсвөр насны хүн байна.

2021 онд цагдан хорих байранд 5449, баривчлах байранд 14 440, саатуулах байранд 5006 хүн саатуулагдсан байна. Өмнөх онтой харьцуулбал цагдан хоригдсон хүний тоо 753 буюу 12.1 хувиар, баривчлагдсан хүний тоо 2924 буюу 16.8 хувиар, саатуулагдсан хүний тоо 2959 буюу 37.1 хувиар тус тус буурсан.

Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, тэнсэх, албадлагын арга хэмжээ авагдсан 21612 этгээдийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд прокуророос хяналт тавьж ажилласан нь өмнөх оноос 13.7 хувиар өссөн байна.

Прокурорын байгууллагаас 2021 онд ял эдлүүлэх ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилттэй 7674 удаа танилцаж, 1069 шалгалт хийж, 2364 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар прокурорын шаардлага 229-ийг бичиж, 71 алба хаагчид сахилгын шийтгэл тооцуулсан байна.

---

[1] Монгол Улсын ерөнхий прокурорын газрын цахим хуудас, http://www.prokuror.mn/page/302

[2] Монгол Улсын ерөнхий прокурорын газрын цахим хуудас, http://prokuror.mn/page/4108

1.3.Прокурорын байгууллагын бүтэц, тогтолцоо

Прокурорын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт “Прокурорын байгууллага Улсын Ерөнхий прокурорын газар, аймаг, нийслэлийн прокурорын газар, сум буюу сум дундын, дүүргийн прокурорын газраас бүрдэнэ” гэж заасан ба 43.2 дахь хэсэгт “Прокурорын хяналтын ажлын онцлогийг харгалзан дагнасан прокурорын газар байгуулж болно” гэжээ. Түүнчлэн манай улсад хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, төмөр зам, нисэхийн обьектод үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий дагнасан прокурорын газар болох “Тээврийн прокурорын газар” ажиллаж байна. Улсын ерөнхий прокурорын газар, 21 аймаг, нийслэл, тээврийн прокурорын газар, 8 сум дундын болон 8 дүүргийн прокурорын газруудаас бүрддэг ба нийт 39 нэгж үйл ажиллагаа явуулж байна[3].

2.Прокурорын байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлт

Прокурорын байгууллага 2021 онд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 70 232 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд хяналт тавьж ажилласан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал өссөн үзүүлэлт ба 2020 онд 67312 байсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлтэй харьцуулахад 4.2 хувиар өссөн байна.

Прокурорын байгууллага 2021 онд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 91079 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэлд хяналт тавьж ажилласан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулбал 21.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2.1.Хүлээн авсан гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн үзүүлэлт

2021 оны байдлаар прокурорын байгууллагаас хяналт тавьсан нийт 70232 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 38061, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 23157, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 9014 шийдвэр тус тус гарчээ. Үүнээс нийслэлд 50843 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл хамаарах бөгөөд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 29296, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 16516, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 5031 байгаа бол орон нутагт прокурорын байгууллагын хяналт тавьсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 19 389, үүнээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 8765, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 6641, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 3983 тус тус эзэлж байна. Үүнийг нийслэлийн болон орон нутгийн прокурорын нэгжүүдээр харьцуулж харуулбал дараах үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Нийслэлийн прокурорын байгууллагуудын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд


	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
Нийслэлийн ПГ	574	540	49
Баянгол дүүргийн ПГ	5109	2527	860
Баянзүрх дүүргийн ПГ	6873	4322	1149
Сонгинохайрхан дүүргийн ПГ	5530	3085	659
Сүхбаатар дүүргийн ПГ	3955	1718	879
Хан-Уул дүүргийн ПГ	2455	2074	390
Чингэлтэй дүүргийн ПГ	3332	1500	713
Багануур дүүргийн ПГ	179	161	64
Налайх, Багахангай дүүргийн ПГ	311	150	134
Тээврийн ПГ	978	439	134
НИЙТ	**29 296**	**16 516**	**5031**

Дээрх үзүүлэлтээс харвал гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байдлаар Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол

[3] Монгол Улсын ерөнхий прокурорын газрын цахим хуудас, https://prokuror.mn/structure

дүүргийн прокурорын газар тэргүүлж байгаа бол Багануур, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар хамгийн бага үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсэн байдлаас авч үзвэл хамгийн их нь мөн Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь өмнөхтэй адил Улсын Ерөнхий Прокурорын газар, Багануур, Налайх, Багахангай дүүргийн прокурорын газар байна. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж шийдвэрлэсэн шийдвэрийн тухайд хамгийн их нь Баянзүрх, Сүхбаатар, Баянгол дүүргийн прокурорын газар, хамгийн бага нь Нийслэлийн прокурорын газар, Багануур дүүргийн прокурорын газар байна. Энэ нь өмнөх 2020 оны тус үзүүлэлттэй ойролцоо байна.

График 1.Нийслэлийн прокурорын байгууллагуудын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд




Хүснэгт 2.Орон нутгийн прокурорын байгууллагуудын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн үзүүлэлтүүд

	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
Архангай АПГ	379	204	248
Баян-Өлгий АПГ	338	182	80
Баянхонгор АПГ	515	281	225
Булган АПГ	229	288	162
Говь-Алтай АПГ	251	165	78
Говьсүмбэр АПГ	128	112	69
Дархан-Уул АПГ	393	389	250
Дорноговь АПГ	456	409	195
Дорнод АПГ	666	326	292
Дундговь АПГ	236	228	82
Завхан АПГ	161	250	156
Орхон АПГ	738	412	242
Өвөрхангай АПГ	115	275	133
Өмнөговь АПГ	435	584	115
Сүхбаатар АПГ	323	328	104
Сэлэнгэ АПГ	557	546	152
Төв АПГ	916	463	321
Увс АПГ	468	192	123
Ховд АПГ	316	235	202
Хөвсгөл АПГ	484	319	515

Хэнтий АПГ	661	453	239
НИЙТ	**8765**	**6641**	**3983**

Орон нутгийн прокурорын байгууллагын тухайд гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн тохиолдол Дорнод, Төв, Орхон аймгийн прокурорын газруудад хамгийн их, Говьсүмбэр, Завхан, Өвөрхангай аймгийн прокурорын газруудад хамгийн бага, хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсэн тохиолдол Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймгийн прокурорын газруудад хамгийн их, Увс, Баян-Өлгий, Говьсүмбэр аймгийн прокурорын газруудад хамгийн бага, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдол Төв, Хөвсгөл, Дорнод аймгийн прокурорын газруудад хамгийн их, Говь-Алтай, Говьсүмбэр, Баян-Өлгий аймгийн прокурорын газруудын хувьд хамгийн бага байна.

График 2.Орон нутгийн прокурорын байгууллагуудын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



2.2.Хүлээн авсан зөрчлийн талаарх гомдол мэдээлэл


2021 оны байдлаар прокурорын байгууллагаас хяналт тавьсан нийт 91079 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллээс зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан 59029, зөрчлийн хэрэг нээсэн 30155, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 1699, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 196 гэсэн тоон үзүүлэлттэй байна. Үүнээс нийслэлд 63146 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл хамаарах бөгөөд зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан 47050, зөрчлийн хэрэг нээсэн 14949, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 1127, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 20 байгаа бол орон нутагт нийт прокурорын байгууллагын хяналт тавьсан зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 27933, үүнээс зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан 11979, зөрчлийн хэрэг нээсэн 15206, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 572, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 176 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнийг нийслэлийн болон орон нутгийн прокурорын нэгжүүдээр харьцуулан харуулбал:

Хүснэгт 3.Нийслэлийн прокурорын байгууллагуудын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

	Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан	Зөрчлийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
УЕПГ	2	41	0	0
Нийслэл ПГ	446	470	5	0
Баянгол ДПГ	6320	2150	139	0
Баянзүрх ДПГ	14 489	3380	431	0
Сонгинохайрхан ДПГ	11 145	2498	205	0
Сүхбаатар дүүргийн ПГ	4950	1705	169	6
Хан-Уул ДПГ	5072	2301	96	0
Чингэлтэй ДПГ	3864	1311	61	0
Багануур ДПГ	258	292	8	0
Налайх, Багахангай ДПГ	478	611	11	14
Тээврийн ПГ	26	190	2	0
НИЙТ	**47 050**	**14 949**	**1127**	**20**

Эндээс үзэхэд зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байдлаар Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн прокурорын газрууд тэргүүлж байгаа бол Улсын Ерөнхий Прокурорын газар, Багануур дүүргийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар хамгийн бага үзүүлэлттэй байна. Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллээс зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн байдлаар хамгийн их нь Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь Улсын Ерөнхий Прокурорын газар, Багануур дүүргийн прокурорын газар, Тээврийн прокурорын газар байна. Мөн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллээс эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шийдвэрлэсэн тохиолдлоос хамгийн их нь Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн прокурорын газрууд байгаа бол хамгийн бага нь Тээврийн прокурорын газар болон Нийслэлийн прокурорын газар байна. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж шийдвэрлэсэн шийдвэрийн тухайд зөвхөн Сүхбаатар дүүргийн прокурорын газар болон Налайх, Багахангай дүүргийн прокурорын газарт шийдвэрлэгдсэн байна.

График 3.Нийслэлийн прокурорын байгууллагуудын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт




Хүснэгт 4.Орон нутгийн прокурорын байгууллагуудын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

	Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан	Зөрчлийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
Архангай АПГ	209	601	8	4
Баян-Өлгий АПГ	452	542	38	0
Баянхонгор АПГ	748	838	47	10
Булган АПГ	176	631	13	1
Говь-Алтай АПГ	231	461	13	17
Говьсүмбэр АПГ	128	355	6	0
Дархан-Уул АПГ	804	591	24	8
Дорноговь АПГ	186	546	18	2
Дорнод АПГ	1514	514	16	25
Дундговь АПГ	319	239	7	11
Завхан АПГ	143	553	30	2
Орхон АПГ	769	999	47	4
Өвөрхангай АПГ	554	1736	60	43
Өмнөговь АПГ	545	739	34	1
Сүхбаатар АПГ	320	452	22	16
Сэлэнгэ АПГ	1341	878	94	5
Төв АПГ	202	921	12	3
Увс АПГ	617	1079	28	0
Ховд АПГ	1564	723	31	10
Хөвсгөл АПГ	489	950	9	4
Хэнтий АПГ	668	858	15	10
НИЙТ	**11 979**	**15 206**	**572**	**176**

Орон нутгийн прокурорын байгууллагын тухайд зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн тохиолдол Дорнод, Ховд, Сэлэнгэ аймгийн прокурорын газруудад хамгийн их, Говьсүмбэр, Завхан, Булган аймгийн прокурорын газруудад хамгийн бага, зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэсэн тохиолдол Орхон, Өвөрхангай, Увс аймгийн прокурорын газруудад хамгийн их, Дундговь, Говьсүмбэр, Говь-Алтай аймгийн прокурорын газруудад хамгийн бага, эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн тохиолдол Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн прокурорын газруудад хамгийн их, Говьсүмбэр, Дундговь, Архангай аймгийн прокурорын газруудын хувьд хамгийн бага, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тохиолдол Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн прокурорын газруудад хамгийн их, Баян-Өлгий, Говьсүмбэр, Увс аймгийн прокурорын газруудын хувьд хамгийн бага байна.

График 4. Орон нутгийн прокурорын байгууллагуудын зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



3.Хяналт тавьсан эрүүгийн хэрэг, түүний шийдвэрлэлт

3.1.Прокурорын байгууллагын хяналт тавьсан эрүүгийн хэргийн үзүүлэлт, өмнөх жилтэй харьцуулсан байдал

2021 онд прокурорын байгууллага нийт 61217 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан байна. Үүнээс хэрэгсэхгүй болгосон 1663, шүүхэд шилжүүлсэн 12582, нэгтгэсэн 6089, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан 15051, тухайн жил эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 10413 хэрэг байна. Тухайн жил шинээр үүсгэсэн хэрэг 34166, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдсан этгээдийн тоо 15618 (эмэгтэй 2286, насанд хүрээгүй хүн 795) байна. Мөн онд бүртгэгдсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн нийт хохирогчийн тоо 26359 байх ба үүнээс эмэгтэй 12007, насанд хүрээгүй хүн 1383 байх ба амь насаараа хохирсон хүн 2003, эрүүл мэндээрээ хохирсон хүн 10349, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн 661 байсан байна. Хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийг тусад нь авч үзвэл 2021 онд тухайн жил шинээр нээсэн мөрдөн байцаалтын хэрэг 19485 байгаа бол үлдсэн 41732 хэрэг нь хэрэг бүртгэлтийн шатанд болон өмнөх жил бүртгэгдсэн мөрдөн байцаалтын хэрэг байна.

Энэ нь өмнөх оны хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавьсан 77199 хэргээс 20.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн шинээр нээсэн мөрдөн байцаалтын хэрэг нь өмнөх оны шинээр нээсэн мөрдөн байцаалтын хэрэг болох 19001 хэргээс 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй, мөн хэрэг бүртгэлтийн болон өмнө нь нээсэн мөрдөн байцаалтын хэрэг 58198 хэргээс 28.3 хувиар буурсан байна.


Хүснэгт 5.Прокурорын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн 2020, 2021 оны харьцуулсан үзүүлэлт

	Прокурорын байгууллагын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргүүд	Шинээр үүсгэсэн мөрдөн байцаалтын хэрэг	Хэрэг бүртгэлтийн болон мөрдөн байцаалтын өмнөх оны үлдэгдэл хэрэг
2020	77 199	19 001	58 198
2021	61 217	19 485	41 732
Өөрчлөлтийн үзүүлэлт	-20.3%	+2.5%	-28.3%

3.2.Прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт

Прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтийн хувьд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдол 3 дахин өссөн, шүүхэд шилжүүлж шийдвэрлэсэн тохиолдол буурсан, нэгтгэж шийдвэрлэсэн тохиолдол өссөн, хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн тохиолдол 2 дахин буурсан, тухайн жил шинээр үүсгэсэн гэмт хэргийн тоо буурсан байна.

Хүснэгт 6, График 5.Прокурорын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтийн 2020, 2021 оны харьцуулалт



	Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	Тухайн жил шинээр үүссэн гэмт хэрэг
Өөрчлөлтийн үзүүлэлт	203.40%	-12.20%	0.62%	-51.50%	-1.28%
2021	1663	12582	5025	15052	34166
2020	548	14329	4994	31064	34610

3.3. Прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн яллагдагчийн байдал

Прокурорын байгууллагаас хянасан мөрдөн байцаалтын хэрэгт яллагдагчаар татагдсан этгээдийн тоо буурсан үзүүлэлттэй байна. Үүнийг дагаад эмэгтэй яллагдагч болон насанд хүрээгүй яллагдагчийн тоо мөн буурсан байна.

Хүснэгт 7.Прокурорын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн яллагдагчийн 2020, 2021 оны харьцуулалт

	Тухайн жил эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдсан яллагдагчийн тоо	Эмэгтэй яллагдагч	Насанд хүрээгүй яллагдагч
2020	16293	2498	846
2021	15618	2286	795
Өөрчлөлтийн үзүүлэлт	-4.14%	-8.48%	-6.02%


3.4.Прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн байдал

Прокурорын байгууллагаас хянасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогч өмнөх оныхоос өссөн байна. Гэхдээ нас барсан хүний тоон үзүүлэлт өмнөх оныхоос буурсан, бусад нь өссөн дүнтэй байна. Тухайлбал, эмэгтэй хохирогч (16.9%), насанд хүрээгүй хохирогч (35.6%), гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн тоо (82.6) буюу тухайн жилд 16.9%-82.6% хэмжээгээр тус тус өсчээ.

Хүснэгт 8.Прокурорын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн 2020, 2021 оны харьцуулалт

	Нийт хохирогч	Эмэгтэй хохирогч	Насанд хүрээгүй хохирогч	Нас барсан хүн	Эрүүл мэндээр хохирсон хүн	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн
2020	23 303	10 271	1020	2672	10 197	362
2021	26 359	12 007	1383	2003	10 349	661
Өөрчлөлтийн үзүүлэлт	+13.11%	+16.9%	+35.6%	-25%	+1.5%	+82.6%

График 6.Прокурорын хяналт тавьсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн хохирогчийн 2020, 2021 оны харьцуулалт



3.5.Прокурорын байгууллагын хяналт тавьсан эрүүгийн хэргийг тодорхой төрлийн гэмт хэргээр үзүүлбэл

1. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүсгэсэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
10.1 дүгээр зүйл. Хүнийг алах	454	3	240	3	28	217
10.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах	2	0	1	0	0	1
10.4 дүгээр зүйл. Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	2315	2	5	2	1835	1879
10.5 дугаар зүйл. Эх нярай хүүхдээ алах	15	1	2	0	8	7
10.6 дугаар зүйл. Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	225	49	63	2	52	131
Нийт	**3011**	**55**	**311**	**7**	**1923**	**2235**

Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт хамаарах нийт 3011 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан ба энэ нь хяналт тавьсан нийт хэргийн 4.91 хувийг эзэлж байна. Энэ нь 2020 онд бүртгэгдсэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нийт хэрэг буюу 3932 хэргээс 30.58 хувиар бага үзүүлэлт юм. Энэхүү 3011 хэргийн 1.82 хувийг хэрэгсэхгүй болгож, 10.32 хувийг шүүхэд шилжүүлж, 0.23 хувийг нэгтгэж, 63.86 хувийг хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна. Үүнээс хүнийг алах гэмт хэрэг (15.07%), хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (76.88%), хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох (7.47%) гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байна.

Хэрэгсэхгүй болгосон хэргийн тухайд хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох (89%), шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд хүнийг алах (77.17%), нэгтгэсэн хэргийн тухайд хүнийг алах (42.85%), хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан тухайд хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (95.42%), тухайн жил шинээр үүссэн хэргийн тухайд хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (84.07%) гэмт хэрэг тус тус хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

2. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг)

Тодорхой төрлийн гэмт хэргүүд	ХБМБ явуулсан хэрэг	Үүнээс				Тухайн жил шинээр үүсгэсэн хэрэг
		Хэрэгсэхгүй болгосон	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан	
11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	762	11	376	7	85	444
11.3 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	117	20	38	1	22	67
11.4 дүгээр зүйл.	1035	120	557	14	98	780

Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах						
11.5 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	122	12	23	0	55	70
11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	9002	906	5389	198	859	7342
11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	256	27	108	15	52	182
Нийт	**11302**	**1097**	**6494**	**235**	**1171**	**8890**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр 2021 онд прокурорын мэдэгдэл 1532 бичсэний дотор 267 буюу 17.4 хувийг зөрчлийн хэрэгт, 870 буюу 56.7 хувийг эрүүгийн хэрэгт, 359 буюу 23.4 хувийг шалгалт, судалгааны дүнг үндэслэж, 36 буюу 2.3 хувийг эрүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээнд үндэслэж тус тус бичсэн байна.

Харьяа нэгж прокурорын газрууд 2021 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга 435 удаа, сургалт зөвлөгөөн 207 удаа, хэлэлцүүлэг 22 удаа зохион байгуулж, хэвлэлд 197 мэдээ, мэдээлэл өгч, гарын авлага 164-ийг гаргасан байна. Өмнөх онтой харьцуулахад зохион байгуулсан яриа таниулга 24.6 хувиар, сургалт зөвлөгөөн 40.8 хувиар, хэлэлцүүлэг 1.4 дахин, хэвлэлд өгсөн мэдээ, мэдээлэл 13.8 хувиар, гарын авлага 13 буюу 8.6 хувиар тус тус өссөн байна.

Улсын Ерөнхий Прокурорын газрын Олон нийттэй харилцах албанаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 22 подкаст, 30 ярилцлага, 10 нийтлэл, 63 видео контент, 24 видео мэдээ, 136 постер бэлтгэж олон нийтэд хүргэсэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ШҮҮХ – COURT

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ
3. ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ
4. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ





ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ ШИЙДВЭРЛЭЛТ

Хүлээн авсан **21162**

Шийдвэрлэсэн **21122**

Хэрэгт холбогдсон хүн **22228**

Торгуулсан **4863**

Торгуулын хэмжээ **2.231.805.600₮**

АНХАН ШАТНЫ ШҮҮХ

Хэргийн тоо **12068** -10.4%

Ял шийтгүүлэгчдийн тоо **11263** -15.9%

Оногдуулсан ял, шийтгэл

- **6179** Торгох (47.2%)
- **1518** Нийтэд тустай ажил хийлгэх (11.6%)
- **2518** Хорих (19.2%)
- **1049** Зорчих эрхийг хязгаарлах (8.0%)
- **78** Албадлагын арга хэмжээ (0.6%)
- **1560** Тэнсэх (11.9%)
- **1** Баривчлах (0.0%)
- **190** Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн (1.5%)

ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

Хянан шийдвэрлэсэн **2105**

Үлдэгдэл - **138**

- Тогтоолыг хэвээр үлдээсэн **908**
- Тогтоолд өөрчлөлт оруулсан **530**
- Тогтоолыг хүчингүй болгосон **667**
- Давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэрлэсэн **70**

ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХ

Хүлээн авсан **948**

- Хянаж шийдвэрлэсэн **322**
- Өөрчлөлт оруулсан **87**
- Хэвээр үлдээсэн **137**
- Хүчингүй болгосон **98**

1.Товч танилцуулга

1.1.Шүүхийн үндсэн чиг үүрэг

Шүүх эрх мэдэл нь ардчилсан төрийн эрх мэдлийн нэг бие даасан салаа бөгөөд иргэн, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн хуулиар хамгаалсан эрх ашгийг аливаа хууль бус халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар шүүхийн байгууллагаас төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлдэг онцгой үйл ажиллагаа байдаг. Шүүх эрх мэдэл нь шүүн таслах үйл ажиллагааг хуулиар тогтоосон журам, баримтлах үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх талаар шүүхэд олгосон бүрэн эрх юм.

Шүүх эрх мэдлийг хуулийн дагуу байгуулагдсан шүүх төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлнэ. Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд шүүх ямар зохион байгуулалтын бүтэц, тогтолцоотой байхыг тодорхой хуульчлан заасан нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хууль зүйн баталгаа болдог.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долоодугаар зүйлийн 1-т “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” хэмээн заасан нь Монгол Улсад шүүх эрх мэдлийг шүүхээс өөр ямар ч төрийн байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэх ёсгүйг хуульчлан тунхагласан явдал юм.


Аливаа шүүн шийдвэрлэх, тэр тусмаа анхан шатны “таслан шийдвэрлэх” ажиллагаа нь шүүх эрх мэдлийн илэрхийлэл бөгөөд гэмт хэрэг өдүүлсэн гэм буруутай эсэхийг эцэслэн шийдвэрлэж Монгол Улсын нэрийн өмнөөс ял шийтгэл оноодог.

Зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүх хянаж үздэг.

1.2.Шүүхийн тогтолцоо

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж заасан. Монгол Улсад нийт 117 шүүх байдаг ба дараах байдлаар зохион байгуулагддаг.

График 2. Монгол Улсын шүүхийн байгууллагын тогтолцоо



1.2.1.Анхан шатны шүүх

2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Шүүх байгуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу 2016 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дараах байдлаар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд болон Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийг байгуулсан байна.

Хүснэгт 1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх дүүрэг
2	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг
3	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Чингэлтэй дүүрэг
4	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол дүүрэг
5	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Хан-Уул дүүрэг
6	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг
7	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багануур дүүрэг
8	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Налайх дүүрэг
9	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багахангай дүүрэг

Хүснэгт 2. Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Иххэт, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд сумд
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн Улиастай, Алдархаан, Дөрвөлжин, Завхан-Мандал, Идэр, Отгон, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Сантмаргац, Сонгино, Шилүүстэй, Яруу, Эрдэнэхайрхан сумд
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

13	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн Баяндалай, Булган, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Номгон, Ноён, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумд
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Богд, Уянга, Тарагт, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийн тээл, Хайрхандулаан, Сант, Төгрөг, Баянгол, Арвайхээр сумд
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Зүүнбүрэн, Ерөө, Түшиг, Шаамар, Хүдэр, Жавхлант, Цагааннуур, Хушаат, Сүхбаатар сумд
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн Дөргөн, Буянт, Дарви, Дуут, Жаргалант, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн, Ховд сумд
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн Цэнхэрмандал сумд

1.2.2. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд Шүүх байгуулах тухай хуулиар Аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхийг иргэний, эрүүгийн болон захиргааны шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосны дагуу Нийслэлийн шүүх нь Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх болон зохион байгуулагдаж, Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж болон Төв аймгийн Зуунмод, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Заамар, Лүн зэрэг 22 сум, Хэнтий аймгийн Цэнхэр-Мандал сумын нутаг дэвсгэрийг харьяалан шүүн таслах ажлыг хэрэгжүүлсэн байна.

Шүүх байгуулах тухай хуулиар давж заалдах шатны шүүхийг байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосны дагуу Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх болон өөрчлөгдөж, нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжийг харьяалан шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Орон нутгийн шүүхийн хувьд Улсын их хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан “Монгол Улсын Шүүхийн тухай” хуульд “Улсын Дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулна“ гэж заасны дагуу орон нутгийн хувьд давж заалдах шатны 9 шүүхийг байгуулахаар 2013 оны 1 дүгээр сарын 24-нд баталсан Шүүх байгуулах тухай хуульд заасан. 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн Шүүх байгуулах тухай хуулийн дагуу орон нутагт давж заалдах шатны 8 шүүх ажиллаж байсан. 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны нийт 25 шүүх ажиллахаар өөрчлөлт оруулсан.

Хүснэгт 3. Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

№	Шүүх	Байршил	Харьяалах нутаг дэвсгэр
1	Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
12	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
15	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
17	Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймгийн Эрүү,	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг

	Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх		дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
20	Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
22	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

1.2.3.Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим

Шүүхийн зохион байгуулалтын тухай 1949 оны хуулиар Улсын Дээд шүүхийн эрх хэмжээг коллегиор ялган тодорхойлсноороо 1943 оныхоос онцлог юм. Коллегиуд харьяаллынхаа хэргийг 1 гишүүн, 2 ардын төлөөлөгчтэй, 2 дугаар шатны журмаар бол хэргийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэнэ гэж хамтран шийдвэрлэх хэлбэрийг тодруулан тогтоосон байдаг.

1960 оны Үндсэн хуулийн 6 дугаар бүлэгт БНМАУ-д шүүн таслах ажлыг БНМАУ-ын Дээд шүүх, аймаг, хотын шүүх, тусгай шүүх, мөн ардын хэсгийн шүүх гүйцэтгэнэ гэж шүүхийн системийг тодорхойлжээ. Энэ үеэс Улсын Дээд шүүхийн зохион байгуулалтын бүтэц нь тус шүүхийн эрх хэмжээ, үйл ажиллагааны төрөл онцлогт нарийн зохилдсон хэмээн үздэг. Шүүхийн зохион байгуулалтын хууль тогтоомжид зааснаар Улсын Дээд шүүх нь Улсын Дээд шүүхийн бүгд хурал, Улсын Дээд шүүхийн тэргүүлэгчид, эрүүгийн хэрэг эрхэлсэн коллеги, иргэний хэрэг эрхэлсэн коллеги, цэргийн коллеги гэсэн зохион байгуулалтын үндсэн бүтэцтэй байлаа. Улсын Дээд шүүхийн гурван коллеги нь 1993 он хүртэл шүүн таслах ажлыг дагнан эрхэлж, шүүхийн хяналтыг хэрэгжүүлж байв.

1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг баталсны дараа 1993, 2002 онд баталсан Шүүхийн тухай хуулийн дагуу Улсын Дээд шүүх нь Ерөнхий шүүгч, Эрүү, Иргэний хэргийн танхимын тэргүүн, 14 шүүгч, нийт 17 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байв.

Улсын Их хурлаас 2012 онд баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулиар “Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ. Улсын Дээд шүүхийн шүүгч эрүү, иргэн, захиргааны хэргийн дагнасан танхимын аль нэгд харьяалагдах бөгөөд түүнийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх өөр танхимын шүүн таслах ажиллагаанд оролцуулахыг хориглоно.” гэж Улсын Дээд шүүхийн бүрэлдэхүүнийг хуульчлан тогтоож, улмаар хууль батлагдахаас өмнө уг танхимд ажиллаж байсан бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Танхимын тэргүүн болон 7 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн юм.

1.3.Бүтэц, орон тоо

2021 онд нийт 30 шүүгчийн сул орон тоонд шүүгчийн хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлт хийсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 13 шүүгчийг шинээр, 1 шүүгчийг дэвшүүлэн, 16 шүүгчийг шилжүүлэн томилуулж, 1 шүүгчийг томилолтоор ажиллуулсан.

2021 онд 6 шүүгч өөрийн бичгээр гаргасан хүсэлтээр, 10 шүүгч өндөр насны тэтгэвэрт гарах, 2 шүүгч нас барсан үндэслэлээр нийт 18 шүүгчийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар албан тушаалаас нь тус тус чөлөөлсөн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайланд дурдсанаар 2022 оны 01 сарын 03-ны өдрийн байдлаар Монгол Улсын бүх шатны 117 шүүхэд нийт 512 шүүгч ажиллаж байгаагаас анхан шатны шүүхэд 389, давж заалдах шатны шүүхэд 101, хяналтын шатны шүүхэд 22 шүүгч тус тус ажиллаж байна.

Хүснэгт.4 Шүүгчдийн тоо

Шүүх			УИХ-ын 2016 оны 42 дугаар тогтоолоор батлсан шүүгч, Ерөнхий шүүгчийн орон тоо			2019 оны эцэс дэх шүүгчийн тоо			2020 оны эцэс дэх шүүгчийн тоо			2021 оны эцэс дэх шүүгчийн тоо		
Хяналт шатны шүүх			25			22			22			22		
Давж заалдах шатны шүүх	Иргэн		24	159	699	22	110	484	20	111	522	18	103	518
	Эрүү		24			20			22			21		
	Эрүү, Иргэний		95			56			54			50		
	Захиргаа		16			12			15			14		
Анхан шатны шүүх	Дүүрэг (иргэн)		99	540		82	374		87	388		87	389	
	Дүүрэг (эрүү)		85			55			66			68		
	Захиргаа		104			73			71			73		
	Сум дунд	Эрүү	93			63			66			65		
		Иргэн	120			74			71			72		
		Дагнаагүй	39			27			28			28		

1.4. Шүүхийн хууль тогтоомжийн шинэтгэл

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаанд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталсан. 2020 онд Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газраас тус тус Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Шүүхийн захиргааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д заасан “шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, эрх зүйн бусад актын төсөл боловсруулах, санал өгөх, хууль санаачлагчид уламжлах” бүрэн эрхийн хүрээнд дээр дурдсан шүүх эрх мэдлийн хууль тогтоомжийн төслүүдэд шүүх, шүүхийн захиргааны байгууллагын саналыг тусгуулах ажлыг нэгтгэн зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Шүүхийн ерөнхий зөвлөл, анхан болон давж заалдах шатны шүүх, тамгын газрын саналыг нэгтгэж хүргүүлжээ. Үүний сацуу Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох санал, тооцоо, мэдээлэл, судалгааг хүргүүлж, хамтран ажилласан.

Ийнхүү 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас баталж, тус хууль мөн оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д нийцүүлэн шүүхийн захиргааны дүрэм, журам, стандартыг шинэчлэн боловсруулах, шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэх, шүүхийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийн дэвшлийг нэвтрүүлэх, шүүхийн үйлчилгээг цахимжуулах ажлыг хийж эхлүүлэн 2021 онд Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцүүлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор 9 дүрэм, журам, Хууль зүй, дотоод хэргийн хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар 2 журмыг тус тус батлан, мөрдөж байна.

2.Эрүүгийн хэргийн шийдвэрлэлт

2.1.Анхан шатны шүүх

2021 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд нийт 17979 хүн, 5 хуулийн этгээдэд холбогдох 14182 хэрэг хүлээн авснаас 1 хуулийн этгээд, 1144 хүнд холбогдох 691 хэргийг прокурорт буцааж, 114 хүнд холбогдох 92 хэргийг түдгэлзүүлж, 326 хүнд холбогдох 175 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 1 хуулийн этгээд, 1252 хүнд холбогдох 912 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хуулийн этгээд, 144 хүнд холбогдох 67 хэргийг цагаатгаж, нийт 12068 хэргийг шийдвэрлэж 2 хуулийн этгээд, 13091 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, үүнээс 1560 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 190 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 11263 хүнд ял шийтгэл оногдуулсан байна. Нийт эрүүгийн хэргийн

анхан шатны шүүхүүд 2021 оны тайлант хугацааны эцэст 1156 хэргийн үлдэгдэлтэй байжээ. Дээрх тоон үзүүлэлтийг 2020 онтой харьцуулбал хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 10.4 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо 15.9 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Хүснэгт 5. Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг, ял шийтгүүлэгчдийн тоо

№	Шүүх	Хэргийн тоо		Өсөлт, бууралт		Ял шийтгүүлэгчдийн тоо		Өсөлт, бууралт	
		2020 он	2021 он	Тоо	Хувь	2020 он	2021 он	Тоо	Хувь
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	306	303	-3	-1.0	297	246	-51	-17.2
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	232	156	-76	-32.8	246	154	-92	-37.4
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	400	331	-69	-17.3	395	230	-165	-41.8
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	225	276	51	22.7	200	249	49	24.5
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	106	135	29	27.4	94	133	39	41.5
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	98	96	-2	-2.0	102	98	-4	-3.9
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	428	341	-87	-20.3	404	325	-79	-19.6
8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	138	178	40	29.0	116	142	26	22.4
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	400	395	-5	-1.3	380	382	2	0.5
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	114	144	30	26.3	100	107	7	7.0
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	134	156	22	16.4	122	136	14	11.5
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	371	324	-47	-12.7	356	341	-15	-4.2

13	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	209	198	-11	-5.3	192	169	-23	-12.0
14	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	155	144	-11	-7.1	145	140	-5	-3.4
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	234	203	-31	-13.2	195	152	-43	-22.1
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	206	174	-32	-15.5	170	132	-38	-22.4
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	487	478	-9	-1.8	462	386	-76	-16.5
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	187	185	-2	-1.1	184	178	-6	-3.3
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	201	185	-16	-8.0	176	153	-23	-13.1
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	387	330	-57	-14.7	348	269	-79	-22.7
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	211	284	73	34.6	216	282	66	30.6
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	107	93	-14	-13.1	85	92	7	8.2
23	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	63	85	22	34.9	44	55	11	25.0
24	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	108	140	32	29.6	116	115	-1	-0.9
25	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	163	89	-74	-45.4	150	68	-82	-54.7
26	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	138	122	-16	-11.6	131	112	-19	-14.5
27	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	51	69	18	35.3	48	51	3	6.3
28	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	99	49	-50	-50.5	62	36	-26	-41.9
29	Хэнтий аймгийн	63	60	-3	-4.8	60	53	-7	-11.7

	Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх								
30	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2064	1460	-604	-29.3	2219	1482	-737	-33.2
31	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1028	940	-88	-8.6	1091	868	-223	-20.4
32	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	909	777	-132	-14.5	909	683	-226	-24.9
33	Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1046	861	-185	-17.7	1176	904	-272	-23.1
34	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	794	728	-66	-8.3	754	703	-51	-6.8
35	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1245	1272	27	2.2	1297	1360	63	4.9
36	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	132	99	-33	-25.0	121	92	-29	-24.0
37	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	21	17	-4	-19.0	21	14	-7	-33.3
38	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	210	191	-19	-9.0	207	171	-36	-17.4
Нийт		**13469**	**12068**	**-1402**	**-10.4**	**13391**	**11263**	**-2128**	**-15.9**

Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн тоон үзүүлэлтийг 2020 оны мөн үзүүлэлттэй харьцуулбал, хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 14.8 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо 19.47 хувиар тус тус буурсан байна. Түүнчлэн, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс бусад 8 дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тоон үзүүлэлтүүд 4-өөс 33.3 хувиар өмнөх оноос буурсан бол тус дүүргийн хувьд хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 2.2 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо 4.9 хувиар тус тус өссөн байна.

Орон нутаг дахь Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн тоон үзүүлэлтийг 2020 оны мөн үзүүлэлттэй харьцуулбал, хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 0.049 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо 0.1 хувиар тус тус буурсан байна.

2.2.Шийдвэрлэсэн гэмт хэргийн төрөл

2021 онд улсын хэмжээнд эрүүгийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хүнийг алах гэмт хэрэг 3 хэргээр буюу 6.2 хувиар, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 38 хэргээр буюу 10.4 хувиар, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 683 хэргээр буюу 12.0 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2 хэргээр буюу 2.0 хувиар, хүн худалдаалах гэмт хэрэг 2 хэргээр буюу 25.0 хувиар, хулгайлах гэмт хэрэг 361 хэргээр буюу 22.4 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 78 хэргээр буюу 29.0 хувиар, улсын хилээр бараг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 11 хэргээр буюу 61.1 хувиар, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 34 хэргээр буюу 18.8 хувиар, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 242 хэргээр буюу 23.5 хувиар тус тус 2020 оноос буурсан байна. Харин хүчиндэх гэмт хэрэг 39 хэргээр буюу 12.7 хувиар, залилах гэмт хэрэг 22 хэргээр буюу 3.1 хувиар өмнөх оноос өсжээ.

Хүснэгт 6. Хянан шийдвэрлэсэн зарим хэрэг

№	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо				
		Өсөлт, бууралт				Өсөлт, бууралт				Хорих ял оногдуулах гүйгээр тэнссэн
		2020 он	2021 он	Тоо	Хувь	2020 он	2021 он	Тоо	Хувь	
1.	Хүнийг алах	210	197	-13	-6.2	209	205	-4	-1.9	0
2.	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	365	327	-38	-10.4	375	322	-53	-14.1	0
3.	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	5689	5006	-683	-12.0	6194	4926	-1268	-20.5	20
4.	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	101	99	-2	-2.0	67	60	-7	-10.4	19
5.	Хүчиндэх	307	346	39	12.7	295	328	33	11.2	47
6.	Хүн худалдаалах	8	6	-2	-25.0	19	10	-9	-47.4	0
7.	Хулгайлах	1614	1253	-361	-22.4	1637	1129	-508	-31.0	322
8.	Дээрэмдэх	269	191	-78	-29.0	303	229	-74	-24.4	38
9.	Залилах	714	736	22	3.1	719	705	-14	-1.9	68
10.	Улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх	18	7	-11	-61.1	18	10	-8	-44.4	0
11.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	181	147	-34	-18.8	211	186	-25	-11.8	33
12.	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1030	788	-242	-23.5	526	419	-107	-20.3	269
13.	Бусад	2964	2965	1	0.0	2818	2734	-84	-3.0	744
Нийт		**13470**	**12068**	**-1402**	**-10.4**	**13391**	**11263**	**-2128**	**-15.9**	**1560**

Хянан шийдвэрлэсэн зарим хэргийг ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл хүнийг алах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 1.9 хувиар, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 14.1 хувиар, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 20.5 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 10.4 хувиар, хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 47.4 хувиар, хулгайлах гэмт хэрэг ял шийтгүүлэгчдийн тоо 31.0 хувиар, дээрэмдэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 24.4 хувиар, залилах гэмт хэрэгт

ял шийтгүүлэгчдийн тоо 1.9 хувиар, улсын хилээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 44.4 хувиар, мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 11.8 хувиар, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 20.3 хувиар, бусад төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 3.0 хувиар тус тус буурчээ. Харин хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 11.2 хувиар өссөн байна.

2.3.Оногдуулсан ял, хариуцлагын төрөл

2021 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс улсын хэмжээнд 6179 хүн, 2 хуулийн этгээдийг торгох ялаар, 1518 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар, 2518 хүнийг хорих ялаар, 1 хүнийг баривчлах ялаар тус тус шийтгэж, 63 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг, 15 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тус тус хэрэглэсэн байна. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсээс биечлэн эдлүүлсэн 2336, өсвөр насны хүн 14, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 20 хүний шийтгэх тогтоолыг хойшлуулжээ. Өнгөрсөн 2020 оноос торгох ялаар ял шийтгүүлсэн хүний тоо 19.3 хувиар, нийтэд тустай ажил хийлгэх ялаар ял шийтгүүлсэн хүний тоо 26.5 хувиар, хорих ял шийтгүүлсэн хүний тоо 31.4 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 7. Шүүхээс оногдуулсан ял, хариуцлагын төрөл

№	Хэргийн төрөл	Өсөлт, бууралт				Нийт гэм буруутайд тооцогдсоноос эзлэх хувь		Зөрүү /+/, /-/
		2020 он	2021 он	Тоо	Хувь	2020 он	2021 он	
1.	Торгох	7655	6179	-1476	-19.3	48.0	47.2	-0.8
2.	Баривчлах	0	1	1		0.0	0.0	0.0
3.	Хорих	3670	2518	-1152	-31.4	23.0	19.2	-3.8
4.	Нийтэд тустай ажил хийлгэх	2066	1518	-548	-26.5	13.0	11.6	-1.4
5.	Зорчих эрхийг хязгаарлах	0	1049	1049		0.0	8.0	8.0
6.	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	124	63	-61	-49.2	0.8	0.5	-0.3
7.	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ	20	15	-5	-25.0	0.1	0.1	0.0
8.	Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх	2333	1560	-773	-33.1	14.6	11.9	-2.7
9.	Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн	96	190	94	97.9	0.6	1.5	0.9

2021 онд торгох ялаар 6179 хүн, 2 хуулийн этгээдэд 9 тэрбум 568 сая 941 мянга 330 төгрөгийн торгох ял, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж 367 хүн, 5 хуулийн этгээдээс 3 тэрбум 114 сая 483 мянга 131 төгрөгийг тус тус гаргуулан улсын орлого болгосон байна. Мөн шүүхээс 515 хүнд эрх хасах нэмэгдэл ял хэрэглэж, 1193 хүнд үүрэг хүлээлгэж, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг тус тус хэрэглэсэн байна.

2.2.1.Сэжигтнийг баривчлах арга хэмжээ

2021 онд улсын хэмжээнд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр нийт 161 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 139 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 22 сэжигтэнд баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ. Ийнхүү баривчлах зөвшөөрөл олгосон нийт хүмүүсийн 3.5 хувийг өсвөр насны хүн, 9.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтнийг баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоог өмнөх онтой харьцуулбал 17 хүнээр буюу 9.6 хувиар, баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо 9 хүнээр буюу 6.1 хувиар, баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо 26.7 хувиар тус тус буурсан байна. Харин баривчлах зөвшөөрөл олгосон өсвөр насны хүний тоо 7 дахин, эмэгтэй хүний тоо 2.1 дахин өсжээ.

Хүснэгт 8.Баривчлагдсан сэжигтний тоо

№	Утга	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоо	178	161	-17	-9.6
2.	Баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо	148	139	-9	-6.1
3.	Баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо	30	22	-8	-26.7

2.2.2.Таслан сэргийлэх арга хэмжээ

2021 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс улсын хэмжээнд 2934 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар, 229 хүнд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар, 34 хүн, хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх арга хэмжээг авхуулахаар тус тус ирүүлсэн байна.

Нийт цагдан хорих зөвшөөрөл олгосон хүмүүсийн 142 буюу 6.0 хувь нь эмэгтэйчүүд, 46 буюу 2.0 хувь нь өсвөр насны хүн байна.

Хүснэгт 9.Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүний тоо

№	Утга	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар ирүүлсэн хүний тоо	3672	2934	-738	-20.1
2.	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар ирүүлсэн хүний тоо	451	229	-222	-49.2
3.	Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх	432	34	-398	-92.1
	Үүнээс: хуулийн этгээд	11	0	-11	-100.0

2021 онд улсын хэмжээнд нийт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар шүүхэд ирүүлсэн 2934 хүний 2351 буюу 80.1 хувийг нь цагдан хорьж, 308 хүн буюу 10.5 хувьд нь цагдан хорихоос татгалзаж шийдвэрлэсэн байна.

Үүнээс цагдан хорих зөвшөөрлийн 8.9 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан”, 16.5 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлсан”, 0.1 хувийг “мөрдөгчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 1.9 хувийг “хохирогчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.6 хувийг “гэрчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.8 хувийг өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.5 хувийг “хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 2.2 хувийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 22.6 хувийг “гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 11.7 хувийг урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн”, 0.5 хувийг “шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 2.0 хувийг “прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 31.8 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан” үндэслэлээр тус тус олгожээ. Доорх хүснэгтэд тоон мэдээллийг үзүүлсэн болно.

Улсын хэмжээнд 2021 онд шүүхээс баривчлах, цагдан хорих талаар нийт 6342 шүүгчийн захирамж гарсан байна. Үүнээс яллагдагчаар цагдан хорих тухай 1426 захирамж, цагдан хорих хугацааг сунгах тухай 3460 захирамж, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай 163 болон Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай 158 захирамж, яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай 213 захирамж гарсан нь нийт шүүгчийн захирамжийн 85.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10.Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар гаргасан шүүгчийн захирамжийн тоо

№	Сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан талаар гаргасан нийт шүүгчийн захирамж	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Сэжигтнийг баривчлах тухай	166	120	-46	-27.7
2.	Сэжигтнийг баривчлахаас татгалзах тухай	18	19	1	5.6
3.	Сэжигтнийг суллах тухай	12	15	3	25.0
4.	Яллагдагчаар цагдан хорих тухай	1623	1426	-197	-12.1
5.	Яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай	294	213	-81	-27.6
6.	Шилжүүлэн цагдан хорих тухай	166	123	-43	-25.9
7.	Шилжүүлэн цагдан хорихоос татгалзах тухай	8	16	8	2 дахин
8.	Цагдан хорих хугацааг сунгах тухай	5515	3460	-2055	-37.3
9.	Цагдан хорих хугацааг сунгахаас татгалзах тухай	167	189	22	13.2
10.	Шүүхэд хянагдаж буй яллагдагчийн хорьж мөрдөх хугацааг сунгах тухай	48	22	-26	-54.2
11.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	70	96	26	37.1
12.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	308	163	-145	-47.1
13.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай	175	195	20	11.4
14.	Тогтоосон газраас гарч явах тухай	0	8	8	-
15.	Тогтоосон нутаг дэвсгэрээс гарч явах тухай	32	17	-15	-46.9
16.	Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай	399	158	-241	-60.4
17.	Тодорхой газар очихыг хязгаарлах тухай	4	20	16	5 дахин
18.	Тодорхой хүнтэй уулзахыг хориглох тухай	61	26	-35	-57.4
19.	Тогтоосон замаар зорчихыг даалгах тухай	0	4	4	-
20.	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	20	13	-7	-35.0
21.	Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	3	11	8	3.6 дахин
22.	Төрийн албанд ажиллахыг түдгэлзүүлэх тухай	0	5	5	-
23.	Тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг түдгэлзүүлэх тухай дахин	7	11	4	57.1

24.	Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх тухай	2	0	-2	-100.0
25.	Тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх тухай	1	7	6	6 дахин
26.	Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэхийг сэргээх тухай	4	5	1	25.0
Нийт		**9103**	**6342**	**-2761**	**-30.3**

2.3.3.Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, ялаас чөлөөлсөн байдал

2021 онд Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14, ЭХХШтХ-ийн 37.5, 37.6, 37.7, 37.8, 37.9, 37.10-т тус тус заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гаргаж ирүүлсэн нийт 6496 хүний материалыг шүүхээс хянан хэлэлцсэнээс 21 ялтныг өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлж, 1115 ялтныг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, хяналт тогтоон, 144 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулж, 9 ялтны хорих ялын дэглэмийг хүндрүүлж шийдвэрлэжээ.

Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Өршөөл үзүүлэх тухай хуулийг УИХ-аас батлан гаргасан билээ. Тус хууль 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж 07 дугаар сарын 06-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд 2189 хүний үндсэн ялыг, 437 хүний нэмэгдэл ялыг тус тус өршөөн хэрэгсэхгүй болгож, хэлтрүүлсэн байна. Үүн дотроо 560 хүнийг торгох ялаас, 24 хүнийг албадлагын арга хэмжээнээс, бусад ялаас 308 хүнийг тус тус чөлөөлж шийдвэрлэсэн байна.


Хүснэгт 11.Хорих ял эдлэхээс хугацааны өмнө сулласан, ялаас чөлөөлсөн тухай мэдээллийг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

№	Утга		2020 он	2021 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14, ЭХХШтХ-ийн 37.5, 37.6, 37.7, 37.8, 37.9, 37.10-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас тодорхойлолт, дүгнэлт гарган ирүүлсэн хүний тоо		2580	6496	3916	151.8
2.	Өвчний учир хугацаанаас өмнө хорих ял эдлэхээс чөлөөлсөн		26	21	-5	-19.2
3.	Хорих ял эдлэхээс хугацааны өмнө сулласан		1386	1115	-271	-19.6
4.	Үндсэн хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар сольсон		0	544	544	-
5.	Үндсэн ялыг өршөөсөн		0	2189	2189	-
6.	Нэмэгдэл ялыг өршөөсөн		0	437	437	-
7.	Албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн		0	64	64	-
8.	Торгууль төлөх хугацааг хойшлуулсан		0	0	0	-
9.	Торгох ялаас чөлөөлсөн		1	560	559	0.0
10.	Торгох ялыг хэсэгчлэн төлөх		0	42	42	-
11.	Торгох ялыг хорих ялаар сольсон		112	412	300	267.9
12.	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоосон		40	0	-40	-
13.	Бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн этгээдийг суллах	Сулласан хүн	0	16	16	-
		Суллахаас татгалзсан хүн	0	0	0	-
14.	Ял эдэлсэн хугацаанд оруулан тооцсон		2	5	3	2.5

					дахин
15.	Хорих байгууллагад ял эдлэх дэглэмийг сольсон	150	153	3	2.0
16.	Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар сольсон	330	267	-63	-19.1
17.	Албадлагын арга хэмжээнээс чөлөөлсөн	7	24	17	3.4 дахин
18.	Ялаас чөлөөлсөн	352	308	-44	-12.5
19.	Насанд хүрэгчдийн хорих ангид шилжүүлсэн	38	7	-31	-81.6
20.	Торгох ялыг хорих ялаар сольсон, тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэсэн	45	31	-14	-31.1
21.	Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольсон	0	145	145	-

Улсын хэмжээнд 2021 онд нийт 144 ялтны хорих ял эдлэх дэглэмийг бууруулж, хаалттайгаас нээлттэй дэглэмд шилжүүлсэн нь өнгөрсөн 2020 оноос 15 хүн буюу 11.6 хувиар өссөн бол хорих ял эдлэх дэглэмийг хүндрүүлж, нээлттэйгээс хаалттай дэглэмд шилжүүлсэн хүний тоо 12 хүнээр буюу 57.1 хувиар буурсан байна.


График 1. Хорих ялын дэглэм шилжсэн байдал



2.3.4.Ял шийтгүүлэгчид


2021 онд нийт ял шийтгүүлсэн 11263 хүнээс Монгол Улсын иргэн 11234 хүн буюу 99.7 хувийг, гадаадын иргэн 29 буюу 0.3 хувийг эзэлж байна. Ял шийтгүүлсэн гадаад улсын иргэдийн тоо 2020 оноос 1 хүнээр буюу 3.6 хувиар өсжээ.

График 2. Ял шийтгүүлэгчдийн насны бүлэг



Ял шийтгүүлэгчдийг насны бүлгээр ангилан 2020 онтой харьцуулан авч үзвэл, 14-15 насны ял шийтгүүлэгчдийн тоо 19 хүнээр буюу 55.9 хувиар, 16-17 настай ял шийтгүүлэгчдийн тоо 84 хүнээр буюу 43.3 хувиар, 18-21 настай ял шийтгүүлэгчдийн тоо 376 хүнээр буюу 29.3 хувиар, 22-29 настай ял шийтгүүлэгчдийн тоо 719 хүнээр буюу 19.2 хувиар, 35-аас дээш настай ял шийтгүүлэгчдийн тоо 953 хүнээр буюу 18. Хувиар тус тус буурсан бол 30-34 настай ял шийтгүүлэгчдийн тоо 24 хүнээр буюу 0.8 хувиар тус тус өссөн байна. Ял шийтгүүлэгчдийн дотор 35-аас дээш насны ял шийтгүүлэгчид 4280 байгаа нь нийт ял шийтгүүлэгчдийн 38.0 хувийг эзэлж байна.

График 3. Ял шийтгүүлэгчдийн боловсролын байдал




	Доктор	Магистр	Бакалавр	Техник, мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
2020 он	1	40	2785	37	672	5677	2304	1097	777
2021 он	3	51	2321	130	804	4937	1453	907	657

Ял шийтгүүлэгчдийн боловсролын байдлын хувьд, 2021 онд нийт ял шийтгүүлсэн хүмүүсээс 2375 буюу 21.1 хувь нь дээд, 130 буюу 1.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 804 буюу 7.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 4937 буюу 43.8 хувь нь бүрэн унд, 1453 буюу 12.9 хувь нь суурь, 907 буюу 8.1 хувь нь бага боловсролтой, 657 буюу 5.8 хувь боловсролгүй иргэд тус тус эзэлж байна.

Энэхүү тоон мэдээллийг 2020 онтой харьцуулж үзвэл дээд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 15.9 хувиар, бүрэн дунд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 13.0 хувиар, суурь боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 36.9 хувиар, бага боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 17.3 хувиар, боловсролгүй ял шийтгүүлэгчдийн тоо 15.4 хувиар тус тус буурсан бол техникийн болон мэргэжлийн боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 3.5 дахин, тусгай мэргэжлийн дунд боловсролтой ял шийтгүүлэгчдийн тоо 19.6 хувиар тус тус өссөн байна. Бүрэн дунд боловсролтой ял шийтгүүлэгчид нийт ял шийтгүүлэгчдийн дунд эзлэх хувиараа өнгөрсөн оноос 1.4 хувиар, тусгай мэргэжлийн дунд боловсролтой ял шийтгүүлэгчид нийт ял шийтгүүлэгчдийн дунд эзлэх хувиар өнгөрсөн оноос 2.1 хувиар тус тус өсжээ.

График 4. Ял шийтгүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



	Улс төрийн албан тушаалтан	Төрийн захирганы албан хаагч	Төрийн тусгай албан хаагч,	Төрийн үйлчилгээний албан хаагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Аж ахуйн нэгжийн ажилтан	Малчин	Оюутан	Сурагч	Ажилгүй	Ялтан	Бусад
2021 он	30	40	161	331	174	1069	1277	432	96	4794	26	2832
2020 он	41	66	128	379	243	1026	1133	456	148	5798	31	3941

Ял шийтгүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд, 2021 онд нийт ял шийтгүүлсэн иргэдийн 0.3 хувь нь улс төрийн албан тушаалтан, 0.4 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 1.4 хувь нь төрийн тусгай албан хаагч, 2.9 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч, 1.5 хувь нь төрийн бус байгууллагын ажилтан, 9.5 хувь нь аж ахуйн нэгжийн ажилтан, 3.8 хувь нь оюутан, 0.9 хувь нь сурагч, 11.3 хувь малчин, 42.6 хувь нь ажилгүй, 0.2 хувь нь ялтан, 25.1 хувь бусад иргэд байна.

2.3.Хэргийн үлдэгдэл

2021 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд нийт 1156 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь 2020 оноос 17 хэргээр буюу 1.5 хувиар өссөн дүн юм.

Үлдэгдэл хэргийг шүүхүүдээр тухайлан авч үзвэл Багахангай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх, Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх тус тус 1 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь хамгийн бага байна. Харин Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 46, Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 57 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдээс хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Харин дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдээс Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хамгийн их буюу 163 хэргийн үлдэгдэлтэй байна. Анхан шатны шүүхэд хугацаа хэтэрсэн хэргийн үлдэгдэл 39 хэрэг байна.

Анхан шатны шүүхэд хугацаа хэтэрсэн хэргийн үлдэгдэл бага хэдий ч хэргийн үлдэгдэл өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа нь гэмт хэргийн ангилал, ээдрээ төвөгтэй байдал, шүүгчийн хэргийн ачааллыг судлан тогтоох шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 11.Анхан шатны шүүхийн хэргийн үлдэгдэл

№	Үзүүлэлт	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Тайлангийн эцсийн үлдэгдэл	1139	1156	17	1.4
2.	Хуулийн хугацаа хэтэрсэн	3	5	2	-40

2.4.Давж заалдах шатны шүүх

2021 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд нийт 2313 хэрэг хүлээн авч, 2105 хэргийг хянан шийдвэрлэж, 138 хэргийн үлдэгдэлтэй, 12 хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах прокурорын дүгнэлтийг хүлээн авч, 70 хэрэгт давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гарсан байна.

Давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо өмнөх оноос 597 хэргээр буюу 22.1 хувиар, үлдэгдэл хэргийн тоо 31 хэргээр буюу 18.3 хувиар тус тус буурчээ.

Хүснэгт 12.Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэрэг

№	Утга	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1.	Хянан шийдвэрлэсэн бүх хэрэг	2702	2105	-597	-22.1
2.	Тогтоолыг хэвээр үлдээсэн	1109	908	-201	-18.1
3.	Тогтоолд өөрчлөлт оруулсан бүгд	760	530	-230	-30.3
4.	Тогтоолыг хүчингүй болгосон бүгд	833	667	-166	-19.9
5.	Давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гаргасан	65	70	5	7.7
6.	Үлдэгдэл хэрэг	169	138	-31	-18.3
Тогтоолд өөрчлөлт оруулсан					
7.	Шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй /Ял гэмт хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй/	209	106	-103	-49.3
8.	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	222	154	-68	-30.6
9.	ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн	39	18	-21	-53.8
10.	Ялыг хөнгөрүүлсэн /зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр/	290	252	-38	-13.1
11.	Ялыг хүндрүүлсэн /зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр/	290	-	-	-
Тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн					
12.	Тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шүүхээр хэлэлцүүлэхээр буцаасан	811	634	-177	-21.8
13.	Тогтоолыг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгосон	22	33	11	50.0
Тогтоолыг хүчингүй болгосон үндэслэл					
14.	Шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй	423	362	-61	-14.4
15.	Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн	238	172	-66	-27.7
16.	ЭБШ, ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн	172	133	-39	-22.7

2021 онд улсын хэмжээнд эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд нийт 2105 хэрэг хянан шийдвэрлэснээс 908 хэрэгт буюу 43.1 хувьд анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, 530 хэрэгт буюу 25.2 хувьд нь тогтоолд өөрчлөлт оруулсан бол 667 хэрэгт буюу 31.7 хувьд нь тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Үүнээс анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээсэн магадлалын тоо өмнөх оныхоос 201 хэргээр буюу 18.1 хувиар, өөрчлөлт оруулсан магадлалын тоо 230 хэргээр буюу

30.3 хувиар, хүчингүй болгосон магадлалын тоо 166 хэргээр буюу 19.9 хувиар тус тус өссөн байна.

Мөн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн тогтоолын 3.4 хувийг “ЭХХШтХ-ийг ноцтойгоор зөрчсөн”, 20.0 хувийг, “Шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй”, 29.1 хувийг “Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн”, 47.5 хувийг “зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлсэн” гэсэн үндэслэлээр тус тус өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгож шийдвэрлэсэн хэргийн тухайд, анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн нийт 833 магадлалаас 362 буюу 54.3 хувьд нь “шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй” гэсэн үндэслэлээр, 172 буюу 25.8 хувьд нь “Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн” гэсэн үндэслэлээр, 133 буюу 19.9 хувьд нь “ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн” гэсэн үндэслэлээр тус тус хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн нийт хэргийн 56.9 хувь нь анхан шатны шүүхийн тогтоолд өөрчлөлт оруулж, эсхүл хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

2021 онд анхан шатны шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн хэргийг өмнөх онд хянан шийдвэрлэсэн хэрэгт эзлэх хувиар авч үзвэл 2.1 хувиар, хүчингүй болгож шийдвэрлэсэн хэрэг 0.9 хувиар тус тус өссөн бол өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн хэрэг 2.9 хувиар буурчээ.

2.5.Хяналтын шатны шүүх

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим 2021 онд нийт 948 хэрэг хүлээн авч, 322 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, 55 хэрэгт Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж, албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн бөгөөд 529 хэргийг хянан буцааж, 2 хэрэгт Ерөнхий шүүгч дүгнэлт гаргаж, нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэсэн ба тайлант хугацааны төгсгөлд 40 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 322 хэргээс 243 хэргийг гомдлын дагуу, 54 хэргийг прокурорын эсэргүүцлээр, 25 хэргийг прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 13.Хяналтын шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны дүн, харьцуулсан байдал

№	Утга	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1.	Хүлээн авсан бүгд	1217	948	-269	-22.1
2.	Хуралдаанаар хянаж шийдвэрлэсэн бүгд	685	322	-363	-53.0
3.	Тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн	332	137	-195	-58.7
4.	Тогтоол магадлалд өөрчлөлт оруулсан бүгд	152	87	-65	-42.8
5.	Тогтоол, магадлалыг хүчингүй болгосон бүгд	201	98	-103	-51.2
Өөрчлөлт оруулсан үндэслэл					
6.	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	82	62	-20	-24.4
7.	ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн	9	3	-6	-66.7
8.	Ялыг хөнгөрүүлсэн /зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр/	61	22	-39	-63.9

9.	Ялыг хүндрүүлсэн /зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр	0	0	0	0
Хүчингүй болгосон үндэслэл					
10.	Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн	151	70	-81	-53.6
11.	ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн	50	28	-22	-44.0

2021 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нийт 322 хэргээс 137 хэрэгт буюу 42.5 хувьд нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, 87 хэрэгт буюу 27.0 хувьд нь өөрчлөлт оруулж, 98 хэрэгт буюу 30.4 хувьд нь тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэжээ. Үүнийг 2020 онтой харьцуулан авч үзвэл, анхан болон давж заалдах шатны шүүхээс гаргасан тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн хэргийн тоо 195 хэргээр буюу 58.7 хувиар, тогтоол магадлалд өөрчлөлт оруулсан хэргийн тоо 65 хэргээр буюу 42.8 хувиар, тогтоол, магадлалыг хүчингүй болгосон хэргийн тоо 103 хэргээр буюу 51.2 хувиар тус тус буурсан байна.

Шүүхийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан үндэслэлийн тухайд, 62 хэрэгт буюу 71.3 хувьд нь эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, 3 хэрэгт буюу 3.4 хувьд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтойгоор зөрчсөн, 22 хэрэгт буюу 25.3 хувьд нь зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж шийдвэрлэжээ.

2021 онд хяналтын шатны шүүх нийт 98 тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэснээс анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн гэсэн үндэслэл 70 хэрэг буюу 71.4 хувийг, ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн гэсэн үндэслэл 28 хэрэг буюу 28.6 хувийг тус тус эзэлж байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл, эрүүгийн хэргийн тогтоол магадлалын 57.5 хувийг өөрчилсөн болон хүчингүй болгож шийдвэрлэжээ.

2021 онд хяналтын шатны шүүх хуралдаанаас тогтоол магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн хэрэг 6.0 хувиар буурсан бол тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан хэрэг 4.8 хувиар, тогтоол, магадлалыг хүчингүй болгосон хэрэг 1.1 хувиар тус тус өмнөх оноос өссөн байна.

2021 онд хяналтын шатны шүүх нийт 98 тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэснээс анхан болон давж заалдах шатны шүүх “Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн” гэх үндэслэл 70 хэрэг буюу 71.4 хувийг, ЭХХШТ хуулийг ноцтойгоор зөрчсөн гэсэн үндэслэл 28 хэрэг буюу 28.6 хувийг тус тус эзэлж байна.

3.Зөрчлийн шийдвэрлэлт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсгүүдэд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхээс зөрчлийг хянах шүүхийн харьяаллыг зааж өгсөн. Энэ харьяаллын дагуу 2021 онд эрүүгийн хэргийн шүүх дээрх хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8-7 дахь хэсэгт заасан зөрчлийг харьяаллын дагуу хүлээн авч, мөн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.13, 6.26 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлт (эсэргүүцэл)-ийг тус тус хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан бол иргэн болон захиргааны хэргийн шүүхүүдээс Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7 дугаар зүйлд заасан зөрчлүүдийг шийдвэрлэсэн байна.

3.1.Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 2021 онд нийт зөрчлийн 21946 хэргийг шийдвэрлэсэн байна. Үүнээс эрх бүхий албан тушаалтны /цаашид ЭБАТ гэх/ шийтгэл оногдуулсан 824 шийдвэрийг хянаж, харьяаллын дагуу 21122 хэргийг хянан шийдвэрлэжээ.

ЭБАТ-ны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хянасан зөрчлийн хэрэг: Улсын хэмжээнд 2021 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд эрх бүхий албан тушаалтны шийдвэрт хамаарах 824 зөрчлийн хэргийг хянаснаас 102 хэрэг буюу 12.4 хувийг хэвээр үлдээж, 93 хэрэг буюу 11.3 хувийг өөрчлөлт оруулж, 598 хэрэг буюу 72.6 хувийг хүчингүй болгож, 31 хэрэг буюу 3.8 хувийг шийтгэлээс чөлөөлж шийдвэрлэжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад хянасан хэргийн тоо 29.4 хувиар, үүнээс шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон хэрэг 35.2 хувиар, өөрчлөлт оруулсан хэрэг 26.8 хувиар, шийтгэлийн хуудсыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн хэрэг 9.7 хувиар тус тус буурсан эерэг дүнтэй байна. Харин шийтгэлийн хуудсыг хянаад шийтгэлээс чөлөөлсөн хэрэг 7.7 дахин ихэссэн нь Өршөөл үзүүлэх тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой юм.

ЗШШтХ-ийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар харьяаллын дагуу хүлээн авч шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг: Улсын хэмжээнд 2021 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 22131 хүн, 97 хуулийн этгээдэд холбогдох 21126 хэргийг хүлээн авч, 21122 хэргийг хянан шийдвэрлэж, 40 хэргийн үлдэгдэлтэй байна.

Анхан шатны шүүхээс харьяаллын дагуу хүлээн авсан хэрэгт холбогдсон этгээд 22228 байгаагаас хүн 22131, хуулийн этгээд 97 байна. Шийтгэл оногдуулах саналтай ирүүлсэн 243 хүнд холбогдох саналыг хэрэгсэхгүй болгож, шийтгэлээс 165 хүнийг чөлөөлж, 21728 хүн, 92 хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан байна.

Хүснэгт 14. Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн мэдээлэл

№	Утга	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
Харьяаллын дагуу шийдвэрлэсэн					
1.	Хүлээн авсан хэрэг	20992	21162	170	0.8
2.	Шийдвэрлэсэн хэрэг	20885	21122	237	1.1
3.	Зөрчлийн хэрэгт холбогдсон	21631	22228	867	4.1
4.	Шийтгэл оногдуулсан	21111	21820	709	3.4
5.	Хэрэгсэхгүй болгосон	182	243	61	33.5
6.	Шийтгэлээс чөлөөлсөн	65	165	100	2.5 дахин
7.	Торгуулсан	3467	4863	1396	40.3
8.	Торгуулсан эмэгтэй	757	1092	335	44.3
9.	Нийт торгуулийн хэмжээ /мян.төг/	972861815	2.231.805.600	1258943785	2.3 дахин
10.	Баривчилсан	17644	16865	-779	-4.4
11.	Баривчлагдсан эмэгтэй	549	755	206	37.5
12.	Эрх хассан	9	0	-9	-
13.	Үлдэгдэл хэрэг	37	40	3	8.1
ЭБАТ-ны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хянасан					
1.	Хэвээр үлдээсэн	113	102	-11	-9.7
2.	Өөрчлөлт оруулсан	127	93	-34	-26.8
3.	Хүчингүй болсон	923	598	-325	-35.2
4.	Шийтгэлээс чөлөөлсөн	4	31	27	7.7 дахин
5.	Бүгд	1167	824	-343	-29.4

Өнгөрсөн онтой харьцуулахад нийт хянан шийдвэрлэсэн хэрэг 0.5 хувиар буурч, харьяаллын дагуу шийдвэрлэсэн хэрэг 1 хувиар, шийтгэл ногдуулсан бүгд 3.4 хувиар, торгуулсан бүгд 40.3 хувиар, үүнээс торгуулсан хүн 42 хувиар, торгуулсан эмэгтэй хүний тоо

44.3 хувиар тус тус өссөн бол баривчилсан хүний тоо 4.4 хувиар буурсан байна. Баривчилсан хүний тоо буурсан хэдий ч үүнээс эмэгтэй хүний тоо 37.5 хувиар өссөн байна.

2021 онд харьяаллын дагуу хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг өмнөх онтой харьцуулахад өсөлт харьцангуй бага, оногдуулсан шийтгэлийн хувьд баривчлах зөрчил буурч, торгох зөрчил өссөн дүнтэй байгаа бол баривчилсан хүний тоо буурсан хэдий ч эмэгтэй хүнийг баривчилсан тоо өссөн байна. Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах явдал 2 дахин ихэссэн нь хуулийн этгээдийг холбогдогчоор тогтоосон, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үр дүнг холбоотой байж болох юм. Торгуулсан хүн мөн хуулийн этгээдийг торгох тохиолдлын тоо энэ онд өссөнтэй холбоотойгоор торгуулийн мөнгөн дүн 2.3 дахин өсжээ.

ЭБАТ-ны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хянасан 824 хэрэг байгаагаас хэвээр үлдээсэн 12.4 хувь, өөрчлөлт оруулсан 11.3 хувь, шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгосон 72.6 хувь, шийтгэлээс чөлөөлсөн 3.8 хувийг эзэлж байна.

2021 онд хянан шийдвэрлэсэн нийт зөрчлийн хэрэг буурсан дүнтэй байгаа хэдий ч шийтгэл оногдуулсан хүн, хуулийн этгээдийн дүн өссөн эсрэг дүн гарчээ. Энэ нь нэг зөрчлийг хэд хэдэн хүн хамтран үйлдсэнтэй холбоотой. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 5.13.2 дахь хэсэгт заасан Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, саад учруулсан зөрчилд нэг хэрэгт хэд хэдэн холбогдогч холбогдсон тохиолдол олон байжээ.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд авч үзвэл Улсын хэмжээнд шийдвэрлэсэн 21946 хэргийн 10166 буюу 46.3 хувийг Улаанбаатар хотод, 11780 хэрэг буюу 53.6 хувийг орон нутгийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн байна. Улаанбаатар хотод буюу 9 дүүргийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн 10166 хэрэг байгаагаас харьяаллын дагуу шийдвэрлэсэн 9686 хэрэг, ЭБАТ-ны шийдвэрийг хянасан 480 хэрэг тус тус байгаа бол орон нутгийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн 11780 хэрэг байгаагаас харьяаллын дагуу шийдвэрлэсэн 11436 хэрэг, ЭБАТ-ны шийдвэрийг хянасан 344 хэрэг тус тус байна.

Хүснэгт 15.Шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн мэдээлэл

№	Шүүх	2020 он			2021 он			Өсөлт, бууралт (тоогоор)		
		Харьяаллын дагуу шийдвэрлэсэн	ЭБАТ-ны шийдвэрийн хянасан	Нийт	Харьяаллын дагуу шийдвэрлэсэн	ЭБАТ-ны шийдвэрийн хянасан	Нийт	Харьяаллын дагуу шийдвэрлэсэн	ЭБАТ-ны шийдвэрийн хянасан	Нийт
1.	Баянзүрх	2838	153	2991	2753	166	2919	-85	13	-72
2.	Сүхбаатар	1491	27	1518	1027	37	1064	-464	10	-454
3.	Чингэлтэй	927	116	1043	784	94	878	-143	- 22	-165
4.	Баянгол	1085	301	1386	1336	43	1379	251	-258	-7
5.	Хан-Уул	1551	74	1625	1381	63	1444	-170	-11	-181
6.	Сонгинохайрхан	1773	45	1818	1889	59	1948	116	14	130
7.	Багануур	248	11	259	248	4	252	-	-7	-7
8.	Багахангай	21	5	26	53	3	56	32	-2	30
9.	Налайх	191	18	209	215	11	226	24	-7	17
Улаанбаатар хот		**10125**	**750**	**10875**	**9686**	**480**	**10166**	**-439**	**-270**	**-709**
10.	Архангай	460	9	469	507	6	513	47	-3	44
11.	Баян-Өлгий	330	15	345	416	20	436	86	5	91
12.	Баянхонгор	525	17	542	701	47	748	176	30	206
13.	Булган	487	22	509	535	22	557	48	-	48
14.	Говь-Алтай	294	17	311	317	11	328	23	-6	17

15.	Говьсүмбэр	141	3	144	253	3	256	112	-	112
16.	Дархан-Уул	319	12	331	416	10	426	97	-2	95
17.	Дорноговь	326	26	352	371	19	390	45	-7	38
18.	Дорнод	487	11	498	429	7	436	-58	-4	-62
19.	Дундговь	136	6	142	197	-	197	61	-6	55
20.	Завхан	437	10	447	481	8	489	44	-2	42
21.	Орхон	1092	13	1105	877	5	882	-215	-8	-223
22.	Өвөрхангай	1712	10	1722	1370	13	1383	-342	3	-339
23.	Өмнөговь	330	63	393	491	29	520	161	-34	127
24.	Сүхбаатар	303	10	313	322	39	361	19	29	48
25.	Сэлэнгэ	440	23	463	606	16	622	166	-7	159
26.	Төв	641	67	708	732	24	756	91	-43	48
27.	Увс	434	32	466	554	23	577	120	-9	111
28.	Ховд	640	30	670	534	11	545	-106	-19	-125
29.	Хөвсгөл	557	6	563	755	16	771	198	10	208
30.	Хэнтий	669	15	684	572	15	587	-97	0	-97
Орон нутаг		**10760**	**417**	**11177**	**11436**	**344**	**11780**	**676**	**-73**	**603**
Улсын хэмжээнд		**20885**	**1167**	**22052**	**21122**	**824**	**21946**	**237**	**-343**	**-106**

2021 онд Өвөрхангай аймгийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оноос 339-өөр буурсан нь орон нутгийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн хэргийн тоо хамгийн ихээр буурсан дүн хэдий ч тус онд өмнөх жилийн мөн адил хамгийн их хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг болжээ. Харин Хөвсгөл аймгийн хэмжээнд хянан шийдвэрлэсэн хэргийн тоо 2021 онд өнгөрсөн оноос 208-аар нэмэгдсэнээр хянан шийдвэрлэсэн хэрэг хамгийн ихээр нэмэгдсэн аймаг болсон байна.

Хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн дүнгээр дүүргийн шүүхийн дундаж нь аймаг дахь сум дундын шүүхээс 2.4 дахин, сум дахь сум дундын шүүхээс 5 дахин их байна.

Улсын хэмжээнд 2021 онд нийт хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг өмнөх онтой харьцуулахад 0.5 хувиар буурсан дүнтэй байх ба ЭБАТ-ны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хянасан хэрэг 29.4 хувиар буурсан нь нөлөөлжээ.

3.2.Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг

2021 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд 537 зөрчлийн хэрэг хүлээн авч, 58 хэргийг хүлээн авахаас татгалзан буцааж, 468 хэргийг хянан шийдвэрлэж, тус жилийн тайлант хугацааны төгсгөлд 19 хэргийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 16.Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг

№	Зөрчлийн хэргийн төрөл	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	Хувь
1.	Гомдол эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн	225	251	26	11.6
2.	Шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон	33	35	2	6.1
3.	Шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаасан	62	73	11	17.7
4.	Албадлагын арга хэмжээг хөнгөрүүлж эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан	80	109	29	36.3
Нийт шийдвэрлэсэн хэрэг		**400**	**468**	**68**	**17**

Дээрх хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргээс 251 хэрэг буюу 53.6 хувьд нь гомдол эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, 35 хэрэг

буюу 7.5 хувьд нь шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож, 73 хэрэг буюу 15.6 хувьд нь шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцааж, 109 буюу 23.3 хувьд нь албадлагын арга хэмжээг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 17. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн тоо

№	Шүүх	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Архангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	14	14	-	-
2	Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	12	18	6	50.0
3	Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	8	16	8	2 дахин
4	Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	12	14	2	16.7
5	Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	14	14	-	-
6	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	3	2	-1	-33.3
7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	17	16	-1	-5.9
8	Дорноговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	12	20	8	66.7
9	Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	12	2	-10	-6 дахин
10	Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	11	10	11 дахин
11	Завхан аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	11	19	8	72.7
12	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	16	23	7	43.7
13	Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	8	5	-3	-37.5
14	Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	11	5	-6	-54.5
15	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	5	10	5	2 дахин
16	Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	38	35	-3	-7.9
17	Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	6	9	3	50.0
18	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	9	19	10	2.1
19	Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	19	29	10	52.6
20	Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	19	19	-	-
21	Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	17	21	4	23.5
22	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	136	147	11	8.1

Давж заалдах шатны зарим шүүх 2021 онд зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн дүн өмнөх онтой адил байна. Харин Баянхонгор, Дундговь, Сүхбаатар аймаг дахь давж заалдах шатны шүүхийн хувьд хянан шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн дүн огцом өсжээ.

Орон нутгийн хэмжээнд дунджаар 15.2 зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн бол Нийслэл дэх эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс 147 хэрэг хянан шийдвэрлэсэн нь орон нутгийн дунджаас 9.6 дахин их байна.

4.Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Шүүхийн ерөнхий зөвлөл БНТУ-ын Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг, Хууль зүйн академитай хамтран 2021 оны 05 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан байна. Сургалтад Улсын Дээд шүүхийн шүүгч Д.Эрдэнэбалсүрэн, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Батзориг, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Базарханд, Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ц.Эрдэнэчимэг, Хэнтий аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Дэнсмаа нар оролцсон. Сургалтын хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа, прокурор, шүүхийн шатанд энэ төрлийн гэмт хэргийг хэрхэн шалгаж, хянан шийдвэрлэж байгаа олон улсын туршлагыг судалсан.

Мөн 2021 онд Азийн сангаас хэрэгжүүлж буй “Хууль бус уул уурхайн гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам” төслийн ажлын хэсэгт ажиллаж, сургалтын гарын авлага бэлтгэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад Шүүхийн ерөнхий зөвлөлөөс оролцож, тодорхой сэдвүүдийн хүрээнд лекцүүдийг бэлтгэн гарын авлагыг хэвлэлтэд шилжүүлсэн байна.

2021 онд Нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан сар бүр шүүн таслах ажлын мэдээ, мэдээлэл солилцож гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг улирал бүр зохион байгуулсан байна.

Түүнчлэн, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Дорноговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Ховд аймгийн Булган сум дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд тус онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтуудыг тодорхой сэдвийн хүрээнд амжилттай зохион байгуулжээ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ – CORRECTION

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ХОРИХ ЯЛЫН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ
3. ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛЫН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ
4. БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ
5. ЦАГДАН ХОРИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ







ЯЛ ЭДЭЛСЭН ХОРИГДЛЫН ТОО **3044** -32.2%

ЭРЭГТЭЙ **2877** -31.5%

ЭМЭГТЭЙ **167** -42.0%

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДИЙН ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ

 **3018**

 **15**

 **3**

 **2**



БАРИВЧЛАГДСАН ЭТГЭЭД +8.8% **6074**

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ **402**

ЭРХ ХАСАХ ЯЛ **474**

НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ **1364**

ТОРГОХ **6617**

Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	**3652**	үлдэгдэл 495
Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон	**1596**	үлдэгдэл 1147
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	**242**	үлдэгдэл 76
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	**17**	үлдэгдэл 36
Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан	**808**	үлдэгдэл 508
Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан	**195**	үлдэгдэл 74
Эрх хасах албадлагын арга хэмжээ авагдсан	**2**	үлдэгдэл 2

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2021 оны үйл ажиллагааны товч танилцуулга

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өнгөрсөн 100 жилийн хугацаанд 1921 оноос гяндан салаа, 1936 оноос Улсын төв засан сайжруулах газар, 1940 оноос Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагерууд ба Хорих ангиудыг удирдах газар, 1956 оноос Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтэс, 1963 оноос Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газар, 1981 оноос Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газар, 1992 оноос Монгол Улсын Хорих байгууллагуудыг удирдах газар, 1996 оны 12 дугаар сараас Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, 2002 оноос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар гэж тус тус нэрлэгдэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харъяалал нь 1921 оноос Шүүх яам, 1936 оноос Дотоод явдлын яам, 1985 оноос НАХЯ-ны Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газарт, 1991 оноос Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдан төрөөс хүлээлгэсэн онцгой, хариуцлагатай үүргээ нэр төртэйгээр биелүүлэн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хорих ял эдлүүлэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, хорих анги, аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс бүрдэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын боловсон хүчний бодлого боловсруулах, алба хаагчийг сургаж бэлтгэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа, түүнийг боловсронгуй болгох чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн талаар санал боловсруулах;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд холбогдох журам, стандарт, заавар, зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, биелэлтийг хангуулах;

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг улсын хэмжээгээр нэгтгэн зохион байгуулж, дүн шинжилгээ хийх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг нэгдсэн удирдлагаар хангах харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээ авах;

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүү, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;

6. Хорих ангийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцөлийг арилгах, дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах;

8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, мэдээлэл дамжуулах болон бусад хяналтын систем нэвтрүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

9. Гадаад улсын ижил төрлийн байгууллагатай харилцах;

10. Шаардлагатай мэдээллийн сан үүсгэх, ашиглах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;

11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

12. Ялтан, хоригдлын зүгээс алба хаагч руу чиглэсэн сөрөг үзэгдлийг таслан зогсоох, шалгах, хариуцлага тооцох орчинг бүрдүүлэх;

13. Хорих байгууллагад онцгой нөхцөл байдал бий болсон үед таслан зогсоох арга хэмжээ авах зэрэг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ, конвенц, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврын хүрээнд ажиллалаа.

Улсын хэмжээнд нээлттэй хорих анги 7, хаалттай хорих анги 5, нээлттэй, хаалттай хорих анги 5, өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага 1, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 2, эмэгтэйчүүдийн хорих анги 1, нийт 21 хорих анги, баривчлах төв 1, баривчлах байр 1, Нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 28 цагдан хорих байр үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2021 онд ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр дараах онцлох ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

1. Монгол Улсын Их хурлаас Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Өршөөл үзүүлэх тухай хуулийг баталсан. Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар “Ажлын хэсэг” байгуулан зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг ханган ажилласан.

2. Төрийн үйлчилгээний цахим машин, төрийн үйлчилгээний нэгдсэн портал и-монголиа сайтаас сулдлагдсан иргэд лавлагаа мэдээллээ авах боломжийг бүрдүүллээ. Өнөөдрийн байдлаар 10 мянга гаруй иргэний суллагдсан мэдээллийг цахим санд оруулсан.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа орон нутаг дахь нийт 26 шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн цагдан хорих байруудад тоон технологийн Hikvision загварын телехяналтын системийг дагалдах техник, тоног төхөөрөмжийн хамт суурилууллаа. Ингэснээр хоригдол, хоригдогчдын дундаас гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, баримтжуулах болон алба хаагчдын аюулгүй байдал хангагдах нөхцөл бүрдлээ.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох, шүүхийн шийдвэр биелэгдэх зарчмыг бодитой хэрэгжүүлэх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх зэрэг зарчмын өөрчлөлтийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн баталж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

5. “Хоригдолд зохион байгуулах сургалтын жишиг хөтөлбөр”-ийг шинэчлэх ажлын хүрээнд “Дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын харилцааны түвшинг нийгэмшүүлэх үйл ажиллагаатай холбон судлах” судалгааны ажлыг зохион байгуулж, гарсан үр дүнг үндэслэн “Хорих ял эдлэх үеийн сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулсан.

6. Аймаг, нийслэлийн төвөөс бусад сум, алслагдсан газарт 5 жил тасралтгүй ажилласан алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох талаар зохицуулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэн батлууллаа. Ингэснээр 12 анги, байгууллагын 600 гаруй алба хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрджээ.

7. Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх чиглэл өгсний дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь уг ялыг эдлүүлэн, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэгдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэхэд гэр бүл, найз нөхөд, байгууллага, олон түмний оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мэдээллийн технологийг ашиглаж, цахим хэлбэрээр ял эдлүүлэх болсноор өртөг зардлыг бууруулсан, иргэдийн амгалан тайван байдал хангагдаж, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гарах зэрэг нийгмийн эерэг үр дагаврууд бий болж, Монгол Улсын Эрүүгийн ял шийтгэлийн бодлогод эрс шинэчлэлийг авчирсан алхам

хийгдсэн юм. Тус ялын хэрэгжилтийг хангаж эхэлснээс хойш 1600 орчим ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж, 402 ялтны ялыг эдлүүлж, дуусгавар болгосон бөгөөд хяналтад байгаа ялтны 52 хувь нь нийслэлд, 48 хувь нь орон нутагт байна.

2.Хорих ялын гүйцэтгэл

2021 онд нийт 3044 хоригдол хорих ял эдэлсэн нь 2020 онд хорих ял эдэлсэн хоригдлын тоотой харьцуулахад 1445 буюу 32.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1.Хорих ял эдлэгсдийн судалгаа:

д/д	Өсөлт, бууралт			
	2020	2021	тоо	хувь
1.	4489	3044	1445	-32.2%

2021 онд нийт хорих ял эдлэгсдийн 94.5 хувь буюу 2877 хоригдол нь эрэгтэй, 5.5 хувь буюу 167 нь эмэгтэй хоригдол байна.

Хүснэгт 2.Хорих ял эдлэгсдийн хүйсийн судалгаа:

д/д	Хүйс	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	эрэгтэй	4201	2877	-1324	-31.5
2.	эмэгтэй	288	167	-121	-42

2021 онд нийт хоригдлын боловсролыг судлахад 328 хоригдол дээд /доктор, магистр, дипломын дээд/ боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 130 буюу 28.4 хувиар, 152 хоригдол тусгай мэргэжлийн дунд боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 67 буюу 30.6 хувиар тус тус буурсан, 11 хоригдол техникийн болон мэргэжлийн боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 3 буюу 37.8 хувиар өссөн, 977 хоригдол бүрэн дунд боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 540 буюу 35.6 хувиар, 765 хоригдол суурь боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 396 буюу 34.1 хувиар, 431 хоригдол бага боловсролтой байсан нь урьд оныхтой харьцуулахад 151 буюу 25.9 хувиар, 380 хоригдол ямар нэг боловсролгүй байсан нь урьд оныхтой харьцуулахад 164 буюу 30.1 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 3.Хорих ял эдлэгсдийн боловсролын судалгаа:

д/д	Боловсролын зэрэг	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	Дээд /доктор, магистр, дипломын дээд/	458	328	-130	-28.4
2.	Тусгай мэргэжлийн дунд	219	152	-67	-30.6
3.	Техникийн болон мэргэжлийн	8	11	3	37.5
4.	Бүрэн дунд	1517	977	-540	-35.6
5.	Суурь	1161	765	-396	-34.1
6.	Бага	582	431	-151	-25.9
7.	Боловсролгүй	544	380	-164	-30.1

Хорих байгууллагад хоригдож буй хоригдлуудын нийт эдлэх ялын хугацааг судлан үзэхэд дийлэнх нь буюу 31.3 хувь нь 0-5 жил хүртэл хоригдох хугацаатай байгаа ба 20 ба түүнээс дээш жил хорих ял эдлэх хоригдлын тоо 10 буюу 5.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4.Хорих ял эдлэх хугацааны судалгаа:

д/д	Эдлэх хорих ялын хугацаа	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	0-1 жил	678	177	-501	-73.9
2.	2 жил	644	192	-452	-70.2
3.	3 жил	494	202	-292	-59.1
4.	4 жил	305	199	-106	-34.8
5.	5 жил	305	182	-123	-40.3
6.	6 жил	244	252	8	3.3
7.	7 жил	131	130	-1	-0.8
8.	8 жил	267	250	-17	-6.4
9.	9 жил	105	118	13	12.4
10.	10 жил	144	160	16	11.1
11.	11 жил	56	58	2	3.6
12.	12 жил	226	219	-7	-3.1
13.	13 жил	164	167	3	1.8
14.	14 жил	85	82	-3	-3.5
15.	15 жил	122	140	18	14.8
16.	16 жил	145	133	-12	-8.3
17.	17 жил	37	48	11	29.7
18.	18 жил	91	97	6	6.6
19.	19 жил	49	51	2	4.1
20.	20 ба түүнээс дээш	197	187	-10	-5.1

Нийт хорих ял эдлэгсдийн 35.4 хувь нь хүний амьд явах эрхийн эсрэг, 27.1 хувь нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 23.5 хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хоригдлууд эзэлж байна.

Хүснэгт *5.Хорих ял эдлэгсдийн ял шийтгэгдсэн зүйлчлэлийн судалгаа*

д/д	Гэмт хэргийн зүйлчлэл	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	хүний амьд явах эрхийн эсрэг	1160	1079	-81	-7
2.	хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	468	271	-197	-42.1
3.	хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	763	824	61	-8
4.	хүний халдашгүй, чөлөөт байх эрхийн эсрэг	24	22	-2	-8.3
5.	эрүүл мэндийн эсрэг	2	0	-2	-100
6.	хүүхдийн эсрэг	0	2	2	100
7.	өмчлөх эрхийн эсрэг	1691	716	-975	-57.7
8.	эдийн засгийн	17	23	6	35.3
9.	үндэсний аюулгүй байдлын эсрэг	6	9	3	50
10.	олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	193	44	-149	-77.2
11.	хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг	3	0	-3	100
12.	авлигын	28	10	-18	-64.3
13.	нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг	3	2	-1	-33.3
14.	хүрээлэн байгаа орчны эсрэг	15	1	-14	-94.3

15.	соёлын өвийн эсрэг	0	0	0	0
16.	кибер аюулгүй байдлын эсрэг	0	0	0	0
17.	хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	116	40	-76	-65.5
18.	цэргийн албаны эсрэг	0	1	1	100

Нийт хорих ял эдлэгсдийн 46 хувь Улаанбаатар хотын харьяат байна.

Хүснэгт *6.Хорих ял эдлэгсдийн орон нутгийн харьяаллын судалгаа*

д/д	Орон нутаг	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	Архангай	129	70	-59	-45.7
2.	Баянхонгор	148	96	-52	-35.1
3.	Баян-Өлгий	53	32	-21	-39.6
4.	Булган	80	73	-7	-8.8
5.	Говь-Алтай	69	50	-19	-27.5
6.	Дорнод	196	142	-54	-27.6
7.	Дорноговь	108	66	-42	-38.9
8.	Дундговь	74	44	-30	-40.5
9.	Завхан	115	60	-55	-47.8
10.	Өвөрхангай	139	100	-39	-28.1
11.	Өмнөговь	87	59	-28	-32.2
12.	Сүхбаатар	83	60	-23	-27.7
13.	Сэлэнгэ	195	132	-63	-32.3
14.	Төв	195	105	-90	-46.2
15.	Хөвсгөл	140	84	-56	-40
16.	Хэнтий	166	106	-60	-36.1
17.	Ховд	76	41	-35	-46.1
18.	Увс	120	60	-60	-50
19.	Говьсүмбэр	29	23	-6	-20.7
20.	Дархан-Уул	183	123	-60	-32.8
21.	Орхон	152	89	-63	-41.4
22.	Улаанбаатар	1933	1401	-532	-27.5

Нийт хорих ял эдлэгсдийн 47.5 хувь нь анх удаа ял шийтгэгдсэн, 52.5 хувь нь хоёр ба түүнээс дээш удаа ял шийтгэгдсэн хоригдлууд байна.

Хүснэгт 7. Хорих ял эдлэгсдийн шүүхээр хэдэн удаа ял шийтгүүлсэн талаарх судалгаа

д/д	Хэдэн удаа	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	Анх удаа	2115	1446	-669	-31.6
2.	2 удаа	1011	634	-377	-37.3
3.	3 удаа	548	331	-217	-39.6
4.	4 удаа	299	213	-86	-28.8
5.	5 удаа	205	169	-36	-17.6
6.	6 удаа	144	106	-38	-26.4
7.	7 удаа	79	60	-19	-24.1
8.	8 удаа	43	43	0	0
9.	9 удаа	24	20	-4	-16.7
10.	10 удаа	11	12	1	9.1
11.	10-аас дээш удаа	10	10	0	0

2021 онд гадаад улсын харьяат 26 хоригдол ял эдэлснээс дийлэнх нь БНХАУ, ОХУ, БНСУ-ын иргэн байжээ.

Хүснэгт 8. Хорих ял эдлэгсдийн иргэний харьяалал:

д/д	Харьяалал	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	Монгол Улс	4470	3018	-1452	-32.5
2.	БНХАУ	6	15	9	9 нэгжээр өссөн
3.	ОХУ	5	3	-2	-40
4.	БНСУ	0	2	2	2 нэгжээр өссөн
5.	Бусад улс	8	6	-2	-25

2021 онд ШШГЕГ-ын харьяа хорих анги, цагдан хорих байрнаас 2 хоригдол оргосон нь урьд оноос 2 буюу 50 хувиар буурсан байна.

Хүснэгт 9. Хорих анги, цагдан хорих байрнаас хоригдол, хоригдогч оргосон судалгаа

д/д	оргодлын тоо	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.		4	2	-2	-50

3.Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл

3.1.Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн дараах ялыг гүйцэтгэж байна. Үүнд:

1. Торгох ял;
2. Нийтэд тустай ажил хийлгэх ял;
3. Зорчих эрхийг хязгаарлах ял;
4. Эрх хасах ял;
5. Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх.

Хүснэгт 10. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний гүйцэтгэл:

Шүүхийн шийдвэрийн төрөл			Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
				2020	2021	2020	2021	2020	2021
1. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн			Нийт ялтны тоо	12158	12945	9192	9376	2966	3569
Үүнээс:	Торгох ял шийтгүүлсэн	Хүнд	ялтны тоо	8296	7659	6976	6617	1320	1042
			мөнгөн дүн	10927354.5	11924432.8	6588610.7	8515044.4	4338743.8	3409388.4
		Хуулийн этгээдэд	тоо	5	4	4	2	1	2
			мөнгөн дүн	195000.0	250240.0	104760.0	116240.0	90240.0	134000.0
	Зорчих эрхийг хязгаарлах ял		ялтны тоо		1602		402		1200
			хоног		767211		256811.0		510400.0
	Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн		ялтны тоо	2114	1647	1742	1364	372	283
			цаг	675210	540117	575733	459755	99477	80362
			ялтны тоо	1743	2033	470	991	1273	1042

	Эрх хасах ял шийтгүүлсэн	хоног	1166794	1452545	454007	678429	712787	774116

3.1.1.Торгох ялыг нэг зуун нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг (нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү) байхаар шүүх тогтоох ба шүүхийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, хэрэв хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй байдаг. Хэрэв шүүхээс оногдуулсан торгуулийг төлөөгүй тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ялтны хөрөнгөөс албадан гаргуулах журмаар гүйцэтгэж байна.

Хүснэгт 11. Торгох ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2020 он			2021 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	
			Нийт	Үүнээс ял сольсон		Нийт	Үүнээс ял сольсон
1.	Архангай	172	152	2	163	147	2
2.	Баян-Өлгий	168	133		119	97	1
3.	Баянхонгор	198	155		183	160	1
4.	Булган	150	131		128	105	2
5.	Говь-Алтай	71	65		87	70	2
6.	Говьсүмбэр	81	64		81	76	
7.	Дархан-Уул	376	325	11	273	234	4
8.	Дорноговь	69	48	1	85	76	1
9.	Замын-Үүд	66	52	1	78	60	
10.	Дорнод	264	217	4	286	259	5
11.	Дундговь	98	89	1	84	79	
12.	Завхан	91	75		80	73	
13.	Тосонцэнгэл	40	36		35	30	1
14.	Орхон	290	246	1	213	184	1
15.	Өвөрхангай	172	142	3	92	80	
16.	Өмнөговь	142	108	1	105	100	1
17.	Сүхбаатар	132	118		119	116	
18.	Сэлэнгэ	127	113	6	99	83	1
19.	Хөтөл	37	32		29	22	1
20.	Төв	231	200	10	245	228	1
21.	Увс	105	81		93	82	
22.	Ховд	138	121	1	180	157	
23.	Хөвсгөл	229	214	2	201	196	1
24.	Хэнтий	169	148	10	182	146	2
25.	НШШГГ	4254	3567	86	3983	3360	43
26.	Налайх	144	116	2	133	113	2
27.	Багануур	114	81	4	106	99	3
28.	Хархорин	53	48		53	50	
29.	Мандал	79	68		98	91	
30.	Ханбогд	36	31		46	44	
ДҮН		8296	69	146	7659	661	75

3.1.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нийтэд тустай ажил хийлгэх ялыг гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлсгүйгээр хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар хийлгэх үйл явцад хяналт тавин, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүснэгт 12. Нийтэд тустай ажил хийлгэх ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2020 он			2021 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	
			Нийт	Үүнээс ял сольсон		Нийт	Үүнээс ял сольсон
1.	Архангай	65	57	7	36	34	3
2.	Баян-Өлгий	50	39	2	31	30	3
3.	Баянхонгор	64	53	5	45	41	3
4.	Булган	32	24	5	25	23	5
5.	Говь-Алтай	16	14	3	10	10	1
6.	Говьсүмбэр	20	20	10	9	8	
7.	Дархан-Уул	94	81	27	43	38	9
8.	Дорноговь	29	24	3	18	17	6
9.	Замын-Үүд	13	11	1	10	7	1
10.	Дорнод	62	50	5	67	51	7
11.	Дундговь	22	20	8	12	12	1
12.	Завхан	22	18	1	18	15	
13.	Тосонцэнгэл	6	5		3	3	
14.	Орхон	44	40	7	41	39	8
15.	Өвөрхангай	24	20	8	19	18	1
16.	Өмнөговь	28	21	1	16	15	2
17.	Сүхбаатар	30	29	10	11	10	1
18.	Сэлэнгэ	20	20	5	6	4	1
19.	Хөтөл	12	11	3	4	4	
20..	Төв	56	48	14	46	38	1
21.	Увс	43	36	2	36	33	2
22.	Ховд	17	16	1	12	12	
23.	Хөвсгөл	85	76	8	38	37	1
24.	Хэнтий	72	60	18	52	37	2
25.	НШШГГ	1055	833	187	959	753	112
26.	Налайх	64	62	14	34	31	1
27.	Багануур	25	19	7	20	20	3
28.	Хархорин	28	22	5	19	17	3
29.	Мандал	15	13	3	4	4	1
30	Ханбогд	1			3	3	
ДҮН		**1525**	**341**	**370**	**1647**	**1364**	**178**

3.1.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхээс оногдуулсан нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хориглосон шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 13. Эрх хасах ялын гүйцэтгэлийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2020 он			2021 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл
1.	Архангай	42	10	32	42	10	32
2.	Баян-Өлгий	48	8	40	48	8	40
3.	Баянхонгор	38	14	24	38	14	24
4.	Булган	23	10	13	23	10	13
5.	Говь-Алтай	20	2	18	20	2	18
6.	Говьсүмбэр	27	6	21	27	6	21
7.	Дархан-Уул	56	19	37	56	19	37
8.	Дорноговь	26	12	14	26	12	14
9.	Замын-Үүд	26	8	18	26	8	18
10.	Дорнод	80	22	58	80	22	58
11.	Дундговь	21	7	14	21	7	14
12.	Завхан	17	5	12	17	5	12
13.	Тосонцэнгэл	9	3	6	9	3	6
14.	Орхон	59	22	37	59	22	37
15.	Өвөрхангай	40	11	29	40	11	29
16.	Өмнөговь	38	9	29	38	9	29
17.	Сүхбаатар	30	5	25	30	5	25
18.	Сэлэнгэ	32	7	25	32	7	25
19.	Хөтөл	14	3	11	14	3	11
20.	Төв	34	11	23	34	11	23
21.	Увс	27	6	21	27	6	21
22.	Ховд	42	17	25	42	17	25
23.	Хөвсгөл	68	21	47	68	21	47
24.	Хэнтий	35	10	25	35	10	25
25.	НШШГГ	808	196	612	808	196	612
26.	Налайх	33	12	21	33	12	21
27.	Багануур	12	4	8	12	4	8
28.	Хархорин	13	6	7	13	6	7
29.	Мандал	17	7	10	17	7	10
30.	Ханбогд	8	1	7	8	1	7
	Дүн	**1743**	**474**	**1269**	**1743**	**474**	**1269**

3.1.4.Шүүхээс оногдуулсан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнссэн шийдвэрийг гүйцэтгэхдээ ялтны түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, нэгж хяналт тавьж байна.

Хүснэгт 14. Тэнссэн этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2020 он				2021 он			
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн	Одоо хяналтад байгаа	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн	Одоо хяналтад байгаа
1.	Архангай	60	2		77	114			11
2.	Баян-Өлгий	32		1	48	69	1	3	6

3.	Баянхонгор	68	2		103	136	1		38
4.	Булган	45	2	1	54	81			26
5.	Говь-Алтай	21	1		46	54		1	18
6.	Говьсүмбэр	8			19	23			3
7.	Дархан-Уул	72	1	7	101	149		4	21
8.	Дорноговь	24			18	32			5
9.	Замын-Үүд	26	1		30	36	1		6
10.	Дорнод	113		2	88	139		1	12
11.	Дундговь	31	1		29	44			7
12.	Завхан	36		1	33	63			4
13.	Тосонцэнгэл	11			15	36			2
14.	Орхон	71			86	125		1	11
15.	Өвөрхангай	64		2	62	82		1	18
16.	Өмнөговь	48		1	43	53			5
17.	Ханбогд	6			9	24			0
18.	Сүхбаатар	47	3	1	53	105	1	1	4
19.	Сэлэнгэ	45		2	55	74			9
20.	Хөтөл	16	1		24	28			6
21.	Төв	50	2	2	73	110	1		17
22.	Увс	20			39	47			21
23.	Ховд	53	2	1	55	114		1	21
24.	Хөвсгөл	88	1	2	142	173			33
25.	Хэнтий	44	3	3	82	102		3	10
26.	НШШГГ	754	34	26	976	1453	14	13	141
27.	Налайх	18			30	57			7
28.	Багануур	17		1	27	38			2
29.	Хархорин	24		1	29	48	1		10
30.	Мандал	36	2	1	28	43			21
Дүн		**75**	**2229**	**55**	**2474**	**3652**	**20**	**29**	**495**

3.2.Албадлагын арга хэмжээний гүйцэтгэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Эрүүгийн хуульд заасан дараах албадлагын арга хэмжээг гүйцэтгэж байна. Үүнд:

1. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
3. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ;
4. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах;
5. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ.

Албадлагын арга хэмжээний төрөл		Хэмжих нэгж	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
			2020	2021	2020	2021	2020	2021
			8770	8850	4461	6512	4309	2338
Үүнээс:	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	этгээдийн тоо	4422	4147	1948	3652	2474	495
	Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан	этгээдийн тоо	433	269	246	195	187	74

	Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон	этгээдийн тоо	2512	2743	1415	1596	1097	1147
	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	этгээдийн тоо	368	318	176	242	192	76
	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан	этгээдийн тоо	71	53	34	17	37	36
	Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан	этгээдийн тоо	961	1316	641	808	320	508
	Эрх хасах албадлагын арга хэмжээ авагдсан	хуулийн этгээдийн тоо	3	4	1	2	2	2

3.2.1.Шүүхээс анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулсан шийдвэрийг ялтны оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас хяналт тавиж хэрэгжүүлж байна.

Хүснэгт 15. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2020 он			2021 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1	Архангай	4			0		
2	Баян-Өлгий				0		
3	Баянхонгор	7			8		
4	Булган	3			3		
5	Говь-Алтай	8	1		5		
6	Говьсүмбэр	1			1		
7	Дархан-Уул	4			10		
8	Дорноговь	4			2		
9	Замын-Үүд	2			0		
10	Дорнод	12			7		
11	Дундговь	4			1		1
12	Завхан				0		
13	Тосонцэнгэл	3			2		
14	Орхон	10		3	2		
15	Өвөрхангай	1			1		
16	Өмнөговь	3			1		
17	Ханбогд				2		
18	Сүхбаатар	4			0		

19	Сэлэнгэ	5		1	11		
20	Хөтөл	1			1		
21	Төв	1			4		
22	Увс	4			7		
23	Ховд	26		1	6		1
24	Хөвсгөл	3			1		
25	Хэнтий				3		
26	НШШГГ	113		2	109	1	11
27	Налайх	1			2		
28	Багануур	9		1	3		1
29	Хархорин	3		1	1		
30	Мандал	10		1	2		
Дүн		**246**	**1**	**10**	**195**	**1**	**14**

3.2.2.Хорих анги нь хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийн талаарх тодорхойлолтыг шүүгчийн захирамжийн хамт түүний оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлж, тухайн алба хяналтыг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 16. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2020 он			2021 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1.	Архангай	37		1	56		
2.	Баян-Өлгий	29		2	31		
3.	Баянхонгор	51		3	54		5
4.	Булган	35		2	16		
5.	Говь-Алтай	22	1	1	17		
6.	Говьсүмбэр	11			17		
7.	Дархан-Уул	73		4	71		3
8.	Дорноговь	24		1	28		2
9.	Замын-Үүд	14			15		
10.	Дорнод	44			49		
11.	Дундговь	12			12		1
12.	Завхан	16		3	17		
13.	Тосонцэнгэл	7		1	11		
14.	Орхон	56	1	1	56		2
15.	Өвөрхангай	20			23		
16.	Өмнөговь	29		1	28		
17.	ханбогд	1			6		
18.	Сүхбаатар	30	1		34		1
19.	Сэлэнгэ	25		1	30		
20.	Хөтөл	7			15		
21.	Төв	43			45		1
22.	Увс	27.		1	39		

23.	Ховд	43		1	26		
24.	Хөвсгөл	66		1	62		
25.	Хэнтий	49	4	3	37	1	1
26.	НШШГГ	574	2	10	727	1	17
27.	Налайх	10			28		
28.	Багануур	11			14		1
29.	Хархорин	16			12		
30.	Мандал	33			20		
	ДҮН	**1415**	**9**	**37**	**1596**	**2**	**34**

3.2.3.Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэсэн шийдвэрийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэх ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, нэгдсэн тоо бүртгэл хөтөлж байна.

Хүснэгт 17. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2020 он			2021 он		
		Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	Нийт	Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн
1.	Архангай	2			12		
2.	Баян-Өлгий	5			16		
3.	Баянхонгор	5			11		
4.	Булган	5			3		
5.	Говь-Алтай	6			3		
6.	Говьсүмбэр	3			1		
7.	Дархан-Уул	10		1	25		3
8.	Дорноговь	4			8		
9.	Замын-Үүд				3		
10.	Дорнод	3			3		
11.	Дундговь	3		2	5		
12.	Завхан				1		
13.	Тосонцэнгэл	2			2		
14.	Орхон	5			7		
15.	Өвөрхангай	5			8		
16.	Өмнөговь	7			5		
17.	Ханбогд	1			1		
18.	Сүхбаатар	2			3		
19.	Сэлэнгэ	9		1	9		
20.	Хөтөл				0		
21.	Төв	1			0		
22.	Увс	6			8		
23.	Ховд	3			0		

24.	Хөвсгөл	4			5		
25.	Хэнтий	13		1	10		
26.	НШШГГ	65		3	84	1	1
27.	Налайх	2			3		
28.	Багануур				4		1
29.	Хархорин	4			1		
30.	Мандал	1			1		
	Дүн	**176**	**0**	**8**	**242**	**1**	**5**

3.2.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.

Хүснэгт 18. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа (аймаг, орон нутгаар)

Д/д	Үзүүлэлт	2020 он			2021 он		
		Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Одоо хяналтад байгаа	Гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Одоо хяналтад байгаа
1.	Архангай	93	80	13	93	70	23
2.	Баян-Өлгий	56	38	18	77	35	42
3.	Баянхонгор	92	53	39	126	71	55
4.	Булган	41	18	23	60	39	21
5.	Говь-Алтай	17	9	8	74	37	37
6.	Говьсүмбэр	0		0	0		0
7.	Дархан-Уул	33	14	19	56	30	26
8.	Дорноговь	15	7	8	15	6	9
9.	Замын-Үүд	19	14	5	18	9	9
10.	Дорнод	66	30	36	122	57	65
11.	Дундговь	2	1	1	12	5	7
12.	Завхан	19	12	7	45	31	14
13.	Тосонцэнгэл	15	12	3	24	21	3
14.	Орхон	17	12	5	23	17	6
15.	Өвөрхангай	12	4	8	32	25	7
16.	Ханбогд				0		
17.	Өмнөговь	0		0	0		0
18.	Сүхбаатар	38	33	5	25	23	2
19.	Сэлэнгэ	61	35	26	47	38	9
20.	Хөтөл	19	17	2	14	9	5
21.	Төв	0		0	0		0
22.	Увс	76	48	28	117	80	37
23.	Ховд	36	32	4	45	30	15
24.	Хөвсгөл	66	58	8	80	63	17
25.	Хэнтий	66	34	32	88	34	54
26.	НШГА	4	3	1	39	19	20
27.	Налайх	0		0	0		0
28.	Багануур	0		0	0		0
29.	Хархорин	73	55	18	64	51	13
30.	Мандал	25	22	3	20	8	12
	Дүн	**961**	**641**	**320**	**1316**	**808**	**508**

Хүснэгт 19. *Хуулийн этгээдэд эрх хасах, татан буулгах албадлагын арга хэмжээ авсан судалгаа*

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 он			2021 он		
			Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан
1	Баянхонгор	Этгээдийн тоо	1	1	1	1	2	1
2	Хэнтий	Этгээдийн тоо	0	1		1		1
ДҮН			**1**	**2**	**1**	**2**	**2**	**2**

Хүснэгт 20. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдийн судалгаа

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 он			2021 он		
			Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан
1	НШШГГ	Этгээдийн тоо	44	27	34	37	16	17
ДҮН			**44**	**27**	**34**	**37**	**16**	**17**

4.Баривчлах шийтгэлийн гүйцэтгэл

Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулах баривчлах шийтгэлийг Улаанбаатар хотод шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэж байна.

Хүснэгт 21. Баривчлагдсан этгээдийн судалгаа (Улаанбаатар хотын хэмжээнд)

д/д	шийтгэлийн төрөл	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	баривчлагдсан этгээд	5584	6074	490	8.8

Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйл. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 5.2 дугаар зүйл. Танхайрах, 5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 5.8 дугаар зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих, 6.20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг зөрчих, 6.26 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах, 8.6 дугаар зүйл. Хулгайлах, 8.7 дугаар зүйл. Хөрөнгө завших, 14.7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зэрэг зөрчилд баривчлах шийтгэл ногдуулахаар заасан.

Хүснэгт 22. Баривчлагдсан этгээдүүдийн үйлдсэн зөрчлийн судалгаа (Улаанбаатар хотын хэмжээнд)

д/д	Зөрчлийн тухай хуулийн заалт	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	Танхайрах /ЗТХ-5.2.1 олон нийтийн газар/	365	93	-272	-74.5
2.	Мансуурах /ЗТХ-5.1.3/	51	59	8	15.7
3.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих /ЗТХ-5.4.4/	4029	1932	-2097	-52
4.	Хулгайлах /ЗТХ-8.6.1/	390	111	-279	-71.5
5.	Хөрөнгө завших /ЗТХ-8.7.1/	2	0	-2	2 нэгжээр буурсан
6.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /ЗТХ-14.7.5 эрхгүй үедээ согтуугаар/	732	611	-121	-16.5
7.	Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих /ЗТХ-5.13.2/	10	34	24	24 нэгжээр өссөн
8.	Хүүхдийн эрх зөрчих /6.20.6/	5	3	-2	-40

5.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй зэрэг үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг гүйцэтгэлийг ШШГЕГ-ын харьяа цагдан хорих төв, байрууд хэрэгжүүлж байна.

Хүснэгт 23. Цагдан хоригдсон хоригдогсдын судалгаа

д/д	Цагдан хорих байр	өсөлт, бууралт			
		2020	2021	тоо	хувь
1.	Хоригдогч	1169	1399	230	19.7

ТАВДУГААР БҮЛЭГ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР -ANTI CORRUPTION

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2. ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

3. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА

4. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ

5. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКС, БАЙГУУЛЛАГА САЛБАРААР

6. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ





110 ТУСГАЙ ДУГААРТ **269** ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАВ

ХУУЛЬД ЗААСАН ХАРЬЯАЛЛЫН

1488 ҮЙЛДЭЛТЭЙ
820 ХОЛБОГДОГЧТОЙ
1255 ХЭРЭГТ



ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫН АЖИЛЛАГАА ЯВУУЛАВ

ШҮҮХЭЭР **107** ХЭРЭГ ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭГДСЭН



МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД

119.5 ТЭРБУМ
ТӨГРӨГИЙГ БИТҮҮМЖЛЭН ХАМГААЛАВ

96.2 ТЭРБУМ
ТӨГРӨГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭВ

1.Товч танилцуулга

2005 онд Монгол Улсын Их Хурал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцийг соёрхон баталсан. 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Их Хурал Авлигын эсрэг хуулийг баталж, 2006 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс даган мөрдөж эхэлсэн. Уг хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага-Авлигатай тэмцэх газар байгуулагдан 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн түүхтэй.

Авлигатай тэмцэх газар нь дараах чиг үүрэгтэй:

- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;
- Хуульд заасан албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах ажлыг зохион байгуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах ажлыг гүйцэтгэх.

Авлигатай тэмцэх газар нь дараах бүрэн эрхтэй:

- Авлигын эсрэг явуулах төрийн бодлого, шийдвэр, түүнчлэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулах;
- Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулах;
- Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайланг гаргуулан авах;
- Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
- Авлигын холбогдолтой өргөдөл гомдлыг хүлээн авч шалгах;
- Хуулиар харъяалуулсан хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;
- Чиг үүрэгтээ холбогдох асуудлаар мэдээ мэдээлэл авах, мэдээллийн нууцыг хадгалах.

2.Гомдол, мэдээлэл

2021 онд гэмт хэргийн шинжтэй 1596 гомдол, мэдээлэл шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 234 буюу 17.2%-иар өсжээ. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу 329 буюу 20.6% хувийг харьяалах байгууллагад шилжүүлсэн. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 460 буюу 40.2% хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 594 буюу 51.9% хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 44 буюу 3.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус шилжүүлж, 46 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 96.0% хувьтай байсан.

Хүснэгт №1. Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт

д/д	Үзүүлэлт		2018	2019	2020	2021
1	Үүнээс	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	327	362	487	594
2		Харьяаллын дагуу шилжүүлсэн	76	34	27	44
3		Эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	447	489	462	460
4		Ажиллагаанд	8	9	44	46
1	Нийт шалгасан гомдол, мэдээлэл		858	894	1020	1144

2021 онд гомдол, мэдээлэлд холбогдсон этгээдийг албан тушаалаар нь ангилбал төрийн улс төрийн албан тушаалтан 233, төрийн захиргааны албан тушаалтан 427, төрийн

тусгай албан тушаалтан 594, төрийн үйлчилгээний албан тушаалтан 148, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтан болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагын албан тушаалтан 194 тус тус холбогдож шалгагдсан байна.


Хүснэгт №2. Гомдол, мэдээлэлд холбон шалгасан этгээдийн албан тушаалын байдал

д/д	Албан тушаалын төрөл	Тоо	Хувь
1	Төрийн улс төрийн	233	15.2
2	Төрийн захиргааны	427	26.7
3	Төрийн тусгай	594	37.2
4	Төрийн үйлчилгээний	148	9.6
5	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, болон төрийн бус байгууллагын	194	12.1
6	Нийт холбогдож шалгагдсан албан тушаалтан	1596	100

Хүснэгт №3. Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсаар 2020 онд хүлээн авсан дуудлагын талаарх мэдээлэл.

д/д	Агуулга	I улирал	II улирал	III улирал	IY улирал	Нийт	
						Тоо	Дүнд эзлэх хувь
1	Зөвлөгөө авсан	1003	1117	907	855	3882	45.8
2	Хуурамч дуудлага	237	336	315	492	1380	16.3
3	Санал хэлсэн	17	6	3	2	28	0.3
4	Дугаар андуурсан	569	547	478	708	2302	27.2
5	Нэмэлт тодруулга	87	117	124	190	518	6.1
6	Төрийн байгууллагын хүнд сурталтай холбоотой мэдээлэл ирүүлсэн	-	2	47	-	49	0.6
7	Гомдол өгсөн	49	92	86	90	317	3.7
8	Нийт	1962	2217	1960	2337	8476	100

График №1. Ирсэн гомдол, мэдээллийн төрөл



110 тусгай дугаарт хандан өргөдөл, гомдол, мэдээлэл ирүүлсэн иргэдийн 145 буюу 45.7% нь нэрээ нууцлахыг хүссэн бол 172 буюу 54.3% нь нэр, хаягаа ил тодоор бүртгүүлсэн байна. 110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн 56.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй асуудлаар, 32.5 хувь нь ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой асуудлаар, 4.1 хувьд төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой асуудлаар хандсан байна.

110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 үйл ажиллагааны чиглэлийг харвал төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудлаар 64, хүний нөөцийн томилгоотой холбоотой 60, захиргааны шийдвэр гаргалттай холбоотой 29, тусгай зөвшөөрөлтэй холбоотой 28, тендер,

худалдан авах ажиллагаатай холбоотой 27, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалттай холбоотой 27, хяналт шалгалттай холбоотой 14, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой 11, улсын байцаагч, шинжээчийн дүгнэлт, шийдвэртэй холбоотой 11, эмчилгээ, оношилгоотой холбоотой 10 өргөдөл, гомдол, мэдээлэл байна.

110 тусгай дугаарын утсаар хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээлэлд хамгийн түгээмэл дурдагдаж байгаа 10 үйл ажиллагааны салбарыг харвал нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах салбарын асуудлаар 64, бага, дунд боловсролын салбартай холбоотой 26, эрүүл мэндийн салбартай холбоотой 25, зам, тээвэр, төмөр замын салбартай холбоотой 17, цагдаагийн байгууллагатай холбоотой 17, газар зохион байгуулалт, газар олголттой холбоотой 16, гаалийн байгууллагатай холбоотой 13, барилгын салбартай холбоотой 12, сургуулийн өмнөх боловсролын салбартай холбоотой 12, цахилгаан, дулаан, ус хангамжтай холбоотой 12 гомдол, мэдээлэл тус тус хүлээн авсан байна.

3.Мөрдөн шалгах ажиллагаа

Авлигатай тэмцэх газар 2021 онд хуульд заасан харьяаллын 1543 үйлдэлтэй, 909 холбогдогчтой, 1307 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь өмнөх онтой харьцуулбал, 1.8%-иар буурсан байна.

Хүснэгт №4. Шалгасан хэрэг

Он	Хэргийн тоо	Өссөн, буурсан хувь	Холбогдогчийн тоо	Өссөн, буурсан хувь
2018	1138	-	1224	-
2019	1300	+14.2	481	-61
2020	1331	+2.4	696	+44.6
2021	1307	-1.8	909	+24.3

2021 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах хэрэг 820 буюу 53.1%, хахууль авах хэрэг 225 буюу 14.6%, хахууль өгөх хэрэг 134 буюу 8.7%, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах хэрэг 20 буюу 1.3%, үндэслэлгүйгээр хөрөнгөжих хэрэг 36 буюу 2.3%, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах хэрэг 26 буюу 1.7%, мөнгө угаах хэрэг 33 буюу 2.1%, эрүү шүүлт тулгах хэрэг 24 буюу 1.6%, бусад хэрэг 225 буюу 14.6%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт №5. Шалгасан хэрэг /төрлөөр/


д/д	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Тоо	Хувь
1	22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	820	53.1
2	22.4 дүгээр зүйл. Хахууль авах	225	14.6
3	22.5 дугаар зүйл. Хахууль өгөх	134	8.7
4	22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	20	1.3
5	22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	36	2.3
6	22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	26	1.7
7	18.6 дугаар зүйл. Мөнгө угаах	33	2.1
8	21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах	24	1.6
9	Бусад	225	14.6
10	Нийт	1543	100

Хүснэгт №6. Авлигын гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээд (албан тушаалын байдлаар)

д/д	Албан тушаалын байдал	2018	2019	2020	2021
1	Төрийн тусгай албан тушаалтан	434	101	116	145
2	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан	193	143	231	149
3	Төрийн улс төрийн албан тушаалтан	166	48	81	91
4	Төрийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтан	82	38	55	200
5	Төрийн үйлчилгээний албан тушаалтан	145	48	116	175

6	Төрийн захиргааны албан тушаалтан	204	103	97	149

График №2. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн албан тушаалын байдал



2021 онд 1307 хэргээс 269 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 20.6%-ийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 1.7%-иар буурсан байна.

Хүснэгт №7. Шалгасан хэргийн шийдвэрлэлт

Он	Шүүхэд шилжүүлэх саналтай	Хэрэг бүртгэлтийг хаах саналтай	Харьяаллын дагуу шилжүүлсэн	Түдгэлзүүлсэн	Бусад хэрэгт нэгтгэсэн
2018	224	467	125	1	9
2019	156	556	80	1	22
2020	236	509	48	6	46
2021	269	429	61	5	63

2021 онд Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах ажиллагаа явуулан шүүхэд шилжүүлсэн хэргээс 160 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад, 40.3%-иар өссөн байна.

Хүснэгт №8. Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Он	Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	Өмнөх онтой харьцуулахад өссөн, буурсан хувь
2018	84	-
2019	68	20 хувь
2020	114	+67.6 хувь
2021	160	+40.3 хувь

2021 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 1.2 их наяд төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 96.2 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх 119.5 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх онтой харьцуулбал гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 2.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт №9. Хохирол

Он	Учирсан хохирол	Мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн	Битүүмжлэн хамгаалсан
2018	663.2 тэрбум	17.4 тэрбум	180.6 тэрбум
2019	12.1 их наяд	11.3 тэрбум	9.7 тэрбум

2020	12.1 их наяд	35.6 тэрбум	10.1 их наяд
2021	1.2 их наяд	96.2 тэрбум	119.5 тэрбум

4.Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил

Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг нийгмийн салбар, бүлэг тус бүрээр ангилан авч үзэж, тухайн салбар, бүлгийн онцлогт тохирсон агуулга, хэлбэрээр зохион байгууллаа. Авлигын эсрэг сурталчилгааг видео болон радио контент, зурагт хуудас, нугалбар, подкаст, үзүүлэн таниулах хуудас, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн самбар, видео болон цахим хичээл, орон нутаг дахь сурталчилгаа, нийтийн тээвэр, сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэцийн, цахилгаан шатны сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлэг зэрэг хэд хэдэн төрөл хэлбэрээр бэлтгэн, түгээсэн. Тухайлбал, илтгэх ур чадварын нээлттэй тэмцээн, орон нутгийн төсвийн ил тод байдал хакатон, багачуудад зориулсан авлигаас ангид байх контент, хүүхдийн кино зохиолын уралдаан, авлигын эсрэг сурталчилгаанд урлаг, спортын төлөөллийг оролцуулсан.

“Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд: “Аавын захиас”, “Тангараг” “Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр”, “Шударга ёс гэж юу вэ?” сэдэвт богино хэмжээний 4 кино контент, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утсыг сурталчилсан 2 төлийн шторкийг бүтээсэн.

“Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Шинэ үе авлигыг тэвчихгүй” цахим илтгэлийн уралдаан зохион байгуулав. Уралдаанд 150 сурагч оролцсоноос 6 сурагчийг шалгаруулж, илтгэлээс постер хийж түгээн сурталчлав. Хүүхэд багачуудад бага наснаас нь шударга ёсны талаар ойлголт өгөх, шударга үйлдэл, дадал хэвшилтэй болгох 7 зорилгоор Улсын Хүүхэлдэйн театртай хамтран “Бүлтээхэй, дэлдээхэй хоёрын шударга тоглоом” теле жүжгийг бүтээж, олон нийтийн хүртээл болгов.

Хүүхэд, багачуудад шударга ёсны үнэ цэнийг ойлгуулах, үнэт зүйлээ тодорхойлоход туслах, аливаа зүйлийн зөв, бурууг ялган таних, улмаар зөв хүмүүжил, зөв дадлыг бий болгох, үе тэнгийнхэндээ шударга ёсны үзэл бодлоо хуваалцах, нийгэмд авлигыг үл тэвчих, шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Зөв дадал-21” арга хэмжээ, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шударга ёсны боловсрол олгох, түүнд эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, идэвхжүүлэх зорилгоор “Шударга ёсны боловсрол: Гэр бүл, хүмүүжил, төлөвшил” чөлөөт уулзалтыг зохион байгууллаа. Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Соёл урлагийн их сургууль, Дотоод хэргийн их сургууль, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Шихихутуг их сургууль, Их засаг олон улсын их сургууль, Улаанбаатар их сургууль зэрэг их, дээд сургуулийн оюутнуудад шударга ёсны талаарх үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох, авлигын эсрэг дуу хоолойг сонсох, санал санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх зорилгоор “Таны эрх, таны оролцоо: Залуучууд авлигыг тэвчихгүй” нээлттэй өдөрлөгийг 4 үе шаттай зохион байгуулсан.

5.Монгол Улсын Авлигын индекс

Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагаас жил бүр боловсруулдаг Авлигын төсөөллийн индексийн дүнгээр 180 улс орны авлигын төсөөллийн индексийг боловсруулснаас 56 улс орон 50-аас дээш оноо авчээ. Индексийн дүнгээр Монгол Улс 2021 онд 35 оноо авч 180 улс орноос 110 дугаар байрт эрэмбэлэгдэж, 2020 онтой харьцуулахад 1

байраар урагшилсан байна. Авлигын төсөөллийн индексийн үнэлгээний дагуу Монгол Улс нь Албани, Босни-Херцеговин, Тайланд, Малави улсын хамт 110 дугаар байрт жагсжээ.[1]

Хүснэгт №10. Авлигын талаарх судалгаа хийдэг байгууллагуудын Монгол Улс дахь авлигын индекст өгсөн үнэлгээ

д/д	Байгууллага-судалгаа	2018	2019	2020	2021
1	Дэлхийн эдийн засгийн форум-Үзэл бодлын судалгаа 2020	31	28	28	34
2	Дэлхийн эрх зүйн төсөл-Хууль дээдлэх ёсны индекс 2020	36	36	33	35
3	Ардчилалын олон талт байдлын төсөл /V-Dem/ 2021	33	31	34	34
4	“Бертелсман” сан-Шилжилтийн индекс 2022	41	37	37	37
5	Эдийн засгийн мэдээллийн нэгж-Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2021	37	37	37	37
6	“Глобал инсайт” байгууллага-Улс орнуудын эрсдэлийн түвшин 2020	47	47	35	35
7	“Ай Эм Ди”-Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл үзэл бодлын судалгаа 2021	30	28	32	29
8	Пи Ар Эс групп-Эрсдэлийн үнэлгээ 2021	32	35	41	37
9	Дэлхийн банк-Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2020	43	35	35	-
Дундаж оноо		36	37	35	35

2021 оны авлигын хэмжүүр судалгаанд хамрагдсан Монгол Улсын иргэдийн 20.9% нь сүүлийн 12 сард хахууль өгсөн хэмээн хариулжээ.

Хүснэгт №11. Судалгаанд хамрагдсан иргэдийн хахууль өгсөн төрийн байгууллага

д/д	Төрийн үйлчилгээ	Хувь
1	Эрүүл мэндийн байгууллага	48.3
2	Шүүх	48
3	Газрын алба	41
4	Гаалийн байгууллага	36.9
5	Цагдаагийн байгууллага	35.3
6	Мэргэжлийн хяналтын байгууллага	33.4

Монгол Улсыг төлөөлөн судалгаанд хамрагдсан иргэдээс авлигад хамгийн их автсан гэж хариулсан төрийн байгууллага, албан хаагчдийг харуулав.

Хүснэгт №12. Авлигад хамгийн их автсан төрийн байгууллага

д/д	Төрийн байгууллага, албан хаагч	Хувь
1	Улсын Их хурлын гишүүн	41.7
2	Шүүх	51.0
3	Газрын алба	47.0
4	Гаалийн байгууллага	48.1
5	Цагдаагийн байгууллага	28.4
6	Мэргэжлийн хяналтын байгууллага	42.8

6.Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Монгол Улсын Засгийн газраас Авлигын индексийн үзүүлэлтийг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомж сурталчлах, авлигатай тэмцэхэд хувийн хэвшлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, бизнесийн ёс зүйг төлөвшүүлэх чиглэлээр МҮХАҮТ-тай, “egazar” программд мэдээллийг нэгтгэх буюу интеграци хийх, зарим аймгийн газар олгох үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай, “UB-engineering” буюу орон зайн мэдээллийн нэгдсэн системд төрийн байгууллагын цахим мэдээллийг оруулах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн хөндлөнгийн хяналтын

[1] Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2021. Улаанбаатар хот, 2022 он. 85 дахь тал.

тогтолцоог бий болгож, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасны дагуу Авлигатай тэмцэх газраас “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын төслийг боловсруулан Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичиг, зөвлөмжийн биелэлт тайлагнах, дүн шинжилгээ хийх, үнэлэх “Авлигын эсрэг үндэсний сүлжээ” буюу khutulbur. iaac.mn нэгдсэн цахим санг үүсгэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэв. Авлигын эсрэг үндэсний сүлжээ нэгдсэн сангаар дамжуулан байгууллагууд тайлан, мэдээг цаасаар бус цахимаар ирүүлэх, үнэлүүлэх, тухай бүрд нь баяжилт хийх боломж бүрдсэн. Үүнээс гадна тухайн тайлан, хэрэгжилт гаргасан байгууллага өөрийн болон бусад байгууллагын үнэлгээ, хийсэн ажилтай танилцаж болох юм.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭ – FORENSIC

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. ШИНЖИЛГЭЭНИЙ ТООН МЭДЭЭ
3. ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ
4. САН БАЯЖУУЛАЛТ, АШИГЛАЛТ
5. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НИЙТЛЭГ АЖИЛ






КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР
8766
Бусад 9
Материал судлал 40
Дуу авиа 15
Компьютер судлал 77
Авто техник 226
Дүрс бичлэг 243
Гарын мөр 5384
Мөр судлал 1394
Бичиг баримт 684
Галт зэвсэг 677
Тэсрэх төхөөрөмж 2
Дүр зураг 15


ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР
191


ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР
33631
Хүний биед гэмтлын зэрэг тогтоох шинжилгээ 22949
Цогцост хийсэн шинжилгээ 4561
Эксгумаци 11
Эд эсийн шинжилгээ 3246
Хавтаст хэргийн материалаар хийсэн шинжилгээ 1178
Хүний биед хийсэн бусад шинжилгээ 1686


ТУСГАЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР
15836
ДНХ-ийн бусад шинжилгээ 1305
Бактериологи 1038
Хими 6931
ДНХ-ээр эцэг тогтоох шинжилгээ 452
Биологи 5977
Физик 133

1.Товч танилцуулга

Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлэх, мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Дээрх чиг үүргийн хүрээнд цагдаагийн байгууллага болон мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран хэргийн газрын үзлэгт оролцож, мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэн, шинжилгээ хийлгэх эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр эрүү, иргэн, захиргааны хэргийн холбогдолтой объектод криминалистик, шүүх эмнэлэг, физик, хими, биологи, ДНХ, бактериологи, эдийн засгийн шинжилгээ хийж байна. Түүнчлэн гарын хээний сан, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн галт зэвсэг, сум хэрэгслийг хүлээн авч санд бүртгэх зорилгоор, буудлага үйлдэн галт зэвсгийн хонгио, хошууны сан, хариуцах эзэнгүй хэн болох нь тогтоогдохгүй цогцосны сан, Генетик мэдээллийн нэгдсэн сан /ДНХ/ болон бусад төрлийн санг бүрдүүлэн лавлагаа мэдээллийн үйл ажиллагаа гүйцэтгэдэг.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь 2021 онд “Байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажилласан ба өнөөдрийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталсны дагуу 10 газар, 4 хэлтэс, 21 алба, 8 хэсэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2.Шинжилгээний тоон мэдээ

Шүүхийн шинжилгээний байгууллага 2021 онд улсын хэмжээнд нийт 58424 шинжилгээ хийсэн байх ба 33631 буюу 57.6 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 5836 буюу 27.1 хувийг тусгай шинжилгээ, 8766 буюу 15 хувийг криминалистикийн шинжилгээ, 191 буюу 0.3 хувийг шүүх эдийн засгийн шинжилгээ эзэлж байна. Энэ нь өмнөх оны шинжилгээний статистик үзүүлэлтээс 5945 шинжилгээгээр бага буюу 10.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №1. Улсын хэмжээнд шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 5 жил)

Шинжилгээний чиглэл, төрөл		**2017 он**	**2018 он**	**2019 он**	**2020 он**	**2021 он**
Криминалистикийн шинжилгээ	Гарын мөр	9541	9550	7499	6660	5384
	Мөр судлал	1545	1553	1740	1556	1394
	Бичиг судлал, бичиг техник	1066	906	1147	915	684
	Дүр зураг	98	72	53	37	15
	Галт зэвсэг	222	604	937	877	677
	Тэсрэх төхөөрөмж	7	2	6	13	2
	Дүрс бичлэг	265	251	237	244	243
	Автотехник	235	165	164	215	226
	Компьютер судлал	131	111	85	119	77
	Дуу авиа	-	28	24	23	15
	Материал судлал	-	32	52	5	40
	Бусад	92	19	17	29	9
	Бүгд	**13202**	**13293**	**11961**	**10693**	**8766**
Тусгай шинжилгээ	Хими	5894	6814	7524	6976	6931
	Физик	170	210	238	249	133
	Биологи	5679	6056	6560	6125	5977
	ДНХ	1265	1685	2046	2030	1757
	Бактерлоги	994	1049	989	1062	1038

	Бүгд	**14002**	**15814**	**17357**	**16442**	**15836**
Шүүх эмнэлгийн шинжилгээ	Цогцост хийсэн шинжилгээ	4016	4492	4659	4455	4561
	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох	27934	27493	27138	25919	22949
	Хэргийн материалаар хийх	1409	1430	1649	1504	1178
	Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	1220	1425	1575	1734	1686
	Шарилд хийсэн шинжилгээ	19	26	24	17	11
	Гистологийн шинжилгээ	3492	4913	5110	3345	3246
	Бүгд	**38090**	**39779**	**40155**	**36974**	**33631**
Шүүх эдийн засгийн шинжилгээ	Татвартай холбоотой	18	20	9	11	7
	Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой	24	21	3	14	8
	Бэлэн мөнгөтэй холбоотой	48	53	64	75	51
	Эд хогшил, бараа	46	36	46	46	35
	Бусад зөрчил	95	13	30	20	16
	Буцсан	-	90	85	0	74
	Бүгд	**231**	**233**	**237**	**260**	**191**
Нийт		**65525**	**69119**	**69710**	**64369**	**58424**

График №1 Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд хийсэн нийт шинжилгээний тоо /шинжилгээний төрлөөр/




График №2 Шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээ (сүүлийн 5 жил)





График №3. Шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 5 жил)



Хүснэгт №2 2021 онд хийсэн шүүхийн шинжилгээ (аймаг, шинжилгээний төрлөөр)


№	Шинжилгээний газар, хэлтэс, алба	Нийт шинжилгээ	Шүүх эмнэлгийн шинжилгээ	Криминалис-тикийн шинжилгээ	Тусгай шинжилгээ	Эдийн засгийн шинжилгээ
1	Архангай	**920**	557	65	298	-
2	Баян-Өлгий	**812**	643	43	126	-
3	Баянхонгор	**758**	682	76	-	-
4	Булган	**504**	361	60	83	-
5	Говь-Алтай	**677**	494	40	143	-
6	Говьсүмбэр	**403**	391	12	-	-
7	Дархан-Уул	**1279**	939	105	235	-
8	Дорноговь	**816**	709	107	-	-
9	Дорнод	**1345**	935	151	259	-
10	Дундговь	**447**	367	80	-	-
11	Завхан	**723**	527	54	142	-
12	Орхон	**1366**	849	167	350	-
13	Өвөрхангай	**738**	608	130	-	-
14	Өмнөговь	**834**	798	36	-	-
15	Сүхбаатар	**716**	590	33	93	-
16	Сэлэнгэ	**1040**	813	143	84	-
17	Төв	**1235**	1041	194	-	-
18	Увс	**947**	677	63	207	-
19	Ховд	**1186**	917	94	175	-
20	Хөвсгөл	**1179**	765	225	189	-
21	Хэнтий	**1093**	921	172	-	-
22	Хүрээлэн	**35145**	17940	3562	13452	191
23	НШШГазар	**4261**	1107	3154	-	-
Бүгд		**58424**	**33631**	**8766**	**15836**	**191**

2.1.Криминалистикийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллага 2021 онд криминалистикийн шинжилгээний 89069 объекттой, 8766 шинжилгээ хийсэн бөгөөд 3562 буюу 40,6 хувийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний газарт, 3154 буюу 36 хувийг Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын криминалистикийн шинжилгээний хэлтэст, 2050 буюу 23,4 хувийг аймгийн шүүхийн шинжилгээний албадын криминалистикийн лабораторид хийсэн байна. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 8222, иргэний 250, захиргааны 111, зөрчлийн 183 хэрэг эзэлж байна.

Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 229, мөрдөгч, прокурорын тогтоолоор 8380, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 157 шинжилгээ хийсэн.

График №4 Криминалистикийн шинжилгээ



Хүснэгт №3 2021 оны Криминалистикийн шинжилгээний тоо (шинжилгээний төрөл, аймгаар)

№	Аймаг	Нийт шинжилгээ	Шинжилгээний төрөл											
			Гарын мөр	Мөр судлал	Баримт бичиг	Галт зэвсэг	Тэсрэх төхөөрөмж	Дүр зураг	Дүрс бичлэг	Автотехник	Компьютер	Дуу авиа	Материал	Бусад
1	Архангай	**65**	46	9	9	1	-	-	-	-	-	-	-	-
2	Баян-Өлгий	**43**	12	11	20	-	-	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	**76**	43	24	9	-	-	-	-	-	-	-	-	-
4	Булган	**60**	38	14	8	-	-	-	-	-	-	-	-	-
5	Говь-Алтай	**40**	23	10	5	2	-	-	-	-	-	-	-	-
6	Говьсүмбэр	**12**	4	6	2	-	-	-	-	-	-	-	-	-
7	Дархан-Уул	**105**	63	27	15	-	-	-	-	-	-	-	-	-
8	Дорноговь	**107**	83	17	7	-	-	-	-	-	-	-	-	-
9	Дорнод	**151**	126	24	1	-	-	-	-	-	-	-	-	-
10	Дундговь	**80**	65	11	4	-	-	-	-	-	-	-	-	-
11	Завхан	**54**	23	17	11	3	-	-	-	-	-	-	-	-
12	Орхон	**167**	116	39	11	1	-	-	-	-	-	-	-	-
13	Өвөрхангай	**130**	83	40	5	-	-	-	-	-	-	-	-	2
14	Өмнөговь	**36**	25	10	1	-	-	-	-	-	-	-	-	-
15	Сүхбаатар	**33**	23	7	1	2	-	-	-	-	-	-	-	-
16	Сэлэнгэ	**143**	112	23	8	-	-	-	-	-	-	-	-	-
17	Төв	**194**	167	26	1	-	-	-	-	-	-	-	-	-
18	Увс	**63**	32	13	13	5	-	-	-	-	-	-	-	-
19	Ховд	**94**	49	32	12	1	-	-	-	-	-	-	-	-
20	Хөвсгөл	**225**	153	39	8	24	-	-	-	1	-	-	-	-
21	Хэнтий	**172**	128	41	1	2	-	-	-	-	-	-	-	-
22	Хүрээлэн	**3562**	833	944	525	636	2	15	243	225	77	15	40	7
23	НШШГазар	**3154**	3137	10	7	-	-	-	-	-	-	-	-	-
Бүгд		**8766**	**5384**	**1394**	**684**	**677**	**2**	**15**	**243**	**226**	**77**	**15**	**40**	**9**

2.2 Шүүх эмнэлгийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд шүүх эмнэлгийн **33631** шинжилгээ


хийсэн бөгөөд энэ нь өмнөх оныхоос 3343 шинжилгээгээр буюу 9 хувиар буурсан байна. Эдгээрийн 24635 буюу 73.3% нь хүний биед хийсэн шинжилгээ, 7818 буюу 23.2 хувь нь цогцос болон шарилд хийсэн шинжилгээ /үүний 9.7% нь эд эсийн шинжилгээ/, 1178 буюу 3.5 хувь нь хэргийн материалаар хийсэн шинжилгээ эзэлж байгаа бөгөөд нийт шинжилгээний 53.3%-ийг ШШҮХ-ийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт, 3.3%-ийг Нийслэлийн Шүүхийн шинжилгээний газарт, 43.4%-ийг аймгуудын шүүхийн шинжилгээний албанд хийсэн. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 27731, иргэний 1218, зөрчлийн 1436 хэрэг эзэлж байна.

Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 78, мөрдөгч, прокурорын тогтоолоор 30100, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 207 шинжилгээ хийсэн.

Хүснэгт №4 Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээ

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ	4561
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	22949
Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	1686
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1178
Эксгумаци	11
Эд эсийн шинжилгээ	3246
НИЙТ	**33631**

График №5 Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээ /төрлөөр/



Хүснэгт №5 Шүүх эмнэлгийн шинжилгээ /шинжилгээний төрөл, аймгаар/

№	Шинжилгээний алба	Нийт шинжилгээ	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	Хүний биед хийсэн бусад шинжилгээ	Цогцост хийсэн шинжилгээ	Эксгумаци	Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	Гистологи
1	Архангай	557	415	16	112	-	14	
2	Баян-Өлгий	643	576	11	55	1	-	
3	Баянхонгор	682	470	61	94	-	57	
4	Булган	361	236	42	81	-	2	
5	Говь-Алтай	494	399	23	70	-	2	
6	Говьсүмбэр	391	363	2	26	-	-	

7	Дархан-Уул	939	780	54	85	-	-	20
8	Дорноговь	709	597	24	88	-	-	
9	Дорнод	935	585	35	150	-	5	160
10	Дундговь	367	273	13	56	-	25	
11	Завхан	527	421	17	66			23
12	Орхон	849	678	53	109	-	9	
13	Өвөрхангай	608	438	55	113	2	-	
14	Өмнөговь	798	616	32	132	-	15	3
15	Сүхбаатар	590	525	26	39	-	-	
16	Сэлэнгэ	813	626	19	168	-	-	
17	Төв	1041	574	17	170	-	109	171
18	Увс	677	486	24	77	1	3	86
19	Ховд	917	738	20	70	-	20	69
20	Хөвсгөл	765	515	48	202	-	-	
21	Хэнтий	921	711	38	149	-	23	
22	ШЭШГ	17940	10972	1033	2331	7	883	2714
23	НШШГ	1107	955	23	118	-	11	
24	**Бүгд**	**33631**	**22949**	**1686**	**4561**	**11**	**1178**	**3246**

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд сүүлийн 6 жилд хийсэн нийт шинжилгээний 57.8%-г шүүх эмнэлгийн шинжилгээ дангаар эзэлж байна.

Хүснэгт №6 Улсын хэмжээнд хийсэн нийт шинжилгээ сүүлийн 6 жилээр

Он	Нийт хийсэн шинжилгээний тоо	Шүүх эмнэлгийн шинжилгээний тоо	Шүүх эмнэлгийн шинжилгээний эзлэх хувь
2016	68525	40423	59%
2017	65525	38090	58,1%
2018	68424	39084	57,1%
2019	69710	40155	57,6%
2020	64369	36974	57,4%
2021	58424	33631	57,6%

2.3 Эдийн засгийн шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн дагуу эдийн засгийн 191 хэрэг хүлээн авснаас 19 аж ахуйн нэгж, байгууллага, 98 иргэдэд холбогдох өмчийн болон татварын маргаантай хавтаст хэрэг, санхүүгийн баримт материалд шинжилгээ хийж, 1,760,559,956.2 төгрөг, 12,211,965.4 валютын хохирлын хэмжээ, шалтгааныг тогтоож, шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 169, иргэний 11, захиргааны 11 хэрэг эзэлж байна. Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 22, мөрдөгч, прокурорын тогтоолоор 169 шинжилгээ хийсэн.

Үүнээс 117 шинжилгээний дүгнэлт гаргасан бөгөөд шинжээч томилох эрх бүхий этгээдийн хүсэлтээр, санхүүгийн баримт ирүүлээгүй, эрх бүхий байгууллагын акт дүгнэлт гараагүй зэрэг шалтгаанаар 59 шинжилгээ буцсан хийгдэж байгаа 15 шинжилгээ байна.

График №6 Эдийн засгийн шинжилгээ зөрчлийн төрлөөр






График №7 Эдийн засгийн шинжилгээ хэргийн төрлөөр



2.4 Тусгай шинжилгээ

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд тусгай шинжилгээний чиглэлээр нийт 33638 объекттой, 15836 шинжилгээ хийснийг өмнөх жилтэй харьцуулахад 606 шинжилгээгээр буюу 3.7 хувиар буурсан байна. 2021 онд Тусгай шинжилгээний чиглэлээр хийсэн нийт шинжилгээний 6931 буюу 43.8 хувийг химийн шинжилгээ, 5977 буюу 37.8 хувийг биологийн шинжилгээ, 1757 буюу 11.1 хувийг ДНХ-ийн шинжилгээ, 1038 буюу 6.5%-ийг бактериологийн шинжилгээ, 133 буюу 0.8 хувийг физикийн шинжилгээ тус тус эзэлж байна. Үүнийг хэргийн төрлөөр нь авч үзвэл эрүүгийн 15368, иргэний 453, захиргааны 1, зөрчлийн 14 хэрэг эзэлж байна. Мөн шинжилгээ хийсэн үндэслэлээр буюу томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 432, мөрдөгч, прокурорын тогтоолоор 7500, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны хүсэлтээр 20, тогтоолыг үндэслэж ирүүлсэн шинжээч эмчийн илгээх бичгээр 7884 шинжилгээ хийсэн.

График №8 Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд хийсэн тусгай шинжилгээ төрлөөр нь /хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ/



Хүснэгт №7 Шүүхийн шинжилгээний байгууллагад 2021 онд хийсэн тусгай шинжилгээ (шинжилгээний төрөл, аймгаар)

№	Аймаг	Нийт шинжилгээ	Шинжилгээний төрөл				
			Хими	Физик	Биологи	ДНХ	Бактериологи
1	Архангай	**298**	171	-	127	-	-
2	Баян-Өлгий	**126**	126	-	-	-	-
3	Баянхонгор	**-**	-	-	-	-	-
4	Булган	**83**	83	-	-	-	-
5	Говь-Алтай	**143**	97	-	46	-	-
6	Говьсүмбэр	**-**	-	-	-	-	-
7	Дархан-Уул	**235**	133	-	102	-	-
8	Дорноговь	**-**	-	-	-	-	-
9	Дорнод	**259**	206	-	53	-	-
10	Дундговь	**-**	-	-	-	-	-
11	Завхан	**142**	142	-	-	-	-
12	Орхон	**350**	256	-	94	-	-
13	Өвөрхангай	**-**	-	-	-	-	-
14	Өмнөговь	**-**	-	-	-	-	-
15	Сүхбаатар	**93**	93	-	-	-	-
16	Сэлэнгэ	**84**	60	-	24	-	-
17	Төв	**-**	-	-	-	-	-
18	Увс	**207**	117	-	90	-	-
19	Ховд	**175**	143	-	32	-	-
20	Хөвсгөл	**189**	189	-	-	-	-
21	Хэнтий	**-**	-	-	-	-	-
22	ТШГ	**13452**	5115	133	5409	1757	1038
Бүгд		**15836**	**6931**	**133**	**5977**	**1757**	**1038**

3.Хэргийн газрын үзлэгт оролцсон байдал


Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн криминалистикийн шинжээчид 2021 онд нийт 21953 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бөгөөд үүнийг өмнөх онтой харьцуулахад 5586 буюу 20.3 хувиар буурсан байна.

Хэргийн газрын үзлэг, шинжилгээний явц, байдлыг гэрэл зургаар бэхжүүлэн авсан ба хэргийн газрын үзлэгийн 309208, шинжилгээний 81915, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 100370, бусад 264871, нийт 756364 гэрэл зураг авч, үзлэг, шинжилгээний баримтад хавсаргасан байна.

Хүснэгт №8 Хэргийн газрын үзлэг хэргийн өнгөөр

д/д	Хэргийн өнгө	Хэргийн тоо
1	Хүний амь нас хохирсон	4999
2	Хулгайлах	5136
3	Дээрэмдэх	339
4	Зам тээврийн осол	3906
5	Бусад	7573
	Нийт	**21953**

График №9 Хэргийн газрын үзлэг хэргийн өнгөөр



Хүснэгт №9 2021 онд хэргийн газрын үзлэгт оролцсон байдал (хэргийн өнгө, аймгаар)

№	Аймаг	Нийт хэргийн газрыг үзлэг	Хэргийн өнгө				
			Хүний амь нас хохирсон	Хулгайлах	Дээрэмдэх	Зам тээврийн осол	Бусад
1	Архангай	**242**	116	44	-	54	28
2	Баян-Өлгий	**319**	39	46	3	85	146
3	Баянхонгор	**267**	91	59	-	57	60
4	Булган	**208**	87	41	1	28	51
5	Говь-Алтай	**256**	64	40	-	69	83
6	Говьсүмбэр	**208**	26	31	1	50	100
7	Дархан-Уул	**602**	131	104	4	137	226
8	Дорноговь	**375**	111	62	5	78	119
9	Дорнод	**407**	162	91	-	78	76
10	Дундговь	**216**	62	43	-	61	50


11	Завхан	**297**	66	53	1	74	103
12	Орхон	**488**	88	112	-	36	252
13	Өвөрхангай	**306**	123	76	-	68	39
14	Өмнөговь	**303**	135	43	-	58	67
15	Сүхбаатар	**163**	47	48	-	36	32
16	Сэлэнгэ	**445**	178	37	-	117	113
17	Төв	**398**	188	45	8	86	71
18	Увс	**263**	82	38	-	80	63
19	Ховд	**311**	71	69	1	95	75
20	Хөвсгөл	**381**	196	82	1	56	46
21	Хэнтий	**401**	140	65	1	115	80
22	НШШГ	**15048**	2763	3905	313	2381	5686
23	КШГ	**49**	33	2	-	7	7
Бүгд		**21953**	**4999**	**5136**	**339**	**3906**	**7573**

Хэргийн газрын үзлэгээр нийт 54668 ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлсэн ба хэргийн газрын үзлэгийн 309208, шинжилгээний 81915, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 100370, бусад 264871 зураг буюу нийт 756364 гэрэл зургаар үзлэг шинжилгээний явцыг бэхжүүлсэн байна.

Хүснэгт №10 Хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт төрлөөр

д/д	Илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт	Ул мөр, эд мөрийн баримтын тоо
1	Гарын мөр	15489
2	Гутлын мөр	3058
3	Тээврийн хэрэгслийн мөр	3401
4	Бичил мөр	166
5	Эвдлэгч багаж хэрэгслийн мөр	1033
6	Биологийн гаралтай ул мөр	3502
7	Бусад ул мөр, эд мөрийн баримт	28019
	Нийт	**54668**

График №10 Хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт төрлөөр



Хүснэгт №11 2021 онд хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт (аймаг тус бүрээр)

№	Аймаг	Нийт ул мөр, эд мөрийн баримт	Ул мөр, эд мөрийн баримт						
			Гарын мөр	Гутлын мөр	Тээврийн хэрэгслийн мөр	Бичил мөр	Эвдлэгч багаж, хэрэгслийн мөр	Биологийн гаралтай ул мөр	Бусад ул мөр, эд мөрийн баримт
1	Архангай	**649**	191	72	229	-	12	14	131
2	Баян-Өлгий	**366**	66	42	58	5	1	35	159
3	Баянхонгор	**969**	376	44	162	-	5	62	320
4	Булган	**592**	113	63	103	10	26	73	204
5	Говь-Алтай	**728**	65	37	198	-	3	32	393
6	Говьсүмбэр	**486**	50	42	88	-	2	7	297
7	Дархан-Уул	**1561**	317	60	21	2	-	40	1121
8	Дорноговь	**994**	186	82	89	6	5	207	419
9	Дорнод	**916**	428	71	131	-	4	42	240
10	Дундговь	**623**	169	38	118	7	9	130	152
11	Завхан	**891**	208	83	128	22	21	50	379
12	Орхон	**1659**	761	149	27	9	9	274	430
13	Өвөрхангай	**1302**	298	94	204	37	30	98	541
14	Өмнөговь	**745**	191	64	126	-	15	48	301
15	Сүхбаатар	**663**	55	41	55	-	8	-	504
16	Сэлэнгэ	**592**	106	59	110	-	-	61	256
17	Төв	**610**	191	19	131	-	25	10	234
18	Увс	**713**	186	51	113	3	-	43	317
19	Ховд	**1126**	294	130	181	1	20	83	417
20	Хөвсгөл	**1171**	171	180	150	3	9	138	520
21	Хэнтий	**1721**	345	42	216	8	41	195	874
22	НШШГ	**34944**	10380	1545	757	52	783	1837	19590
23	КШГ	**647**	342	50	6	1	5	23	220
Бүгд		**54668**	**15489**	**3058**	**3401**	**166**	**1033**	**3502**	**28019**

4.Сан баяжуулалт, ашиглалтын статистик

Шүүхийн шинжилгээний байгууллага нь галт зэвсгийн хонгио хошууны Арсенал болон гарын мөр, дардасны Папилон сан, ДНХ-ийн мэдээллийн санг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд 2021 онд галт зэвсгийн Арсенал санг 5013 сумны хонгионы мөрөөр, 3464 сумны хошууны мөрөөр буюу нийт 8477 мөрөөр, Папилон санг 42487 гарын дардсаар, 8617 гарын мөрөөр буюу нийт 51104 мөр, дардсаар, “ДНХ-ийн мэдээллийн сан”-г 1626 хүний мэдээллээр баяжуулж гэмт хэрэг илрүүлэх чиглэлээр үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нийслэлийн засаг даргын 627 дугаар захирамжаар баталсан “Эзэнгүй цогцос оршуулах журам”, 2013 оны А/117 дугаар захирамжаар баталсан “Захирамжид өөрчлөлт оруулах журам”-ыг тус тус үндэслэн тус хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын цогцос хадгалах байранд хадгалагдаж байгаа хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй цогцосны мэдээллийн санд нийт 38 цогцос бүртгэж, хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй нийт 55 цогцсыг холбогдох журмын дагуу оршуулсан.

График №11,12 2021 оны сайн баяжуулалт (Арсенал, Папилон)





Хүснэгт №12 2021 оны сан баяжуулалт, ашиглалтын статистик (аймаг тус бүрээр)

№	Аймаг	Арсенал			Папилон		
		Сумны хонгио	Сумны хошуу	**Нийт**	Гарын мөр	Гарын дардас	**Нийт**
1	Архангай	-	-	**-**	43	525	**568**
2	Баян-Өлгий	-	-	**-**	27	517	**544**
3	Баянхонгор	-	-	**-**	148	833	**981**
4	Булган	2	-	**2**	32	491	**523**
5	Говь-Алтай	10	6	**16**	30	383	**413**
6	Говьсүмбэр	-	-	**-**	-	360	**360**
7	Дархан-Уул	2	2	**4**	99	948	**1047**
8	Дорноговь	-	-	**-**	73	790	**863**
9	Дорнод	12	2	**14**	240	1299	**1539**
10	Дундговь	-	-	**-**	44	465	**509**
11	Завхан	23	6	**29**	115	308	**423**
12	Орхон	61	61	**122**	364	583	**947**
13	Өвөрхангай	-	-	**-**	75	556	**631**
14	Өмнөговь	-	-	**-**	72	1292	**1364**
15	Сүхбаатар	56	35	**91**	47	1597	**1644**
16	Сэлэнгэ	9	6	**15**	81	4439	**4520**
17	Төв	-	-	**-**	87	838	**925**
18	Увс	4	4	**8**	54	1405	**1459**
19	Ховд	42	25	**67**	120	557	**677**
20	Хөвсгөл	52	27	**79**	126	964	**1090**
21	Хэнтий	2	1	**3**	132	683	**815**
22	НШШГ	-	-	**-**	5509	18674	**24183**
23	КШГ	4738	3289	**8027**	1099	3980	**5079**
Бүгд		**5013**	**3464**	**8477**	**8617**	**42487**	**51104**

5.Гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг ажил

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/216 дугаар тушаалаар “Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, орон тоо”-г шинэчлэн Криминалистикийн шинжилгээний газарт Экологийн шинжилгээний лабораторийг шинээр байгуулсан. Мөн Дорнод, Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний албанд 2021 оны 6 дугаар сард “Эд эсийн шинжилгээний лаборатори”-ийг байгуулсан ба үүний үр дүнд баруун, зүүн бүсийн аймгуудын Шүүхийн шинжилгээний албад эд эсийн шинжилгээг Улаанбаатар хот руу илгээж дүгнэлтийн хугацаа хэтрэх, шинжилгээний дээж замдаа муудах, гэмтэх зэрэг асуудал шийдэгдсэн.

Тус хүрээлэнгийн Тусгай шинжилгээний газраас 4 дэх жилдээ зохион байгуулахаар төлөвлөсөн “DNA WORKSHOP-2021”, “Narcotic Workshop-2021” сургалт семинарыг мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис тодорхойлох шинжилгээний онцлог, үе шат, хийж байгаа шинжилгээний төрөл зүйл, шинжилгээнд дээжийг шаардлага хангахуйцаар ирүүлэх зэрэг сэдвийн хүрээнд онол, практик хослуулан зохион байгуулсан. Уг сургалт, семинарт Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Нийслэлийн прокурорын газар, Гаалийн ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Наркологийн эмнэлэг зэрэг нийт 7 байгууллагын 12 албан тушаалтан оролцсон.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны санхүүжилтээр “Chison Ebit-30” загварын зөөврийн хэт авиан шинжилгээний 3 аппарат худалдан авч, хүний биеийн хэвлийн гэмтлийг оношлох, жирэмсэн болон жирэмслэлт таслагдсан эсэхийг тогтоох, мөн ял эдлэхээс чөлөөлөх өвчний жагсаалтад хамаарах эсэх шинжилгээнд онош бататгах зорилгоор ашиглаж байна.

Түүнчлэн, Тусгай шинжилгээний газрын гистологийн шинжилгээний лабораторийг өргөжүүлж иммуногистохимийн шинжилгээ хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн бөгөөд үүний үр дүнд гавал тархины гэмтлийн цаг хугацааг нарийвчлан тогтоох, зарим төрлийн амьсгал бүтэлтийг ялган оношлох зэрэг нарийвчилсан шинжилгээг хийх боломжтой болсон. Мөн тус зөвлөлийн санхүүжилтээр ОХУ-аас гарын хээний автомат харьцуулалтын “Адис-Папилон-7” системийн 62 нэгж бүхий нийт 10 ширхэг иж бүрдлийг худалдан авсан ба дүүргүүдийн Цагдаагийн 2 болон 3 дугаар хэлтсүүдэд интернэт сүлжээ, техник тоног төхөөрөмжүүдийг суурилуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон бусад чиглэлээр үйл ажиллагаандаа ашиглаж байна.



ДОЛООДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ – CRIME VICTIM

1. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК
2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК
3. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН СТАТИСТИК
4. ШҮҮХИЙН СТАТИСТИК
5. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ, ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ






ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ (2021)

НИЙТ ХОХИРОГЧ
24994 +8.4%

НИЙСЛЭЛД **16060** +11.0%

ОРОН НУТАГТ **8934** +4.0%

ЭРЭГТЭЙ | ЭМЭГТЭЙ



54.9%

13719
+0.6%

45.1%



11275
+19.7%

НАС

70+
65-69
60-64 - 3704
55-59
50-54
45-49
8909 - 40-44
35-39
30-34
25-29 - 11016
18-24
1365 - -17



УЧИРСАН ХОХИРОЛ
180.3 -29.3% ТЭРБУМ

НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН
90.3 +10.1% ТЭРБУМ

ХУВЬ
50.0% +17.9%

ХОХИРСОН ХУУЛИЙН ЭТГЭЭД **59** -10.6%



НАС БАРСАН
683 +1.9%



ГЭМТСЭН
8299 +1.5%

Гэмт хэргийн хохирол

Криминологийн шинжлэх ухаанд хохирогч судлал /Виктимлоги/ чухал байр суурийг эзэлдэг. Учир нь ямар хүн хохирч байна гэдгийг судалсны үндсэн дээр тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх боломжтой.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал" (Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power)-ыг баталсан нь дэлхийн улс орнуудад өөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогч судлалын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн гол үндэслэл болсон[1].

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй" гэж заасан бөгөөд бусдын хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалтуудаар зохицуулсан байдаг.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн актуудаар нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээдийг хохирогч, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэж тодорхойлсон нь үндсэндээ эд хөрөнгийн хохирлоос гадна эд хөрөнгийн бус хохирол нөхөн төлүүлэх эрхийг бататган хуульчилсан бөгөөд ийнхүү гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг бататгасан нь эрх зүйн орчин бүрдсэн.

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх учиртай.

Тэгвэл Монгол Улсын хувьд, “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-г бүрдүүлэхийг хуульчилсан байна[2]. Монгол Улсын Их Хурлаас “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийг 2006 оны 06 дугаар сарын 29-ний батлан, 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр шинэчлэн найруулсан байдаг.

Гэхдээ уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл /хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /хүнийг хүчээр алга болгох/, 15.3 дугаар зүйл /хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна” гэж ялгамжтай байхаар хуульчилжээ. Дээрх хуулийн заалтуудыг судалж үзвэл, хүний амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэж үйлдсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгож байхаар хуульчилсан ч процессын нарийн зохицуулалт тодорхой бус байна.

[1] https://legal.un.org/avl/ha/dbpjvcap/dbpjvcap.html

[2] “Засгийн газрын нөөц сангийн тухай хууль” шинэчилсэн найруулга, 2019 https://www.legalinfo.mn/

Мөн сэтгэл санааны хохирол хэрхэн барагдуулах асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байсаар байна. Хэдий тийм ч 2021 онд өргөн барьсан Шүүхийн шинжилгээний тухай шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд сэтгэл санааны хохирлыг үнэлэх журмыг тусгажээ. Тухайлбал, хуулийн төслийн 40 дүгээр зүйл. Сэтгэцэд учирсан хор уршгийг тооцох үнэлгээ 40.1. Шинжилгээний байгууллага Эрүүгийн хуулийн Аравдугаар бүлэг /Хүний амьд явах эрхийн эсрэг/, Арван нэгдүгээр бүлэг /Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг/, Арван хоёрдугаар бүлэг /Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг/, Арван гуравдугаар бүлэг /Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг/, 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, 14.2 дугаар зүйл /Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах/, 14.3 дугаар зүйл /Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах/, 14.4 дүгээр зүйл /Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах/, 14.8 дугаар зүйл /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/, Арван тавдугаар бүлэг/Эрүүл мэндийн эсрэг/, Арван зургадугаар бүлэг/Хүүхдийн эсрэг/, 17.1 дүгээр зүйл /Хулгайлах/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 17.3 дугаар зүйл /Залилах/, 17.6 дугаар зүйл /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх/, 17.8 дугаар зүйл /Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 17.10 дугаар зүйл /Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих/, 17.12 дугаар зүйл /Мал хулгайлах/, 20.11 дүгээр зүйл /Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях/, 20.12 дугаар зүйл /Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх/, 20.13 дугаар зүйл /Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах/, 20.14 дүгээр зүйл /Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх/, 20.16 дугаар зүйл /Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 21.5 дугаар зүйл /Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 21.13 дугаар зүйл /Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих/, 24.1 дүгээр зүйл /Байгаль орчныг бохирдуулах/, 4.3 дугаар зүйл /Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах/, 24.7 дугаар зүйл /Ой, хээрийн түймэр тавих/, 26.3 дугаар зүйл /Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 27.3 дугаар зүйл /Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих/, 27.7 дугаар зүйл /Агаарын хөдөлгөөний аюулгүй 24 байдалд халдах/, 27.8 дугаар зүйл /Агаарын хөлгийг авч зугтаах/, 27.10 дугаар зүйл /Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих/, 28.3 дугаар зүйл /Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх/, 28.4 дүгээр зүйл /Бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих/, 28.10 дугаар зүйл /Байлдааны машин жолоодох, ашиглалтын журам зөрчих/, 28.11 дүгээр зүйл /Байлдааны, сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих/, 29.4 дүгээр зүйл /Дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх/, 29.5 дугаар зүйл /Төрлөөр устгах/, 29.7 дугаар зүйл /Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг зэрэглэлийг тогтоож дүгнэлт гаргана[3] гэжээ. Гэтэл энэхүү шинжилгээний байгууллагад ямар байгууллага хамаарах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байна.

Мөн сэтгэцийн шинжилгээ хийлгэх эрх зүйн боломжийг хязгаарлаж, бусад төрлийн хэрэгт, тухайлбал Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт хохирсон хүүхдийн сэтгэцийн хохирлыг үнэлэхгүй байхаар төсөлд тусгасан байгааг анхаарах шаардлагатай.

Сэтгэцийн хохирлыг тодорхойлох талаар хуульчлахаар ажиллаж байгаа хэдий ч практикт сэтгэл санааны хохирлын барагдуулсан туршлага цөөнгүй аж. Тухайлбал, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн өмгөөлөгчид 2015 оноос бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн сэтгэл зүйд учирсан гэмтлийг тогтоолгох, хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх аргачлалыг шүүхийн практикт туршиж эхэлсэн. Ингэхдээ Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас баталсан сэтгэцийн болон зан үйлийн эмгэг өвчний олон улсын ангиллын систем 1СЭ-10V(Б)-д тулгуурласан байна.

[3] Хуулийн төслийн цахим хувилбар: https://mojha.gov.mn/

“Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2021” эмхэтгэлд Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн талаар шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудын статистик тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

Судалгааны явцад дээрх байгууллагуудын статистик тоон мэдээллүүд ямагт зөрүүтэй, зарим тохиолдолд хоорондоо уялдахгүй байсныг дурдах нь зүйтэй. Энэ нь Монгол Улсад гэмт хэргийн статистик мэдээллийн нэгдсэн тогтолцоо байхгүйтэй холбоотой.

1.Цагдаагийн байгууллагын статистик

Монгол Улсын хэмжээнд 2021 онд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 24994 хүн хохирсон нь өмнөх оныхтой харьцуулахад 1944 хүн буюу 8.4%-иар өсжээ. Үүнээс 683 хүн нас барсан нь өмнөх онтой харьцуулахад 13 буюу 1.9%-иар өссөн байна.

2021 онд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 59 хуулийн этгээд хохирсон бөгөөд Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт 13 хуулийн этгээд, мөн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт 10 хуулийн этгээд тус тус хохирсон нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Хүснэгт №1. Гэмт хэргийн улмаас нас барсан хохирогч

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Үүнээс: Гэмт хэргийн төрлөөр													
			10.1 /91/		10.2, 10.3, 10.5 /92-93/		10.4 /95/		10.6 /94/		27.1-27.11 /215-225/		Үүнээс 27.10		бусад	
			2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
1	Баруун бүс	Баян-Өлгий	5	2				1	1		6	9	6	9	3	
2		Говь-Алтай	2	3			1			2	2	3	2	3	1	
3		Завхан	1	2			2	1	2	4	17	6	17	6	1	
4		Үүнээс: Тосонцэнгэл		1			1	1		1	12	3	12	3		
5		Увс		1			1			1	4	7	4	7		1
6		Ховд	2	1				1	1	2	11	11	11	11		1
7		Үүнээс : Булган		1												1
8	Хангайн бүс	Архангай	6	3	1		2	1		3	12	12	12	12	1	3
9		Баянхонгор	2	3			2	1	2	1	8	7	8	7		2
10		Булган	5	10			6	2		2	5	15	5	15		
11		Орхон	3	3			2	6	1	3	2	5	2	5	1	1
12		Өвөрхангай	4	2			1	4	1	2	9	7	9	7	1	1
13		Үүнээс: Хархорин	1					1		1	3	1	3	1		
14		Хөвсгөл	4	5				2	4	4	10	10	10	10	3	1
15	Төвийн бүс	Говьсүмбэр	2	2					3		2	2	2	2		1
16		Дархан-Уул	2	5	1		2		2	1	3	3	3	3	1	
17		Дорноговь	5	5				1	1		4	5	4	5		
18		Үүнээс: Замын-Үүд	4	2							2	1	2	1		
19		Дундговь	1	2			1	1	1		4	4	4	4		
20		Өмнөговь	7	3		1	1	3	3	1	17	5	17	5	2	1
21		Үүнээс:Цогтцэций сум	2	2		1	1	2	2	1	5	2	5	2	1	1
22		Сэлэнгэ	11	3	1		5	6	3	4	11	9	11	9	3	2
23		Үүнээс: Мандал	2	1	1		1	1	2	2	3	2	3	2	1	2
24		Төв	7	5			3	1	5	8	24	16	24	16	2	1
25		Үүнээс: Заамар		1			1		3	1	8	3	8	3		1
26	Зүүн бүс	Дорнод	4	5				1	1	4	17	12	17	12	3	2
27		Сүхбаатар	7	2			17	1	1		7	6	7	6		2
28		Хэнтий	10	7			4	6	1	3	12	10	12	10		2
29		Үүнээс: Бор-Өндөр	3					2								
30	Нийслэл		100	97	2	2	67	114	25	26	77	74	77	74	13	26

31	Баянгол	14	8			14	15	2	2	5	7	5	7	5	3
32	I хэлтэс	7	6			9	12			1	3	1	3		1
33	II хэлтэс	7	2			5	3	2	2	4	4	4	4	5	2
34	Баянзүрх	29	26		1	18	54	12	6	14	8	14	8	4	6
35	I хэлтэс	13	10		1	6	16	7	4	2		2			3
36	II хэлтэс	5	9			9	24			5	2	5	2	3	2
37	III хэлтэс	11	7			3	14	5	2	7	6	7	6	1	1
38	Сүхбаатар	6	10	1	1	4	10	3	2	6	7	6	7	1	3
39	I хэлтэс	2	1		1	1	4	1	1	1		1		1	3
40	II хэлтэс	4	9	1		3	6	2	1	5	7	5	7		
41	Сонгинохайрхан	29	20			14	17	1	4	25	30	25	30	1	7
42	I хэлтэс	14	9			9	6		2	17	22	17	22	1	4
43	II хэлтэс	9	7			3	7			6	6	6	6		2
44	III хэлтэс	6	4			2	4	1	2	2	2	2	2		1
45	Хан-Уул	10	11	1		6	9	3	9	16	14	16	14	1	2
46	I хэлтэс	3	3			1	5	1	4	3	6	3	6		1
47	II хэлтэс	7	8	1		5	4	2	5	13	8	13	8	1	1
48	Чингэлтэй	7	14			7	6	2	1	7	7	7	7	1	5
49	I хэлтэс	1	3			4	1	1		1	1	1	1	1	1
50	II хэлтэс	6	11			3	5	1	1	6	6	6	6		4
51	Багануур	2				1		1		1		1			
52	Багахангай														
53	Налайх	3	8			3	3	1	2	3	1	3	1		
54	Бусад					1									
55	ИАТ									1		1			
56	Төмөр зам						1	1							
57	Мөрдөн байцаах алба		1			3				2	2	2	2		2
58	Эрүүгийн цагдаагийн алба														
59	Замын цагдаагийн газар									72	72	72	72		
60	НЦУГ ХГХТХ														
61	НЦУГ ХОХГХТХ	26	2												
62	Хар тамхитай тэмцэх газар													1	
63	Экологийн цагдаагийн алба														
64	АТГ									1		1			
65	ТЕГ -ын МБХ														
66	Улсын дүн	190	171	5	3	118	153	58	71	264	238	264	238	35	47
Өсөлт бууралт/тоогоор/		-19		-2		35		13		-26		-26		12	
Өсөлт бууралт /хувиар/		- 10.0		- 40.0		2 9.7		2 2.4		- 9.8		- 9.8		3 4.3	

Эрүүл мэндэд учруулсан хохирлын хувьд 2021 оны байдлаар нийт 8299 хүн гэмтсэн бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, 124 буюу 1.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Эд хөрөнгийн хохирлын хувьд 180339.4 сая төгрөгийн хохирол учирсан ба урьд онтой харьцуулбал, 74598.3 сая төгрөг буюу 29.3%-иар буурчээ.

Нийт хохирсон иргэдийн 13573 буюу 54.3% нь Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хохирсон байх бөгөөд 6523 буюу 48%-ийг Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан залилах гэмт хэргийн хохирогч дангаараа эзэлж байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хохирогчийн дэлгэрэнгүй мэдээллээс үзэхэд эмэгтэй, 30-39 насны, бүрэн дунд боловсролтой иргэд зонхилж байна.

Хүснэгт №2. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол нийслэлд /2019-2020/

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Учирсан хохирол /сая.төг/					
			Нийт		Гэмт хэргийн ангилал			
					Хөнгөн		Хүнд	
			2020	2021	2020	2021	2020	2021
1	Баруун бүс	Баян-Өлгий	822.9	761.8	540.0	283.7	282.9	478.1
2		Говь-Алтай	697.0	681.8	341.3	364.7	355.7	317.1
3		Завхан	1214.5	1951.3	738.1	1475.9	476.5	475.4
4		Үүнээс: Тосонцэнгэл	259.4	622.3	62.1	529.6	197.3	92.7
5		Увс	444.4	944.6	210.4	653.3	234.0	291.3
6		Ховд	936.6	862.6	745.4	724.4	191.2	138.2
7		Үүнээс : Булган	169.2	185.9	144.6	155.9	24.6	30.0
8	Хангайн бүс	Архангай	1645.5	1350.5	779.3	675.6	866.2	674.9
9		Баянхонгор	1168.0	999.8	779.9	617.5	388.0	382.3
10		Булган	1603.7	2716.9	1295.6	2279.6	308.1	437.4
11		Орхон	1859.7	1321.3	1107.7	956.7	752.0	364.6
12		Өвөрхангай	772.9	725.0	558.3	408.9	214.6	316.1
13		Үүнээс: Хархорин	279.8	290.0	188.9	221.9	90.8	68.2
14		Хөвсгөл	2158.5	1607.8	1538.2	1067.0	620.2	540.8
15	Төвийн бүс	Говьсүмбэр	3585.9	319.7	3541.9	221.4	44.0	98.3
16		Дархан-Уул	1681.6	1732.1	1450.9	1198.8	230.6	533.3
17		Дорноговь	1127.6	1550.4	893.1	953.3	234.6	597.1
18		Үүнээс: Замын-Үүд	497.1	853.0	407.1	418.3	90.0	434.8
19		Дундговь	692.9	711.9	411.3	530.6	281.6	181.3
20		Өмнөговь	2471.8	1011.0	1074.9	865.4	1396.9	145.6
21		Үүнээс:Цогтцэций сум	1961.3	669.1	777.4	630.5	1184.0	38.6
22		Сэлэнгэ	1294.2	2261.7	1038.5	1752.5	255.7	509.2
23		Үүнээс: Мандал	254.9	566.2	178.5	530.5	76.4	35.7
24		Төв	3250.1	3741.9	2504.4	3190.4	745.7	551.5
25		Үүнээс: Заамар	1133.0	936.0	811.9	810.4	321.1	125.6
26	Зүүн бүс	Дорнод	1387.9	2149.6	986.4	1524.1	401.5	625.5
27		Сүхбаатар	1445.6	1207.5	428.3	1004.3	1017.3	203.2
28		Хэнтий	2291.4	1573.0	1631.6	951.7	659.8	621.3
29		Үүнээс: Бор-Өндөр	242.8	346.7	131.4	164.9	111.4	181.8
30	Нийслэл		222257.9	149283.9	197239.6	100477.3	25018.1	48806.6
31	Баянгол		15590.0	19447.4	12849.9	16764.8	2740.1	2682.5
32	I хэлтэс		9984.4	10606.2	8069.3	8934.5	1915.1	1671.8
33	II хэлтэс		5605.6	8841.2	4780.6	7830.4	825.0	1010.8
34	Баянзүрх		23473.7	24936.5	18334.8	17711.3	5138.9	7225.2
35	I хэлтэс		7911.1	14575.0	7148.5	9820.5	762.6	4754.5
36	II хэлтэс		7730.7	6803.3	6282.1	4706.3	1448.7	2097.0
37	III хэлтэс		7831.9	3558.2	4904.3	3184.5	2927.6	373.7
38	Сүхбаатар		25929.4	42810.5	18436.7	27973.6	7492.8	14836.9
39	I хэлтэс		21174.3	40860.1	13955.5	26437.1	7218.8	14423.0
40	II хэлтэс		4755.1	1950.4	4481.2	1536.5	273.9	413.9
41	Сонгинохайрхан		11706.5	11055.1	8974.8	9163.4	2731.7	1891.6
42	I хэлтэс		6646.7	8277.2	5072.5	7055.3	1574.2	1221.9
43	II хэлтэс		2886.8	1341.3	2541.1	1045.6	345.6	295.8
44	III хэлтэс		2173.0	1436.6	1361.2	1062.6	811.9	374.0
45	Хан-Уул		107075.0	35747.8	105607.0	15276.1	1467.9	20471.6
46	I хэлтэс		104942.0	31164.3	104037.0	11937.1	905.2	19227.2
47	II хэлтэс		2133.0	4583.5	1570.2	3339.0	562.7	1244.5
48	Чингэлтэй		37581.8	13898.8	32345.4	12351.1	5236.4	1547.8

49	I хэлтэс		36260.0	9139.5	31174.3	7760.5	5085.6	1379.0
50	II хэлтэс		1321.8	4759.3	1171.1	4590.6	150.7	168.7
51	Багануур		155.5	393.5	111.5	376.7	44.1	16.8
52	Багахангай		77.4	40.0	41.3	29.6	36.2	10.5
53	Налайх		668.5	954.4	538.3	830.7	130.2	123.7
54	Бусад		127.1	873.2	127.1	208.4		664.8
55	ИАТ		18.4		16.8		1.6	
56	Төмөр зам		1464.4	85.0	1167.4	84.9	297.0	0.2
57	Мөрдөн байцаах алба		28812.9	20975.1	28596.8	6928.6	216.1	14046.6
58	Эрүүгийн цагдаагийн алба		6554.6	23496.7	2857.0	10759.2	3697.6	12737.5
59	Замын цагдаагийн газар		2367.9	2726.0	2184.9	2573.1	183.0	152.9
60	НЦУГ	ХГХТХ	389.0	292.4	192.4	216.6	196.7	75.9
61	НЦУГ	ХОХГХТХ	318.5	255.3	66.7	107.0	251.9	148.3
62	Хар тамхитай тэмцэх газар		8.9	22.8	8.1	21.8	0.8	1.0
63	Экологийн цагдаагийн алба		274.9	1860.4	242.4	1755.1	32.5	105.3
64	АТГ		2245.8	648.5	1893.6	97.1	352.3	551.5
65	ТЕГ -ын МБХ		289.9	30.3	289.9	29.8		0.5
66	Улсын дүн		254937.6	180339.4	219962.2	122385.6	34975.3	57953.8
Өсөлт бууралт/тоогоор/			-74598.3		-97576.6		22978.4	
Өсөлт бууралт /хувиар/			-29.3		-44.4		65.7	

Хүснэгт №3. Өмчийн хэлбэр.

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Учирсан хохирол /сая.төг/							
			Өмчийн хэлбэр							
			Орон нутгийн		Үүнээс					
					Өмчийн		Өмчийн оролцоотой		Гадаадтай хамтарсан хөрөнгө оруулалттай	
			2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
1	Баруун бүс	Баян-Өлгий	2.8				2.8			
2		Говь-Алтай	34.8	2.0	34.8			2.0		
3		Завхан	6.6	21.8	5.8	15.1	0.8	6.7		
4		Үүнээс: Тосонцэнгэл	2.4	0.3	2.4	0.3				
5		Увс	20.4	35.6	20.4	35.6				
6		Ховд	102.5	91.1	93.5	53.8	9.0	36.3		1.0
7		Үүнээс : Булган	64.0	53.3	62.7	53.3	1.3			
8	Хангайн бүс	Архангай	23.8	47.4		43.8	23.8	3.5		
9		Баянхонгор	28.2	18.9	4.7	1.9	23.4	17.0		
10		Булган	644.9	245.7	169.0	134.4	475.8	111.4		
11		Орхон	2.9	3.1		1.5	2.9	1.6		
12		Өвөрхангай	6.5	69.0	4.2		2.3	69.0		
13		Үүнээс: Хархорин	3.9		1.6		2.3			
14		Хөвсгөл	933.9	314.9	759.6	258.5	174.3	56.4		
15	Төвийн бүс	Говьсүмбэр	13.3	0.4		0.4	13.3			
16		Дархан-Уул	290.1	553.7	290.1	553.7				
17		Дорноговь	16.3				16.3			
18		Үүнээс: Замын-Үүд	16.3				16.3			
19		Дундговь	21.0	3.2		3.0	21.0	0.2		
20		Өмнөговь	5.5	0.7	0.5		5.0	0.7		
21		Үүнээс:Цогтцэций сум								
22		Сэлэнгэ	79.2	256.2	46.7	154.8	32.5	99.4		2.0
23		Үүнээс: Мандал	5.5	105.0		16.2	5.5	86.8		2.0
24		Төв	41.5	323.3	1.0	306.9	40.5	16.4		
25		Үүнээс: Заамар	2.0	257.8		253.3	2.0	4.5		

26	Зүүн бүс	Дорнод	5.4	381.0	4.5	222.2	0.9	158.7		
27		Сүхбаатар	0.5	232.9		232.9	0.5			
28		Хэнтий	29.9	14.3	11.2	8.8	18.8	5.5		
29		Үүнээс: Бор-Өндөр								
30	Нийслэл		85.1	692.6	0.5	87.1	71.9	605.3	12.7	0.2
31	Баянгол			360.2				360.0		0.2
32	I хэлтэс			0.2						0.2
33	II хэлтэс			360.0				360.0		
34	Баянзүрх		10.6	303.0		86.9	10.1	216.1	0.5	
35	I хэлтэс		9.0	191.8			9.0	191.8		
36	II хэлтэс		0.5	2.4				2.4	0.5	
37	III хэлтэс		1.1	108.8		86.9	1.1	21.9		
38	Сүхбаатар									
39	I хэлтэс									
40	II хэлтэс									
41	Сонгинохайрхан		4.5	4.4	0.5	0.3	1.8	4.1	2.2	
42	I хэлтэс		4.5	3.8	0.5	0.3	1.8	3.6	2.2	
43	II хэлтэс			0.5				0.5		
44	III хэлтэс									
45	Хан-Уул		1.5	22.0			1.5	22.0		
46	I хэлтэс		1.5				1.5			
47	II хэлтэс			22.0				22.0		
48	Чингэлтэй		11.3	3.1			1.3	3.1	10.0	
49	I хэлтэс		10.0	1.7				1.7	10.0	
50	II хэлтэс		1.3	1.4			1.3	1.4		
51	Багануур									
52	Багахангай									
53	Налайх		57.1				57.1			
54	Бусад									
55	ИАТ									
56	Төмөр зам		2.2	0.2					2.2	0.2
57	Мөрдөн байцаах алба									
58	Эрүүгийн цагдаагийн алба									
59	Замын цагдаагийн газар		5.0				5.0			
60	НЦУГ	ХГХТХ								
61		ХОХГХТХ								
62	Хар тамхитай тэмцэх газар									
63	Экологийн цагдаагийн алба		24.8	220.1		151.1	24.8	69.0		
64	АТГ		772.7		718.7		54.0			
65	ТЕГ -ын МБХ									
66	Улсын дүн		2395.1	3307.9	1446.6	2114.5	935.9	1190.2	12.7	3.2
Өсөлт бууралт/тоогоор/			912.8		668.0		254.3		-9.5	
Өсөлт бууралт /хувиар/			38.1		46.2		27.2		-74.9	

Хувийн өмчид нийт 168264.2 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирснаас Монгол Улсын иргэний өмчид 153169.3 сая төгрөгийн, гадаад улс болон иргэнтэй хамтарсан 12492.9 сая төгрөгийн, гадаад улсын болон иргэний 2602.0 сая төгрөгийн хохирол тус тус учирсан байна.

Хохирол нөхөн төлүүлэлтийн хувьд хэрэг бүртгэлтийн шатанд 2021 оны байдлаар 90376.7 сая төгрөгийн хохирол нөхөн төлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.1%-иар өссөн байна.

Хүснэгт №4. Хохирол нөхөн төлүүлэлт.

№	Бүс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллага	Хохирол нөхөн төлүүлэлт /сая.төг/											
			Үүнээс:				Өмчийн хэлбэр							
			Мөрдөн байцаалтын шатанд		Хэрэг бүртгэлтийн шатанд		Төрийн өмчийн		Үүнээс					
									Орон нутгийн өмчийн		Өмчийн оролцоотой		Гадаадтай хамтарсан хөрөнгө оруулалттай	
			2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
1	Баруун бүс	Баян-Өлгий	540.8	644.6	8.6	2.3	3.8	29.8	3.8	29.8				
2		Говь-Алтай	500.7	570.9			201.4		201.4					
3		Завхан	496.7	1024.6	2.0	6.9	7.8	42.7	7.8	42.6		0.1		
4		Үүнээс: Тосонцэнгэл	102.1	196.8		5.1		24.0		24.0				
5		Увс	314.4	649.0			20.1	0.8	20.1	0.8				
6		Ховд	484.0	333.5	55.7	158.0	48.9	22.4	48.9	0.4				22.0
7		Үүнээс : Булган	123.6	70.6	16.4	3.1	33.9	0.1	33.9	0.1				
8	Хангайн бүс	Архангай	805.1	759.9	2.1	0.8	11.0	94.7	1.4	78.9	9.3	15.8	0.3	
9		Баянхонгор	602.6	432.1	7.6	6.0	6.6		6.6					
10		Булган	892.0	824.1		2.4		40.3		40.3				
11		Орхон	906.9	546.8			59.0	4.9	22.0	4.6	37.0			0.3
12		Өвөрхангай	312.9	419.5	0.2	2.6	9.2	49.7	9.2	49.7				
13		Үүнээс: Хархорин	91.1	160.5			9.2	49.7	9.2	49.7				
14		Хөвсгөл	716.5	979.8										
15	Төвийн бүс	Говьсүмбэр	160.3	231.9										
16		Дархан-Уул	759.1	433.8			0.9	1.9	0.9	1.9				
17		Дорноговь	812.2	766.7	2.6	0.9	314.2	48.3	312.1				2.1	48.3
18		Үүнээс: Замын-Үүд	400.9	469.7	2.6		179.2	48.3	177.1				2.1	48.3
19		Дундговь	257.0	309.2	0.1	2.0		125.4		0.3		125.2		
20		Өмнөговь	912.5	644.7	1.1	2.3	1.0	126.1	1.0	126.1				
21		Үүнээс:Цогтцэций сум	581.5	440.3	1.2	0.3		109.1		109.1				
22		Сэлэнгэ	676.3	1159.8	17.0	48.1	1.0	50.1	1.0	50.1				
23		Үүнээс: Мандал	133.4	286.7	13.8	44.5	1.0	0.5	1.0	0.5				
24		Төв	2343.1	2915.9	42.1	78.5	34.4	16.9	28.7	13.3		3.6	5.6	
25		Үүнээс: Заамар	916.1	567.0	18.6	3.5	1.3	13.3	1.3	13.3				
26	Зүүн бүс	Дорнод	639.3	1170.2	19.6	52.7	5.1		5.1					
27		Сүхбаатар	1036.4	524.0				13.2		13.2				
28		Хэнтий	534.2	655.2		8.9		24.0				24.0		
29		Үүнээс: Бор-Өндөр	101.7	140.2				24				24		
30	Нийслэл		67083.7	73954.6	119.4	49.8	1391.6	2939.1	1116.6	2855.2	0.0	82.4	275.0	1.5
31	Баянгол		7023.5	6969.6	3.3	4.8	275.0						275.0	
32	I хэлтэс		4679.8	2787.9	1.3	4.8	275.0						275.0	
33	II хэлтэс		2343.6	4181.7	2.0									
34	Баянзүрх		7810.1	10432.7	32.9	1.4	1036.5	121.2	1036.5	121.2		0.0		
35	I хэлтэс		2918.2	6926.8	18.4	0.5	48.6	33.3	48.6	33.3				
36	II хэлтэс		2009.3	1415.8	2.3	0.9		0.0				0.0		
37	III хэлтэс		2882.6	2090.1	12.1		987.9	87.9	987.9	87.9				
38	Сүхбаатар		12364.6	27301.2	12.5	0.1	44.7	0.5	44.7	0.5				
39	I хэлтэс		10176.1	26412.7	2.5	0.1	44.7		44.7					
40	II хэлтэс		2188.4	888.5	10.0			0.5		0.5				
41	Сонгинохайрхан		4421.6	4298.1	13.1	5.1	1.5	1.8	1.5	0.3				1.5
42	I хэлтэс		1467.2	2919.0	6.5	3.8	1.0	1.8	1.0	0.3				1.5
43	II хэлтэс		1980.3	937.1	0.8	0.5								


44	III хэлтэс	974.1	441.9	5.7	0.8	0.5		0.5					
45	Хан-Уул	6324.2	16994.1	2.0	3.9								
46	I хэлтэс	5028.4	14876.3	2.0	2.0								
47	II хэлтэс	1295.8	2117.8		1.9								
48	Чингэлтэй	28722.2	7547.6	54.7	29.9	34.0	2810.6	34.0	2728.6		82.0		
49	I хэлтэс	28055.7	4019.3	11.1		13.2	82.0	13.2			82.0		
50	II хэлтэс	666.6	3528.3	43.6	30.0	20.8	2728.6	20.8	2728.6				
51	Багануур	100.2	57.1										
52	Багахангай	40.7	39.9	1.0	0.1								
53	Налайх	276.6	314.2		4.4		5.0		4.6		0.4		
54	Бусад	14.3	3.8										
55	ИАТ	16.4											
56	Төмөр зам	1447.8	83.8	1.5	1.0	417.7	50.1	135.0				282.7	50.1
57	Мөрдөн байцаах алба	24964.6	12983.4		2.1								
58	Эрүүгийн цагдаагийн алба	103.9	6750.6				2799.8		2717.8		82.0		
59	Замын цагдаагийн газар	1922.7	2310.3	28.7	5.1								
60	НЦУГ ХГХТХ	130.2	147.2										
61	НЦУГ ХОХГХТХ	245.5	108.3										
62	Хар тамхитай тэмцэх газар	8.1	10.6										
63	Экологийн цагдаагийн алба	184.2	301.9			143.1	218.8	143.1	218.4		0.4		
64	АТГ	1368.9	268.0			294.4		19.4				275.0	
65	ТЕГ -ын МБХ	7.9	4.0		17.3								
66	Улсын дүн	81801.2	89954.5	278.2	422.2	2115.9	3630.3	1786.5	3307.1	46.3	251.1	283.0	72.1
Өсөлт бууралт/тоогоор/		8153.3		144.1		1514.4		1520.6		204.7		-210.9	
Өсөлт бууралт /хувиар/		10.0		51.8		71.6		85.1		5.4 дах		-74.5	

Хувийн өмчийн 84143.9 сая төгрөгийн хохирол нөхөн төлүүлснээс, Монгол Улсын иргэний өмчийн 84079.9 сая төгрөгийн, гадаад улс болон иргэнтэй хамтарсан 25.1 сая төгрөгийн, гадаад улсын болон иргэний 39.7 сая төгрөгийн хохирлыг тус тус нөхөн төлүүлжээ. Хохирол нөхөн төлүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 6.9%-иар өссөн байна.

2.Авлигатай тэмцэх байгууллагын статистик

2021 онд 1307 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, гэмт хэргийн улмаас 1,002,100,805,191 /нэг их наяд, 2 тэрбум, нэг зуун сая, найман зуун таван мянга нэг зуун ерэн нэг/ төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 96,207,070,220 /ерэн зургаан тэрбум, хоёр зуун долоон сая, далан мянга, хоёр зуун хорь/ төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 119,502,691,958 /нэг зуун арван есөн тэрбум, таван зуун хоёр сая, зургаан зуун ерэн нэгэн мянга, есөн зуун тавин найм/ төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 2.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График №1. Учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгө, нөхөн төлүүлсэн байдлыг өмнөх онтой харьцуулав.



2020 онд АТГ гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 83.3%-тай тэмцэх хэмжээний эд

хөрөнгийг битүүмжилж байсан бол 2021 онд 11.9% болон буурчээ.

2021 онд АТГ-аас мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс шүүхээр хянан шийдвэрлэгдсэн 160 хэргийн шийтгэх тогтоолоос 116-г хүлээн аваад байгаа бөгөөд ийнхүү хүлээн авсан тогтоолоос үзэхэд мөрдөн шалгах ажиллагааны явцад хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан болон битүүмжлэн хамгаалсан хөрөнгөөс шүүх 1,444,012,295 төгрөгийг улсын орлого болгохоор шийдвэрлэж 821,780,000 төгрөгийн торгох ял оногдуулсан байна[4].

3.Прокурорын байгууллагын статистик[5]

2021 онд бүртгэсэн нийт гэмт хэргийн улмаас нийт 26369 хүн хохирсноос, 12007 эмэгтэй, 1383 хүүхэд байна. Мөн 10349 хүн гэмтэж, 661 хүн гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирчээ.

Нийт 12003 хүн гэмт хэргийн улмаас нас барсан гэж бүртгэгджээ. Нас барсан байдлыг өмнөх оныхтой харьцуулахад 668 буюу 25%-иар буурсан байна.

Хүснэгт №5. Прокурорын байгууллагад бүртгэгдсэн хохирогч.

		Прокурорын байгууллага					
		Хохирогч	Үүнээс		Нас барсан хүн	Эрүүл мэндээрээ хохирсон хүн	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн
			Эмэгтэй	Хүүхэд			
Нийт		**26659**	**12007**	**1383**	**2003**	**10349**	**661**
Нийслэл		17863	8584	910	1188	6202	309
1	Тээврийн ПГ	718	336	50	111	498	0
2	Нийслэл ПГ	237	104	7	2	19	2
3	Багануур ДПГ	113	42	7	3	104	1
4	Налайх,Багахангай ДПГ	359	166	31	31	212	25
5	Баянгол ДПГ	2226	1199	88	91	596	18
6	Баянзүрх ДПГ	4708	2201	261	387	1527	61
7	Сонгинохайрхан ДПГ	3366	1557	192	252	1347	105
8	Сүхбаатар дүүргийн ПГ	2459	1185	124	54	670	42
9	Хан-Уул ДПГ	2080	989	90	217	598	21
10	Чингэлтэй ДПГ	1826	900	62	40	631	34
Орон нутаг		8550	3447	475	815	4147	352
1	Архангай АПГ	224	79	6	19	170	12
2	Баян-Өлгий АПГ	291	92	10	26	87	12
3	Баянхонгор АПГ	299	125	25	16	210	11
4	Булган АПГ	253	88	16	33	141	2
5	Говь-Алтай АПГ	222	78	13	14	92	5
6	Говьсүмбэр АПГ	170	78	15	9	91	8
7	Дархан-Уул АПГ	561	271	35	34	249	56
8	Дорноговь АПГ	447	201	25	40	210	14
9	Дорнод АПГ	481	174	38	27	256	19

[4] Цахим эх сурвалж: https://iaac.mn/posts?category_id=13945

[5] Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбатын 2022.06.16-ны өдрийн 1/3917 дугаартай албан бичгийн хавсралт.

10	Дундговь АПГ	240	86	11	20	131	13
11	Завхан АПГ	311	93	13	21	164	15
12	Орхон АПГ	548	271	37	60	252	34
13	Өвөрхангай АПГ	573	222	43	88	236	9
14	Өмнөговь АПГ	478	177	29	103	244	23
15	Сүхбаатар аймгийн ПГ	375	149	15	18	128	16
16	Сэлэнгэ АПГ	636	288	44	75	318	23
17	Төв АПГ	576	207	20	40	369	25
18	Увс АПГ	154	44	7	24	96	1
19	Ховд АПГ	402	151	19	25	193	15
20	Хөвсгөл АПГ	653	362	24	35	236	5
21	Хэнтий АПГ	669	216	31	88	274	35

Прокурорын байгууллагаас гэмт хэргийн улмаас хохирсон хуулийн этгээдийн талаарх судалгааг ирүүлээгүй болно.

4.Шүүхийн статистик[6]

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2021 онд 17979 шүүгдэгч, 5 хуулийн этгээдэд холбогдох 14182 хэрэг шийдвэрлэхээс 14484 шүүгдэгч, 4 хуулийн этгээдэд холбогдох 12068 хэргийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн улмаас 2021 онд 15869 хүн хохирогчоор тогтоогдсоноос 5639 эмэгтэй, 712 хүүхэд байна. Албан тушаалаар нь авч үзвэл, эмч 108, багш 219, шүүгч 1, прокурор 1, мөрдөгч 15, хууль сахиулах байгууллагын ажилтан 119, оюутан 858, малчин 1854, ажилгүй 3836 байна. Боловсролын хувьд дээд боловсролтой 3581, бүрэн дунд боловсролтой 6339, суурь боловсролтой 2064, бага боловсролтой 1175, боловсролгүй 891 байна.

Гэмт хэргийн улмаас 595 хуулийн этгээд хохирогчоор тогтоогдсон бөгөөд төрийн захиргааны байгууллага 445, хязгаарлагдмал хариуцлагатай компани 127 бүртгэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Хохирогчийг иргэний харьяаллаар нь авч үзвэл, Монгол Улсын иргэн 15844, гадаадын иргэн 25, харьяалалгүй хүн бүртгэгдээгүй байна.

Гэмт хэргийн улмаас 522 хүн нас барснаас 129 эмэгтэй, 40 хүүхэд байна. Гэмт хэргийн улмаас 7237 хүн гэмтсэнээс 1389 эмэгтэй, 149 хүүхэд гэмтлийн зэргийн хувьд хүнд 745, хүндэвтэр 944, хөнгөн 5548 хүн гэмтжээ.

Гэмт хэргийн улмаас 82,012,148,998 төгрөгийн хохирол учирснаас хүнд 50,325,605,456 төгрөг, хуулийн этгээдэд 31,686,543,542 төгрөгийн хохирол учирчээ.

5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистик

Төрөөс олгосон нөхөн төлбөрийн тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэргийн шүүхээс тогтоосон торгох ялыг гүйцэтгэсэн үнийн дүнгийн 60 хувь, гэм буруутай төлбөр төлөгчөөс нөхөн төлүүлсэн төлбөрийн мөнгийг “Гэмт хэргийн нөхөн төлбөрийн сан”-д байршуулж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21 зүйл, заалтад хамаарах гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэж байна.

Төрөөс нөхөн төлбөр олгох үндэслэлийн дагуу 2020 онд 411.780.752 төгрөг, 2021 онд 347.731.619 төгрөгийг тус тус төлбөр авагч иргэдэд олгуулж, уг мөнгийг зохих санд буцаан төвлөрүүлэх, мөнгөн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэсэн.

[6] Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Р.Батрагчаагийн 2022.06.10-ны өдрийн 03/753 дугаартай албан бичгийн хавсралт.

2020-2021 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1, 11.1, 11.4, 12.1, 17.2 дахь зүйл, заалтад заасан гэмт хэргийн улмаас хохирсон төлбөр авагч иргэдэд нөхөн төлбөр олгож, төлбөр төлөгчөөс 2020 онд 54.472.836 төгрөг, 2021 онд 51.939.535 төгрөгийг зохих санд төвлөрүүлэн ажилласан.

Төрөөс 2020-2021 онд олгосон гэмт хэргийн нөхөн төлбөрт хамаарах эрүүгийн хэргийн шийдвэрүүдийг авч үзвэл:


-2014-2015 оны шүүхийн шийдвэрээр 3 төлбөр авагчид 17.351.751 төгрөг;

-2016-2017 оны шүүхийн шийдвэрээр 13 төлбөр авагчид 79.958.227 төгрөг;

-2018-2019 оны шүүхийн шийдвэрээр 56 төлбөр авагчид 536.739.368 төгрөг;


-2020-2021 оны шүүхийн шийдвэрээр 17 төлбөр авагчид 125.463.025 төгрөг буюу 759.512.371 төгрөгийн нөхөн төлбөрийг 89 төлбөр авагч иргэнд төрөөс олгуулсан.

Төрөөс нөхөн төлбөр авсан гэмт хэргийн хохирогчийн тоо



	Оршуулгын зардал	Эмчилгээний зардал	Ажилгүй байсан хугацаа ны
2020 он	22	9	2
2021 он	46	10	

Төрөөс олгосон нөхөн төлбөр хэмжээ /сая.төг/



	Оршуулгын зардал	Эмчилгээний зардал	Ажилгүй байсан хугацаа ны
2020 он	140.7	260.7	10.2
2021 он	318	29.7	

<u>Зөрчлийн хариуцлага тооцсон тухай</u>

Иргэний, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээдийн саад учруулсан, шүүхийн шийдвэрийг биелэлтийг хангуулах хууль ёсны шаардлага биелүүлээгүй, төлбөр төлөхөөс зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэхүйг үндэслэн ахлах шийдвэр гүйцэтгэгчдээс Зөрчлийн тухай хуулийн 6.20, 15.2, 15.27 дугаар зүйлийг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг үндэслэн 2020 онд 326 холбогдогчид 100.6 сая төгрөгийн торгох шийтгэл 68 холбогдогчид баривчлах шийтгэл, 2021 онд 118 холбогдогчид 32.6 сая төгрөгийн торгох шийтгэл, 30 холбогдогчид баривчлах шийтгэл, албадан сургалтанд хамрагдах албадлагын арга хэмжээ тогтоолгож, шийтгэлийн хуудасны биелэлтийг хангуулсан.


2021 онд шийтгэл оногдуулсан зөрчлийн холбогдогчийг авч үзвэл:


-төлбөрийн үүрэг хүлээсэн 94 холбогдогч

-шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус, гуравдагч этгээд болох 13 холбогдогч

-хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээ биелүүлээгүй 50 холбогдогчид тус тус зөрчлийн хариуцлага тооцох арга хэмжээ авсан.

Ахлах шийдвэр гүйцэтгэгчдээс нийслэлд 112, орон нутагт 45 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан байна.





Гэмт хэргийн хохирол, төлбөр барагдуулалт


2020 онд 77.6 тэрбум төгрөгийн 1903 төлбөртэй хоригдол, 2021 онд 89.7 тэрбум төгрөгийн 1383 төлбөртэй хоригдол хорих ангид яд эдэлж байсан.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулах ажлын хүрээнд 2020 онд хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс 293.0 сая төгрөг, 2021 онд 241.8 сая төгрөг суутгасныг гүйцэтгэх баримт бичигт заасан хохирол, төлбөрт тооцон шилжүүлсэн байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр хохирол, төлбөр гаргуулах гүйцэтгэх баримт бичгийг албадан гүйцэтгүүлэхээр 2020-2021 онд нийт 144.803.984,0 төгрөгийг төлбөр авагч иргэнд, 125.435.198,2 төгрөгийг төлбөр авагч-хуулийн этгээдэд, 20.539.033,5 төгрөгийг улсын орлогод оруулах нийт 14496 гүйцэтгэх баримт бичгийг шүүх, төлбөр авагчдаас тус тус ирүүлсэн байна.


-2020 онд 22.930.821,8 төгрөгийн 4392 гүйцэтгэх баримт бичгийг;

-2021 онд 53.486.746,2 төгрөгийн 4743 гүйцэтгэх баримт бичгийг тус тус шинээр хүлээн авчээ.



Монгол Улсын хэмжээнд эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр хохирол, төлбөр гаргуулах 136.358.134,0 төгрөгийн 7138 гүйцэтгэх баримт бичгийг 2020 онд, 154.420.081,7 төгрөгийн 7358 гүйцэтгэх баримт бичгийг 2021 онд тус тус шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж, 2020 онд 11.989.413,5 төгрөгийг, 2021 онд 44.095.992,3 төгрөгийн хохирол, төлбөрийг барагдуулсан.

Эрүүгийн хохирол, төлбөр барагдуулах ажлын хүрээнд 2020 онд 3904, 2021 онд 4279 гүйцэтгэх баримт бичгийг эцэслэн шийдвэрлэж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангажээ.



Зөрчлийн шийтгэл, хохирол барагдуулалт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан 6.9 тэрбум төгрөгийн 2402 гүйцэтгэх баримт бичигт 2020 онд, 5.4 тэрбум төгрөгийн 2589 гүйцэтгэх баримт бичигт 2021 онд зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, нийт 7.2 төгрөгийн 4232 гүйцэтгэх баримт бичгийг эцэслэн шийдвэрлэсэн.

2020 онд Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичгийг авч үзвэл:

-2282 гүйцэтгэх баримт бичгийн 3.6 тэрбум төгрөгийн торгох шийтгэл;

-1 гүйцэтгэх баримт бичгийн 208.7 сая төгрөгийн зөрчил үйлдэж, олсон хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээг;


-75 гүйцэтгэх баримт бичигт холбогдох зөрчлийн үр дагавар, хохирол 999.5 сая төгрөгийн төлбөрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явагдсан.

2021 онд Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичгийг авч үзвэл:

-2361 гүйцэтгэх баримт бичгийн 3.6 тэрбум төгрөгийн торгох шийтгэл;

-44 гүйцэтгэх баримт бичгийн 11.3 сая төгрөгийн зөрчил үйлдэж, олсон хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээг;

-112 гүйцэтгэх баримт бичигт холбогдох зөрчлийн үр дагавар, хохирол 1.8 тэрбум төгрөгийн төлбөрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явагдсан.



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол харилцан адилгүй бүртгэгдэж байгаа нь тухайн байгууллагуудын бүртгэлийн системтэй холбоотой байна. Тухайлбал, цагдаагийн байгууллага хохирогчийн мэдүүлэг, зарим үнэлгээний дүгнэлт үндэслэн цахим санд бүртгэдэг бол

прокурорын байгууллага мөрдөн байцаалтын үед тогтоогдсон баримтын үндсэн дээр хохирлыг тодорхойлдог нь илүү бодитой гэж үзэж болохоор байна. Мөн нөгөөтэйгүүр цагдаагийн байгууллагын гэмт хэргийн цахим бүртгэлд тухайн хохирлын талаарх мэдээлэл оруулсан албан хаагч хохирлын бүрэн бодитой байдалд төдийлөн хяналт тавьдаггүй, аль болох өндөр үнийн дүнгээр хохирол шивэх хандлагатай байдаг аж.

Учир нь Мөрдөн байцаах албанаас мөрдөгчийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо хохирол нөхөн төлөлтийн байдлыг харгалздаг нь дээрх зөрүүтэй статистик бий болоход нөлөөлжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.8 дугаар зүйлийн 1.6 дахь хэсэгт хохирогчид хохирол, хор уршгийг нөхөн төлж барагдуулах бол мөнгөн төлбөр, хохирол барагдуулах ажиллагааг ямар хугацаанд, ямар хэмжээгээр хийх талаар шүүх шийдвэртээ тусгах зохицуулалттай буюу хохирол нөхөн төлүүлэх эрх хэмжээ шүүхэд байдаг.

Харин мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаас хохирол нөхөн төлүүлэх, эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор эд хөрөнгө битүүмжлэх, хураан авах зэрэг ажиллагааг бодитой хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллага, АТГ-ын тухайд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээнд дүйцэхүйц эд хөрөнгө битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авдаггүй нийтлэг байдал ажиглагдлаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэж заасан боловч Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг үнэлэх, бэхжүүлэх тогтолцоо байдаггүйгээс хохирогчийн эрх ашиг зөрчигдөх эрсдэлийг бий болгожээ.

Сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх тал дээр багагүй оролдлого хийгдэж, тодорхой хэргүүдийг шийдвэрлүүлж чадсан ч энэ нь хүний эрхэд хэр нийцтэй байна гэдэгт дүн шинжилгээ хийж цаашид боловсронгуй болгох шаардлагатай байна.



НАЙМДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ





УЛСЫН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ҮР НӨЛӨӨ

Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гишүүд өөрсдийн салбарын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид нийцүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий Прокурорын газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тагнуулын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургууль зэрэг 14 байгууллага тусгайлан төлөвлөгөө боловсруулан батлуулж, бусад 22 байгууллага гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалт тусгаж, хэрэгжилтийг ханган дүгнэсэн байна.



- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээд байна.



- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт заасныг үндэслэн “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан.





- “Иргэдийн оролцоо” төслийн дэмжлэгтэйгээр “Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн мэргэжлийн бус 1-2 дугаар дамжааны оюутнууд, мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагсдад зориулсан эрх зүйн албан бус хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааг хийж, түүнд үндэслэн албан бус сургалтын 3 төрлийн хөтөлбөр боловсруулсан. Хөтөлбөрийн дагуу үндэсний хэмжээнд 2022 онд хуваарийн дагуу сургалт явуулахаар төлөвлөсөн.





- Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 120 дугаар захирамжаар “Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт (индекс)-ийг бууруулах зорилго бүхий Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайд ахалж байгаа бөгөөд бүрэлдэхүүнд Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Төрийн албаны зөвлөл, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газар (хуучин нэрээр), Тагнуулын ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөл багтсан. Ажлын хэсгээс авч хэрэгжүүлэх эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхий сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөнд хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд 16, төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, цахим үйлчилгээний чанарыг сайжруулах хүрээнд 7, урьдчилан сэргийлэх, олон нийтийг мэдээллээр хангах хүрээнд 17, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигын хэргийг хянан шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хүрээнд 8, нийт 48 ажил, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.




Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд хийсэн онцлох ажил:

2.1.Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

- Эрүүл мэндийн яам, Тээврийн цагдаагийн албатай хамтран “Хүүхдэд ээлтэй жолооч” арга хэмжээг 2021.05.21-ний өдрөөс 1 сарын хугацаатай улсын хэмжээнд зохион байгуулсан. Мөн жил бүр зохион байгуулдаг “Замын хөдөлгөөний соёл” арга хэмжээг энэ оны 6-10 дугаар сард зохион байгуулж, нэгдсэн хяналтыг хэрэгжүүлж урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ ЦЕГ-ийн ТЦА-ны Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран зохион байгуулж ажилласан.
- Хууль сахиулах байгууллагын алба хаагчид тэр дундаа шаардлагатай нэг бүрийн тусгай хэрэгслээр буюу 58,6 сая төгрөгийн өртөг бүхий 144 ширхэг энгэрийн камер худалдан авч, Хил хамгаалах ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хил хамгаалах байгууллагад 19 нэр төрлийн 975 ширхэг “Замын тэмдэг, шон” нийлүүлж дэмжлэг үзүүлсэн байна.




2.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг 2 үе шаттай хэрэгжүүллээ. Үндэсний хөтөлбөрийн I шат /2017-2019 он/-ны хэрэгжилт 82.2 хувиар үнэлэгдсэн бөгөөд II шат /2020-2021 он/-ны хэрэгжилт урьдчилсан байдлаар 82.1 хувьтай үнэлэгдсэн байна.
- ШУА-ын Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээр “Мансууруулах үйлчилгээтэй зэрлэг ургамлын тархац, байршлыг шинэчлэн тогтоох судалгаа”-г хийлгэсэн бөгөөд судалгааны тайланг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж, холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

- Зэрлэг байдлаар ургаж буй мансууруулах үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг 14 аймаг, нийслэлд зохион байгуулсан.
- Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн байгууллагад шаардлагатай 154 сая төгрөгийн программ хангамж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авах ажлыг зохион байгуулсан.




2.3.Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 148 дугаар тогтоолоор батлсан "Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийлгэхэд 99,1%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн.
- Хилийн боомтын шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд хүний биометр мэдээлэлд суурилсан орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай 200.0 сая төгрөгийн өртөг бүхий техник хэрэгсэл, 351.0 сая төгрөгийн өртөг бүхий гарын хээ, паспорт унших зөөврийн скайнер, дүрс таних камер зэрэг тоног төхөөрөмжийг ХХЕГ-т хүлээлгэн өгсөн.
- Монгол Улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департамент хамтран Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн “Хүүхэд хамгааллын компакт гэрээ”-ний хэрэгжилтийн хоёр улсын Засгийн газрын өндөр түвшний уулзалтыг 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгууллаа. Энэхүү уулзалтаар хоёр Улсын Засгийн газар, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээг хэрэгжүүлэгч олон улсын байгууллагуудын төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, түүний үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцлээ.
- Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны зураглал гаргах судалгаа, хүн худалдаалах, түүнтэй төсөөтэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийх судалгааг тус тус гүйцэтгүүллээ.




2.4.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

- Улсын хэмжээнд нийт 715 хамтарсан баг 6065 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. 2021 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцаас эдгээр хамтарсан багуудад 333,200,000 төгрөгийн санхүүжилтийг олгож, дэмжлэг үзүүллээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн чанарын судалгааг хөндлөнгийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлж, судалгааны тайлангийн хэлэлцүүлгийг 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан.
- Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа Түр хамгаалах байрны гэр бүлийн хүчирхийллийн зөвлөгөө, тусламжийн 107 тусгай дугаарын утасны үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийлгэлээ.
- 2021 оны жилийн эцсийн байдлаар эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх 715 хамтарсан багаас 6207 кейс бүртгэгдэж, 3084 кейс шийдвэрлэж, 3281 кейстэй ажиллаж, 8100 гэр бүлд үйлчилгээ үзүүлж, 1974 иргэний аюулгүй байдлыг хангаж, 9321 хүүхдэд хамгааллын үйлчилгээ, 3017 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ, 4932 иргэнийг зохих байгууллагуудад холбон зуучилж, үйлчилгээнд хамруулсан байна.




2.5.Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

- Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Дотоод хэргийн их сургуультай хамтран “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн нэгдмэл байдал, уялдааг хангах боломж” судалгааны тайлангийн хэлэлцүүлгийг 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан.




2.6.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр

- Малчдын эрх зүйн мэдлэгт зориулсан “Малчин танд” гарын авлагыг 1500 ширхэгийг хэвлүүлж, орон нутгийн салбар зөвлөлөөр дамжуулан малчдад түгээсэн.
- Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 иргэн, 16 аж ахуйн нэгж, 18 мах боловсруулах үйлдвэр, мал нядалгааны газруудад 360 эргэдэг 307,000,000 төгрөгний

өртөгтэй, 115 хяналтын камерыг аж ахуйн нэгж байгууллагын зардлаар суурилуулан, Цагдаагийн байгууллагын хяналтын камерын нэгдсэн сүлжээнд холбоод байна.




2.7.Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр

- Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/580, А/228 дугаар тушаалыг үндэслэн согтуурах донтой хүнийг хорт зуршлаас татгалзуулах, сэтгэц, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг сайн дурын үндсэн дээр “Цагаан өргөө” сувилалын газарт ГБХЗХГ, Наркологийн төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын оролцоотойгоор хамтран зохион байгуулж, 104 хүнийг эмчлээд байна.
- Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны орчин, үйлчилгээг сайжруулах зорилгоор 38 нэр төрлийн, нийт 140 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагуудад хүлээлгэн өглөө.




Гурав. Соён гэгээрүүлэх чиглэлээр:

- Гэмт хэргийн тоон мэдээллээр нийт 69 инфографикыг бэлтгэж *www.zarig.mn, www.tovch.mn, www.itoim.mn, www.news.mn, www.lnews.mn, www.tur.mn, www.zaluucom.mn, www.zuv.mn, www.urug.mn* цахим хуудсаар дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж, давхардсан тоогоор 5,872,722 үзэлттэй байна.




- Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлах, жендэрт суурилсан хүчирхийллийн хор уршгийн талаар иргэд олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, нийгмийн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “20к клуб” ТББ-тай хамтран “Эр хүн Би гэртээ” соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд “Би гэртээ”-цахим хуудсыг шинээр нээж 4 лайв, 9 подкастыг бэлтгэсэн. Бэлтгэсэн контентийг “Би Гэртээ” цахим хуудаст байршуулснаас нийт үзсэн 1,243,859 сэтгэгдэл бичсэн 9,456, бусадтай хуваалцсан 4,483 удаа хандалттай байна.





- Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба НҮБ-ын Олон Улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Мөрөөдлийн Шүхэр” соён гэгээрүүлэх арга хэмжээг хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх агуулгаар 9 видео, 1 нэвтрүүлэг бэлтгэсэн. Контентийг нийгмийн сүлжээн дэх “Мөрөөдлийн Шүхэр” цахим хуудсанд байршуулж, давхардсан тоогоор 194,061 удаа үзсэн, 369 удаа сэтгэгдэл бичсэн хандалт авсан байна.





- Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Экологийн цагдаагийн алба хамтран “Ногоон дуу хоолой” аяныг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд нийт 19 контент, хүрээлэн байгаа орчноо хайрлан хамгаалах уламжлалт зан заншил, орчин үеийн хандлага, иргэний оролцоог таниулсан агуулгатай бичлэг 32, зурагт сурталчилгаа 43, нийт 94 мэдээ, мэдээллийг цахим сүлжээнд байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ярилцлага 6, нэвтрүүлэг 3, сонин цахим хуудаст мэдээ, ярилцлага 16 өгсөн. Цахим орчинд, олон нийтэд хүргэсэн мэдээ, мэдээлэл давхардсан тоогоор 10,701,229 хүнд хүрч, 192,246 хүнд таалагдаж, 61,966 хүн бусадтай хуваалцаж, 7,277 хүн сэтгэгдэл үлдээснээс 77 хувь нь үйл ажиллагааг дэмжсэн, 6.0 хувь нь шүүмжилсэн, 17 хувь нь бусад сэтгэгдлүүд байв .Үүрэн холбооны “Мобиком копораци”-ийн 1,001,520 хэрэглэгчдэд зорилтот мессэжийг илгээлээ.







- Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO), Nomadic Content хамтран зөвлөгөө мэдээлэл тусламжийн "Family Center.mn" цахим хуудас нээсэн. Бэлтгэсэн контентыг цахим хуудсаар лайв хэлбэрээр цацуулснаас давхардсан тоогоор үзсэн 2,186,369, сэтгэгдэл бичсэн 3,540, бусадтай хуваалцсан 1,621 удаа байна.



- “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай уриан дор зохион байгуулж, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хууль сурталчлах нэгдсэн арга хэмжээ зохион байгууллаа. Энэ аяныг угтаж НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Нарны сүүдэр” уран сайхны киног бүтээлгэж, олон нийтэд 29 телевийн сувгаар түгээсэн. 2021 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар байдлаар “Нарны сүүдэр” уран сайхны киног 180,600 хүн үзэж, 1007 сэтгэгдэл бичиж, 6000 гаруй бусадтай хуваалцсан байна.





- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” Үндэсний IV чуулганыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Уг чуулганд 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нар, салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нар, аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ажилтнууд, орон нутаг дахь цагдаагийн алба хаагч нар нийт, 300 хүн оролцож, хуулийн хэрэгжилтийн орон нутаг дахь нөхцөл байдал, хохирогчид үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж, салбар дундын хамтын ажиллагаа, хамтарсан багийн үйл ажиллагаа болон тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж, чуулганаас гарсан саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, холбогдох арга хэмжээг авах шийдвэр гаргуулахаар шийдвэрлэв.





Дөрөв. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх талаар:

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн хэрэгжүүлж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтад “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журмыг батлах” гэж заасан.

Уг заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолоор “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журам”-ыг батлуулж, мөрдөн ажиллаж байна.

Энэхүү журмаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгчид /гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл, Дэд зөвлөл, Салбар зөвлөл, тэдгээрийн ажлын алба, түүний дарга, гишүүд/-ээс тайлан мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх харилцааг зохицуулсан.

Мөн журамд Аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Зохицуулах зөвлөлийн гишүүд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хагас жилийн тайлан, мэдээг жил бүрийн 7 дугаар сарын 5-ны өдрийн дотор, бүтэн жилийн тайлан, мэдээг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус Зохицуулах зөвлөлийн Ажлын албанд ирүүлэхээр зохицуулсан.

Аймаг, нийслэлийн Салбар зөвлөлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дараахь үндсэн үзүүлэлтээр үнэлнэ.

1.Харьяа нутаг дэвсгэртээ болон эрхлэх асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлох судалгаа хийж, түүнд үндэслэн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлсэн ажлын үр дүн;

2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт, түүний зарцуулалтын байдал;

3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дээд шатны байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулж, зохион байгуулж, хэрэгжүүлсэн байдал;

4.Хуульд заасан эрх хэмжээний хүрээнд шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн бусад байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжин тусалж, хамтран ажилласан байдал;

5.Харьяа нутаг дэвсгэр болон эрхлэх асуудал, чиг үүрэг, эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдэд хуулийг сахин биелүүлэх дадал бий болгоход чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал;

6.Харьяа нутаг дэвсгэр болон үйл ажиллагаа явуулж буй барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор шинээр дүрс бичлэгийн техник, хэрэгслийг байршуулсан эсэх, чанарын шаардлага хангасан дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбож, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байдал;

7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулсан байдал;

8.Нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн цагдаа, олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулсан байдал.

Түүнчлэн аймаг, нийслэлийн Салбар зөвлөлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үнэлэхдээ дараахь үзүүлэлтийг харгалзана:

1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, түүний зарцуулалт, тайлагналт нь холбогдох дүрэм, журамд нийцсэн эсэх, дараа жил төсөв нь нэмэгдсэн байдал;

2.16 болон түүнээс дээш насны хүн амд ногдох гэмт хэргийн өсөлт, бууралт;

3.16 болон түүнээс дээш насны хүн амд ногдох гэмт хэргийн улмаас хүний амь хохирсон тоон үзүүлэлт;

4.16 болон түүнээс дээш насны хүн амд ногдох гэмт хэргийн улмаас хүн гэмтсэн тоон үзүүлэлт;

5.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг чадавхжуулсан байдал, алба хаагчдыг сургаж, мэргэшүүлсэн байдал.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалаар үнэлж байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙГ ОЛОН УЛСАД ТАЙЛАГНАСАН БАЙДАЛ





25 429

Бүртгэгдсэн
гэмт хэрэг-Бүгд
Recorded crimes-Total

12 068

Шүүхээр шийдвэрлэгдсэн
эрүүгийн хэрэг
Resolved criminal case by Court

Гэмт хэргийн улмаас / *Due to crime*

Хохирсон хүн
Victims

24 994

15 869

Нас барсан хүн
Died persons

683

521

Гэмтсэн хүн
Injured persons

8 299

7 237

180.3

Бүртгэгдсэн хэргийн улмаас
учирсан хохирол,
тэрбум төг

Damage caused by recorded crime, billion togrogs

90.4

Нөхөн төлүүлэлт, тэрбум төг

Restituted damage, billion togrogs

82.0

Шүүхээр шийдвэрлэсэн
эрүүгийн хэргийн улмаас
учирсан хохирол,
тэрбум төг

Damage caused resolved criminal case by Court, billion togrogs

27.3

Нөхөн төлүүлэлт, тэрбум төг

Restituted damage, billion togrogs

Шүүхээр ял шийтгүүлсэн хүн / *Persons convicted by court*

Бүгд / *Total*

11 263

Эмэгтэй / *Female*

1 180

Өсвөр насны хүн
Teenager

125

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙГ ОЛОН УЛСАД ТАЙЛАГНАСАН БАЙДАЛ

1.Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэх хэрэгцээ, шаардлага

Гэмт хэргийн статистикийн мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэхэд гэмт хэргийн статистикт зориулсан үндэсний ангилал чухал үүрэг гүйцэтгэдэг.

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар болон Европын эдийн засгийн комисс хамтран 2015 онд “Гэмт хэргийн статистикт зориулсан олон улсын ангилал”-ыг боловсруулан баталж, дэлхий нийтэд мөрдүүлсэн.

НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгаа нь 2016 оноос уг ангиллыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн боловч Монгол Улсын хувьд гэмт хэргийн статистикт зориулсан үндэсний ангиллаа боловсруулж, баталж, мөрдөөгүй учраас судалгааны 292 үзүүлэлтийн 192 (65.8%)-ийг гаргах, тайлагнах боломжгүй байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны мэдээлэл, бүтцээр

д/д	Хүснэгтийн нэр	Гарвал зохих үзүүлэлтийн тоо	Гарсан үзүүлэлтийн тоо	%
1	Санаатай алах гэмт хэрэг	46	30	65.2
2	Хүчирхийллийн гэмт хэрэг	24	18	75.0
3	Бусад гэмт хэрэг	19	11	57.9
4	Эрүүгийн эрх зүйн системийн үйл ажиллагаа	101	0	0.0
5	Хорихын мэдээлэл	24	20	83.3
6	Эрүүгийн эрх зүйн системийн хүний нөөц, хүчин чадал	24	18	75.0
7	Гэмт хэргийн хохирогчийн судалгаа	54	3	5.6
8	НҮБ-ын гэмт хэргийн чиг хандлагын судалгааны нийт үзүүлэлтийн тоо	292	100	34.2

Түүнчлэн, 2019 онд Монгол Улсын Статистикийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Гэмт хэргийн хохирогчийн судалгаа”-г 3 жил тутам зохион байгуулж, явуулахаар заасан. Иймд 2023 онд гэмт хэргийн хохирогчийн судалгааг явуулахаас өмнө гэмт хэргийн статистикт зориулсан гэмт хэргийн ангиллыг боловсруулж, мөрдүүлэх хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

Мөн Хууль зүйн салбарын хөгжлийг үнэлэх Тогтвортой хөгжлийн зорилтын 26 үзүүлэлтийн 8 (30.8%) үзүүлэлт нь бүрэн гарч, 11 (42.3%) үзүүлэлт нь огт гарахгүй, 7 (26.9%) үзүүлэлт нь нэг буюу түүнээс дээш задаргаагаар гарахгүй байна.

Бүрэн гарч байгаа 8 үзүүлэлтийн 3 нь НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны үзүүлэлт, 5 нь Үндэсний статистикийн хорооны Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа болон Жендерт суурилсан хүчирхийллийн судалгааны үзүүлэлтүүд байна. Огт гарахгүй байгаа 11 үзүүлэлт болон задаргаа нь дутуу гарч байгаа 7 үзүүлэлтийг гэмт хэргийн хохирогчийн судалгааг зохион байгуулснаар гаргах боломж бүрдэх юм.

Анх 1872 онд Лондон хотод зохион байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба таслан зогсоох” олон улсын чуулганы үеэр дэлхийн улсуудын гэмт хэргийн статистикийн ойлголт, тодорхойлолтын зөрүүтэй байдлаас шалтгаалж, олон улсын түвшинд гэмт хэргийн статистикийн мэдээллийг харьцуулан судлах боломжгүй байгааг тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн, олон улсын түвшинд хууль зүй, гэмт хэргийн статистикийн мэдээллийг цуглуулах үндэс нь дэлхийн улсуудын хөгжлийн түвшинг зэрэгцүүлэх, харьцуулах явдал бөгөөд үндэсний хэмжээний шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын өөр өөр мэдээллийн эх сурвалжийн мэдээллийг жигдлэх боломжийг буй болгох явдал гэдгийг тэмдэглэжээ. Гэмт хэргийн статистикт зориулсан үндэсний ангиллыг гэмт хэргийн статистикийн олон улсын ангилалд нийцүүлэн боловсруулж, нэвтрүүлснээр Монгол Улсын гэмт хэргийн статистикийн мэдээлэл олон улсад харьцуулагдах, бүрэн тайлагнах боломж бүрдэхээс гадна Олон улсын хэрэг бүртгэх журмыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Гэмт хэргийн статистикийн олон улсын

ангилал (ГХСОУА)-ыг Европын статистикчдийн бага хурлаас 2012 онд баталсан "Статистикийн зорилгоор ашиглах гэмт хэргийн олон улсын ангиллын үндсэн зарчим, тогтолцоо"-нд үндэслэн боловсруулсан.

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал (ГХСОУА) гэж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт, тодорхойлолт, зарчимд суурилсан, гэмт хэргийн статистикийн олон улсын харьцуулалт, уялдаа холбоог сайжруулах, олон улсын болон үндэсний хэмжээнд дүн шинжилгээ хийх чадавхийг сайжруулах зорилгоор гэмт хэргийг ангилахыг хэлдэг.

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал нь хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын статистикийн мэдээллийг системтэй бэлтгэх, харьцуулах үндэс суурийг бий болгодог. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ямар ч үе шатад гэмт хэргийн мэдээллийн бүх хэлбэр болон гэмт хэргийн хохирогчийн судалгаагаар цуглуулсан мэдээллийн хувьд гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал (ГХСОУА)-ыг ашиглах боломжтой.

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал нь улс орнуудын гэмт хэргийн мэдээллийг олон улсын түвшинд харьцуулах боломж олгоно.

2.НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны мэдээлэл цуглуулалт, тайлагналт

НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны мэдээллийг НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар жил бүр НҮБ-ын гишүүн 130 улсаас цуглуулж, https://dataunodc.un.org/ цахим хуудсаар дамжуулж, дэлхий нийтэд мэдээлдэг. Түүнчлэн, цуглуулсан мэдээлэлдээ үндэслэн сэдэвчилсэн судалгаа, тайлан, гарын авлага, зөвлөмж боловсруулж, олон улсын түвшинд тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг зөвлөдөг.

1.1 НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны 2021 оны мэдээлэл

Хүснэгт 1. Санаатай алах гэмт хэрэг, 2018-2021 он

1 - Санаатай аллагын мэдээлэл 1-(Intentional homicide data)								Цагдаа эсвэл бусад хууль сахиулах байгууллага Police or other law enforcement
Жилийн үзүүлэлт (Annual variables)								
Үзүүлэлт (Indicators)					2018	2019	2020	2021	Нэмэлт тайлбар Additional comments
1.1	**Хүний амин хүрсэн болон хүрэхийг завдсан хэрэг Acts leading to death or intending to cause death**								
1.1.1	Санаатай аллага (0101), гэмт хэргийн тоо Intentional homicide (0101) number of offences				192	197	192	194	
1.1.2	Санаатай аллага үйлдэхийг завдсан (0102), гэмт хэргийн тоо Attempted intentional homicide (0102)number of offences				-	-	-	-	
1.2	**Санаатай аллагын ХОХИРОГЧ, хүйсээр (SV) Intentional homicide VICTIMS by sex(SV)**								
1.2.1	Санаатай аллагын нийт хохирогч (0101) Total victims of intentional homicide(0101)				196	205	205	206	
1.2.1a	Санаатай аллагын эрэгтэй хохирогч (0101) Male victims of intentional homicide(0101)				151	165	165	163	
1.2.1b	Санаатай аллагын эмэгтэй хохирогч (0101) Female victims of intentional homicide(0101)				45	40	40	43	
1.3	**Санаатай аллагын ХОХИРОГЧ, гэмт хэрэгтэн, хохирогчийн хамаарал болон хүйсээр (ViP/SV) Intentional homicide VICTIMS by victim-perpetrator relationship and sex(ViP/SV)**								
1.3.1	Санаатай аллагын хохирогч (0101) хөнөөсөн хүнээр: Victims of intentional homicide(0101) killed by	Ойр дотны хамтрагч эсвэл гэр бүлийн гишүүн (IPFM) Intimate partner or family member(IPFM)	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females		5	28	12	36	
1.3.1a			Эрэгтэй Male		2	20	5	28	
1.3.1b			Эмэгтэй Female		3	8	7	8	
1.3.1.1		Ойр дотны хамтрагч Intimate partner	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females		3	20	8	28	
1.3.1.1a			Эрэгтэй Male		1	14	3	26	
1.3.1.1b			Эмэгтэй Female		2	6	5	2	
1.3.1.2		Гэр бүлийн гишүүн Family member	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females		2	8	4	8	
1.3.1.2a			Эрэгтэй Male		1	6	2	2	
1.3.1.2b			Эмэгтэй Female		1	2	2	6	
1.3.2		Хохирогчийг таних бусад гэмт хэрэгтэн Other perpetrator know to the victim	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females		45	58	47	68	
1.3.2a			Эрэгтэй Male		40	47	46	56	
1.3.2b			Эмэгтэй Female		5	11	1	12	
1.3.		Хохирогчийг үл таних гэмт хэрэгтэн Perpetrator unknow to the victim	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females		62	91	78	42	
1.3.3a			Эрэгтэй Male		51	75	70	37	
1.3.3b			Эмэгтэй Female		20	16	8	5	
1.3.4		Гэмт хэрэгтэн нь тодорхойгүй хамаарал нь тодорхой бус хэрэг Relationship to perpetrator is not know	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females		84	28	68	60	
1.3.4a			Эрэгтэй Male		58	23	44	42	
1.3.4b			Эмэгтэй Female		17	5	24	18	

Эх үүсвэр: ЦЕГ-ын бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл

1.4	**Санаатай аллагын ХОХИРОГЧ, хүйсээр, үйлдэгдсэн байдлаар (SiC/SV) Intentional homicide VICTIMS by situational context and sex (SIC/SV)**							
1.4.1.1	Санаатай аллагын хохирогч, хамаарлаар (0101) Victims of intentional homicide(0101) related холбогдох:	Зохион байгуулалттай бүлгээр үйлдсэн Organized criminal groups	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	-	-	-	-	
1.4.1.1a			Эрэгтэй Male	-	-	-	-	
1.4.1.1b			Эмэгтэй Female	-	-	-	-	
1.4.1.2		Бусад эрүүгийн үйлдлээр Other criminal activities	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	-	-	-	-	
1.4.1.2a			Эрэгтэй Male	-	-	-	-	
1.4.1.2b			Эмэгтэй Female	-	-	-	-	
1.4.2		Хувь хүмүүс хоорондын аллага Interpersonal homicide	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	-	-	-	-	
1.4.2a			Эрэгтэй Male	-	-	-	-	
1.4.2b			Эмэгтэй Female	-	-	-	-	
1.4.3		Нийгэм-улс төрийн аллага Socio-political homicide	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	-	-	-	-	
1.4.3a			Эрэгтэй Male	-	-	-	-	
1.4.3b			Эмэгтэй Female	-	-	-	-	
1.4.3.1		Алан хядах үйл ажиллагаа Terrorist offences	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	-	-	-	-	
1.4.3.1a			Эрэгтэй Male	-	-	-	-	
1.4.3.1b			Эмэгтэй Female	-	-	-	-	
1.4.4		Аллагын мэдэхгүй төрлүүд Unknow n types of homicide	Эрэгтэй ба эмэгтэй Male and Females	196	190	190	206	
1.4.4a			Эрэгтэй Male	151	155	155	163	
1.4.4b			Эмэгтэй Female	45	35	35	43	
1.5	**Санаатай аллагын хохирогч, аллага үйлдсэн арга хэрэгслээр (We) Intentional homicide VICTIMS by mechanism of killing (We)**							
1.5.1	Санаатай аллагын хохирогчид (0101) халдсан: VICTIMS of intentional homicide(0101) attacked w ith;	Галт зэвсэг эсвэл тэсэрч дэлбэрэх бодис Firearms or explosives						
1.5.1.1		Галт зэвсэг Firearm		6		2	3	
1.5.2		Бусад буу зэвсэг Another w eapon		85	110	75	111	
1.5.2.1		Хурц иртэй зэвсэг Sharp object		85	110	30	75	
1.5.3		Ямар ч зэвсэггүй /бусад механизм Whithout a w eapon/ Other mechanism		105	54	-	17	
1.5.4		Тодорхойгүй аргаар Unspecified		-	-	-	-	

Эх үүсвэр: ЦЕГ-ын бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл

Хүснэгт 2. Хүчирхийллийн гэмт хэрэг, 2018-2021 он

2 - Хүчирхийллийн гэмт хэргийн мэдээлэл Violent Crimes data				2- Цагдаа эсвэл бусад хууль сахиулах байгууллага Police or other law enforcement				
Жилийн үзүүлэлт Annual variables								
				2018	2019	2020	2021	Нэмэлт тайлбар Additional comments
2.1	**Хувь хүнд хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан гэмт хэрэг Acts causing harm or intending to cause harm to the person**							
2.1.1	Хүнд хэлбэрийн танхайн (020111) гэмт хэргийн тоо Serious assualt (020111) number of offences			326	238	310	370	
2.1.2	Хүн хулгайлах (020221) гэмт хэргийн тоо Kidnapping(020221)number of offences			6	4	2	2	
2.2	**Бэлгийн шинж чанартай хохирол учруулсан үйлдэл Injurious acts of a sexual nature**							
2.2.1	**Бэлгийн хүчирхийлэл (0301) гэмт хэргийн тоо violence (0301) number of offences**		**Sexual**	621	610	505	540	
2.2.1.1	Хүчиндэх (03011) гэмт хэргийн тоо (03011) number of offences		Rape	519	481	401	439	
2.2.1.2	Бэлгийн дарамт (03012) гэмт хэргийн тоо Sexual assault (03012) number of offences			12	15	14	8	
2.2.1.3	Бэлгийн хүчирхийллийн бусад төрөл (03019) гэмт хэргийн тоо Other acts of sexual violence(03019) number of offences			83	114	90	93	
2/2/2002	Бэлгийн мөлжлөгийн (0302) гэмт хэргийн тоо Sexual exploitation (0302) number of offences			7	6	3	3	
2.3	**Хүчирхийлэх, айлган сүрдүүлэх зэргээр бусдын эд хөрөнгийг дээрэмдэх Acts against property involving violence or threat against a person**							
2.3.1	Дээрэм (0401) гэмт хэргийн тоо Robbery(0401) number of offences			1,497	868	404	366	
Солигддог үзүүлэлт Rotating variables								
2.8	**Бэлгийн мөлжлөгийн ХОХИРОГЧ, хүйсээр, насны бүлгээр Sexual exploitation VICTIMS by sex and age (SV/AV)**							
2.8.1a	Бэлгийн мөлжлөгийн хохирогч (0302): Victims of sexual exploitation(0302)	Эрэгтэйчүүд, насны бүлгээр Males aged	0-9 9	0 to				
			10-17 17	10 to				
			18-24 24	18 to				
			25-44 44	25 to				
			45-59 59	45 to				
			60 ба түүнээс дээш and older	60				
2.8.2 a			Мэдэхгүй Unknow n					
2.8.4 a		Нийт эрэгтэй хохирогч Total male victims						
		Эмэгтэйчүүд, насны бүлгээр Females aged	0-9 9	0 to				
			10-17 17	10 to				
			18-24 24	18 to				
			25-44 44	25 to				
2.8.5 a			45-59 59	45 to				
2.8.6 a			60 ба түүнээс дээш and older	60				
2.8.7 a			Мэдэхгүй Unknow n					
		Нийт эмэгтэй хохирогч Total female victims						

Эх үүсвэр: ЦЕГ-ын бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл

Хүснэгт 3. Бусад гэмт хэрэг, 2018-2021 он

3 - Бусад гэмт хэргийн мэдээлэл 3- Other crimes data						Цагдаа эсвэл бусад хууль сахиулах байгууллага Police or other law enforcement
Жилийн үзүүлэлт Annual variables						
		2018	2019	2020	2021	Нэмэлт тайлбар Additional comments
3.1	**Хяналтад байдаг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бусад бодистой холбоотой хэрэг Acts involving controlled psychoactive substances or other drugs**					
3.1.1	Хяналтад байдаг мансууруулах бодис, бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэг (0601), гэмт хэргийн тоо Unlaw ful acts involving controlled drugs or precursors(0601) number of offences	200	258	204	187	
3.1.1.1	Хяналтад байдаг мансууруулах бодисыг хувийн хэрэглээнд хууль бусаар эзэмших, худалдан авах, хэрэглэх, тариалах эсвэл боловсруулах(06011), гэмт хэргийн тоо Unlaw ful possession, purchase, use, cultivation or production of controlled drugs for personal consumption (06011)number of offences	200	258	204	187	
3.1.1.2	Хяналтад байдаг мансууруулах бодисыг бусдын хэрэглээнд хууль бусаар худалдаалах, тариалах эсвэл боловсруулах (06012), гэмт хэргийн тоо Unlaw ful trafficking cultivation or production of controlled drugs or precursors not for personal consumption(06012) number of offences	-	-	-	-	
3.2	**Залилан, хууран мэхлэх, авлигын хэрэг Acts involving fraud, deception or corruption**					
3.2.1	Авлига (0703) гэмт хэргийн тоо Corruption(0703) number offences	362	523	314	335	
3.2.1.1	Хээл хахууль (07031), гэмт хэргийн тоо Bribery (07031) number of offences	58	101	107	119	
3.2.1.2	Авлигын бусад төрлийн гэмт хэрэг (07039), гэмт хэргийн тоо Other acts of corruption(07032-07039) number of offences	304	422	207	216	
3.3	**Нийтийн хэв журам, засаг захиргаа, төрийн хууль, дүрмийн эсрэг үйл Acts against public order, authority and provisions of the State**					
3.3.1	Цагаачдыг хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн хэрэг (08051), гэмт хэргийн тоо Smuggling of migrants (08051) number of offences	-	-	-	-	
3.4	**Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг Acts against public safety and state security**					
3.4.1	Зэвсэг, дэлбэрэх бодис худалдаалах (09012), гэмт хэргийн тоо Trafficking of w eapons and explosives (09012) number of offences	-	3	-	-	
3.4.2	Зохион байгуулалттай гэмт хэрэгт оролцох (09051), гэмт хэргийн тоо Participation in an organized criminal group (09051) number of offences	-	-	-	-	
3.4.3	Алан хядах бүлэглэлийн үйл ажиллагаанд оролцох (09061), гэмт хэргийн тоо Participation in a terrorist group (09061) number of offences	-	-	-	-	
3.4.4	Алах хядах үйл ажиллагаа санхүүжүүлэх (09062), гэмт хэргийн тоо Financing of terrorism (09062)number of offences	-	-	-	-	

		2018	2019	2020	2021	Нэмэлт тайлбар Additional comments
3.7	**Нийгмийн аюулгүй байдал ба төрийн хамгаалалтын эсрэг гэмт хэрэг Acts against public safety and state security**					
3.7.1	Компьютерийн системд хууль бусаар нэвтрэх (9031) хэргийн тоо Unlaw ful access to computer system (9031), number of offences	42	57	146	151	
3.7.2	Компьютерийн системд эсвэл компьютерийн өгөгдөлд хууль бусаар хөндлөнгөөс нэвтрэх (09032) хэргийн тоо Unlaw ful interference w ith a computer system or computer data(09032), number of offence	42	57	146	151	
3.7.3	Компьютерийн өгөгдөлд хууль бусаар хөндлөнгөөс нэвтрэх, нэвтрэх Unlaw ful interception or access of computer data (09033) number of offences					
3.8	**Хүрээлэн буй байгаль орчны эсрэг Acts against the natural environment**					
3.8.1	Байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан үйлдэл Acts that cause enviromental pollution or degradation(1001) number of	131	137	227	179	
3.8.2	Хог хаягдал тээвэрлэх эсвэл хаях (1002) хэргийн тоо Acts involving the movement of dumpling of w aste(1002) number of offences	-	-	-	-	
3.8.3	Хориотой эсвэл дархан цаазтай ургамал амьтан худалдах, эзэмших гэмт хэргийн тоо Trade or possesion of protected or prohibited species of faune and flora(1003) number of offence	195	285	346	374	
3.8.4	Байгалийн баялгийг хомстолд оруулсан болон доройтуулсан хэрэг Acts that result in the depletion of degradation of natural resources(1004) number of offences	-	48	30	33	

Эх үүсвэр: ЦЕГ-ын бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээлэл

Хүснэгт 4. Эрүүгийн эрх зүйн системийн үйл ажиллагаа, 2018-2021 он

4 -Эрүүгийн эрх зүйн системийн үйл ажиллагаа 4-Criminal Justice system process								Цагдаа эсвэл бусад хууль сахиулах байгууллага, Прокурор, Шүүх & Хорих Polce or other law enforcement agency Prosecution, Courts, Prisons		
Жилийн үзүүлэлт Annual variables										
4.1	**ГХСОУА-ын 02 болон 03 түвшний гэмт хэрэг CIS process-ICCS Crimes level 02&03**									
2021 оны Бүртгэгдсэн/ 2020 оны баталгаажсан мэдээлэл Reported/Revised data for 2020 new 2021				Санаатай аллага (0101) Intentional homicide(0101)	Хүчиндэх Rape (03011)	Мансууруулах бодисыг эзэмших Drug possesion (06011)	Мансууруулах бодис худалдаалах Drug trafficking (06012)	Хахууль (07031) Bribery(07031)		
4.1.1.1 - 1.5	Цагдаа Police	Гэмт хэрэгт холбогдсон хүний тоо Persons brought into Formal contact for:	2020	211	294	269	-	107		
			2021	201	335	210	-	119		
4.1.1.1a - 1.5a		Эрэгтэй Males	2020	190	293	254	-	94		
			2021	179	329	194	-	113		
4.1.1.1b - 1.5b		Эмэгтэй Females	2020	21	1	15	-	13		
			2021	22	6	16	-	6		
4.1.2.1 - 2.5	Прокурор Prosecution	Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хүний тоо Persons prosecuted for:	2020	258	447	266	48	157		
			2021	230	462	212	38	164		
4.1.3.1 - 3.5	Шүүх Courts	Ял шийтгүүлсэн хүний тоо Persons convicted for:	2020	210	307	191	-	47		
			2021	205	328	186	1	64		
4.1.4.1 - 4.5	Хорих Prison	Хоригдож буй хүний тоо Persons held for:	2020	194	291	203	8	20		
			2021	165	286	102	7	20		

Эх үүсвэр: Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын гэмт хэргийн мэдээлэл

Солигдог үзүүлэлт Rotating variables														
4.6	**CJS Процесс - ГХСОУА 1 түвшний гэмт хэрэг**													
2017 оны Бүртгэгдсэн/ 2016 оны баталгаажсан мэдээлэл Reported/Revised data for 2016 new 2017				Хүний амин хүрсэн болон завдсан хэрэг Acts leading to death of intending to cause death	Хүнд хохирол, гэмтэл учруулсан, учруулахыг завдсан хэрэг Acts leading to harm or intending to cause harm to the person	Бэлгийн шинж чанартай хохирол учруулсан үйлдэл Injures acts of a sexual nature	Хүний эсрэг хүчирхийлэл, сүрдүүлэг бухий өмчийн эсрэг үйлдэл Acts against property involving violence or threat against a person	Зөвхөн өмчийн эсрэг үйлдэл Acts against property only	Хяналтад байдаг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үйлдэл Acts involving controlled psychoactive substances or other drugs	Залилан, хууран мэхлэх, авлигын хэрэг Acts involving fraud, deception or corruption	Нийтийн хэв журам, эрх мэдлийн эсрэг үйлдэл Acts against public order, authority and provisions of the State	Терийн хамгаалалт, нийгмийн аюулгүй байдлын эсрэг үйлдэл Acts against public safety and state security	Байгаль орчны эсрэг үйлдэл Acts against the natural environment	Өөрөөр ангилаагүй бусад гэмт үйлдэл Other criminal acts not elsewhere classified
4.6.1.1 - 1.11	ЦАГДАА POLICE	Нийт гэмт хэргийн тоо: Total number of offences	2020 он	192	7,594	505	12,250	12,061	204	4,270	18		622	985
			2021 он	194	7,847	540	13,842	13,632	187	6,558	8		601	915
4.6.2.1 - 2.11	ЦАГДАА POLICE	Гэмт хэрэгт холбогдсон хүн: Persons in formal contact for:	2020 он	211	6,812	366	7,082	7,036	229	2,269	29		588	850
			2021 он	201	7,007	417	8,065	8,039	161	4,007	5		570	800
4.6.3.1 - 3.11	ПРОКУРОР PROSECUTION	Яллагдагчаар татсан хүн: Persons prosecuted for:	2020 он											
			2021 он											
4.6.4.1 - 4.11	ШҮҮХ COURT	Ял шийтгүүлсэн хүн: Persons convicted for:	2020 он											
			2021 он											
4.6.5.1 - 5.11	ХОРИХ PRISON	Шоронд шинээр орсон хүн: Persons entering prison for:	2020 он											
			2021 он											
4.6.6.1 - 6.11	ХОРИХ PRISON	Ял эдэлсэн хүн: Persons held for:	2020 он											
			2021 он											

Эх үүсвэр: Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын гэмт хэргийн мэдээлэл

Хүснэгт 5. Хорихын мэдээлэл

5 - Хорихын мэдээлэл 5- Prisons data				Хорих болон тэнсэн харгалзах байгууллага Prison and Probation services				
Жилийн үзүүлэлт Annual variables								
				2018	2019	2020	2021	Нэмэлт тайлбар Additional comments
5.1	**Хоригдлын тоо, хүйс, насны ангиллаар / иргэншлээр Person held by age status and sex/by citizenship**							
5.1.1	Хорих анги, засан хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүмүүс Persons held in Prisons, penal institutions or Correctional institutions	**Хоригдож байгаа нийт хүний тоо Total number of persons held**		4,804	5,275	5,658	4,068	
5.1.2		Насанд хүрсэн Adults	Эрэгтэй ба эмэгтэй Male and females	4,730	5,202	5,607	4,031	
5.1.2a			Эрэгтэй Male	4,503	4,914	5,241	3,770	
5.1.2b			Эмэгтэй Female	227	288	366	261	
5.1.3		Өсвөр насны Juvenile	Эрэгтэй ба эмэгтэй Male and females	74	73	51	37	
5.1.3a			Эрэгтэй Male	72	70	47	36	
5.1.3b			Эмэгтэй Female	2	3	4	1	
5.1.4		Хоригдож байгаа дотоодын иргэн National citizens held		4,780	5,233	5,613	4,032	
5.1.5		Хоригдож байгаа гадаадын иргэн Foreign citizens held		24	42	45	36	
5.2	**Хоригдож байгаа хүний тоо, ял эдэлсэн байдал, хүйсээр Persons held by sentencing status and sex**							
5.2.1	Хорих анги, шийтгэх байгууллага болон засан хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүмүүс	Ял эдлэхээс өмнө хоригдсон Unsentenced	Эрэгтэй ба эмэгтэй Male and females	1,279	1,342	1,169	1,024	
5.2.1a			Эрэгтэй Male	1,199	1,255	1,047	929	
5.2.1b			Эмэгтэй Female	80	87	122	95	
5.2.2		Ял эдэлсэн Sentenced		3,525	3,933	4,489	3,044	
5.2.2.1		үүнээс: Ялыг бүрэн эдлээгүй Of w hich: With a non-final sentencing decision						
5.2.2.2		үүнээс: эцсийн байдлаар ял эдэлсэн of w ich: With a final sentencing decision		3,525	3,933	4,489	3,044	
5.3	**Ял эдлэхээс өмнө хоригдсон хүний тоо, цагдан хоригдсон хугацаагаар Persons held unsentenced by length of detention**							
5.3.1	Хорих анги, шийтгэх байгууллага болон засан хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүмүүс Persons held in Prisons, Penal institutions or Correctional institutions	Ял эдлэхээс өмнө хоригдсон хүний тоо, цагдан хоригдсон хугацаагаар: Number of persons held unsentenced by length of detention	12 сараас их More than 12 months	22	36	16	12	
5.3.2			12 сараас бага Less than 12 months	1,257	12	1,153	1,012	
5.3.2.1			үүнээс: 6 сараас бага of w hich: less than 6 months	1,201	1,294	1,144	1,009	
Солигддог үзүүлэлт Rotating variables								
5.5	**Шоронд шинээр орсон хүн, ял эдэлж байгаа байдлаар Persons entering prisons by sentencing status**							
5.5.1	Шоронд шинээр орсон хүн	Шоронд орсон нийт хүний тоо Total number of persons entering prisons						
5.5.1.1		Ял эдэлсэн Sentenced						
5.5.1.2		Ял эдлэхээс өмнө хоригдсон Unsentenced						
5.6	**Шоронд шинээр орсон хүн, ял эдэлж байгаа байдлаар**							
5.5.1	Ял шийтгүүлсэн хүн, хяналтын бусад төрлөөр	Эрэгтэй ба эмэгтэй Male and females						
5.5.1.1		Эрэгтэй Male						
5.5.1.2		Эмэгтэй Female						

Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорихын статистикийн мэдээлэл

Хүснэгт 6. Эрүүгийн эрх зүйн систем, хүний нөөц, хүчин чадал

6 - Эрүүгийн эрх зүйн тогтолцоо, хүний нөөц & хүчин чадал 6-Criminal Justice System Personel&capacity	Цагдаа эсвэл бусад хууль сахиулах байгууллага, Прокурор, Шүүх & Хорих Polce or other law enforcement agency Prosecution, Courts, Prisons

Солигддог үзүүлэлт (бусад жил болгон энэхүү хэсгийг бөглөнө)
Rotating variables(section requested every other year)

				2018	2019	2020	2021	Нэмэлт тайлбар Additional comments
6.1	**Цагдаагийн бие бүрэлдэхүүн хүйс / чиг үүргээр Police personal by sex/by function**							
6.1.1	Цагдаа Police	Цагдаагийн бие бүрэлдэхүүн Police personal	Эрэгтэй ба эмэгтэй Male and females	8200	8200	10500	10500	
6.1.1a			Эрэгтэй Male	6600	6600	9200	9200	
6.1.1b			Эмэгтэй Female	1600	1600	1300	1300	
6.1.2		Цагдаагийн ажилтан, хариуцах чиглэлээр Police personal responsible for:	Урьдчилан сэргийлэх Prevention	500	500	360	360	
6.1.3			Илрүүлэх Detection	2000	2000	9578	9578	
6.1.4			Захиргааны/бусад Administration/Other	5700	5700	562	562	
6.2	**Прокурорын албан хаагчид хүйсээр Prosecution personnel by sex**							
6.2.1	Прокурор Prosecution	Прокурорын ажилтан: Prosecution personnel:	Эрэгтэй ба эмэгтэй Male and females	526	512	545	569	
6.2.1a			Эрэгтэй Male	236	241	256	275	
6.2.1b			Эмэгтэй Female	290	271	289	294	
6.3	**Магистрийн зэрэгтэй, мэргэжлийн шүүгч, хүйсээр Professional Judges or Magistrates by sex**							
6.3.1	Шүүх Courts	Мэргэжлийн шүүгч эсвэл шүүгчид Professional judges or Magistrates	Эрэгтэй ба эмэгтэй Male and females	503	506	506	512	
6.3.1a			Эрэгтэй Male	185	182	182	191	
6.3.1b			Эмэгтэй Female	318	324	324	321	
6.4	**Хорих ангийн албан хаагчид хүйс / чиг үүргээр Prison personnel by sex/by function**							
6.4.1	Хорих Prison	Хорих ангийн ажилтан: Prison staff	Эрэгтэй ба эмэгтэй Male and females	3075	3075	3146	3177	
6.4.1a			Эрэгтэй Male	2019	2019	2061	2103	
6.4.1b			Эмэгтэй Female	1056	1056	1085	1074	
6.4.2		Хорих ангийн ажилтан, хариуцсан чиглэлээр Prison staff responsible for:	Хяналтын Surveillance	10	10	10	13	
6.4.3			Боловсрол/Сургалт/Эрүүл мэндийн Education/training/health	40	40	52	52	
6.4.4			Захиргаа/Менежмент/Бусад Administration/management/other	3025	3025	3084	3112	
6.5	**Албан ёсны хорих ангийн хүчин чадал, хүйс, насны ангиллаар Official prison capacity by sex/by age status**							
6.5.1	Хорих Prison	Албан ёсны хорих анги, шийтгэх байгууллага болон засан хүмүүжүүлэх байгууллагын хүчин чадал Official capacity of Prisons, Penal institutions or correctional institutions	Насанд хүрсэн Adults	2997	4952	4952	4952	
6.5.2			Өсвөр насны Juvenules	78	42	42	42	
6.5.3			Эрэгтэй ба эмэгтэй Male and females	3075	4952	4994	4994	
6.5.3a			Эрэгтэй Male	2019	4664	4694	4694	
6.5.3b			Эмэгтэй Female	1056	288	300	300	
6.6	**Хорих ангийн тоног төхөөрөмж Prison facilities**							
6.6.1	Хорих анги, шийдвэр гүйцэтгэх байгууллага болон засан хүмүүжүүлэх байгууллага Prisons, Penal institutions or Correctional institutions		Хорих ангийн тоног төхөөрөмж Number of facilities	42				

Эх үүсвэр: Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын мэдээлэл

Хүснэгт 7. Гэмт хэргийн хохирогчийн судалгаа

7 - Хохирогчийн судалгаа 7- Victimization survey			Үндэсний статистикийн байгууллага эсвэл Хохирогчийн судалгаа хариуцсан бусад байгууллага National Statistical Office or other authority responsible for Victimization Surveys		
Жилийн үзүүлэлт Annual variables		**Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он, Судалгааны түүвэрт 14500 сонгогдсноос 13798(95.0%) өрх бүрэн хамрагдсан.**			
			2018	2019	Нэмэлт тайлбар Additional comments
7.1	**Хамралтын түвшин Prevalence rate**			**95.0%**	
7.1.1	Өөрийн амьдарч буй орчиндоо ганцаараа алхахдаа аюулгүй байдлыг мэдэрдэг хүн амын эзлэх хувь Percentage of population that feel safe w alking alone around the area they live in	Эрэгтэй Male		83.7%	
		Эмэгтэй Female		54.8%	
7.1.2	Хамралтын түвшин: Prevalence rate of:	Орон байрны хулгайн хэрэг Burglary			
7.1.3		Моторт тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн хулгай Motor-vehicle theft			
7.1.4		Хээл хахууль Bribery	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females		
7.1.4a			Эрэгтэй Male		
7.1.4b			Эмэгтэй Female		
7.1.5		Бизнесийн хахууль Bribery among businesses			
7.1.6		Бие махбодийн хүчирхийлэл Physical violence	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females		
7.1.6a			Эрэгтэй Male		
7.1.6b			Эмэгтэй Female		
7.1.7		Дээрэмдэх Robbery			
7.1.8		Биеийн хүчирхийлэл Physical assault			
7.1.9		Бэлгийн хүчирхийлэл Sexual violence	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females		
7.1.9a			Эрэгтэй Male		
7.1.9b			Эмэгтэй Female		
7.1.10		Бэлгийн дарамт Sexual assault			
7.1.11		Хүчиндэх Rape			
7.1.12		Сэтгэл санааны хүчирхийлэл Psychological violence	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females		
7.1.12a			Эрэгтэй Male		
7.1.12b			Эмэгтэй Female		
7.1.13		Бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл Physical or sexual violence	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females		
7.1.13a			Эрэгтэй Male		
7.1.13b			Эмэгтэй Female		
7.1.14		Сэтгэл санааны, бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл Psychological, physical or sexual violence	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females		
7.1.14a			Эрэгтэй Male		
7.1.14b			Эмэгтэй Female		
7.1.15		Биеийн болон бэлгийн дарамт Physical or sexual harrassment	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females		
7.1.15a			Эрэгтэй Male		
7.1.15b			Эмэгтэй Female		

7.2	Бүртгэлийн түвшин Reporting Rate						
7.2.1	Цагдаагийн болон бусад эрх бүхий байгууллагуудад бүртгэгдсэн түвшин:: Reporting Rate to the Police or other competent authorities of :	Бие махбодийн хүчирхийлэл Physical violence	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females				
7.2.1a			Эрэгтэй				
7.2.1b			Эмэгтэй				
7.2.3		Дээрэм Robbery	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females				
7.2.3a			Эрэгтэй Male				
7.2.3b			Эмэгтэй Female				
7.2.4		Биеийн хүчирхийлэл Physical assault	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females				
7.2.4a			Эрэгтэй Male				
7.2.4b			Эмэгтэй Female				
7.2.5		Бэлгийн хүчирхийлэл Sexual violence	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females				
7.2.5a			Эрэгтэй Male				
7.2.5b			Эмэгтэй Female				
7.2.6		Бэлгийн дарамт Sexual assault	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females				
7.2.6a			Эрэгтэй Male				
7.2.6b			Эмэгтэй Female				
7.2.7		Хүчиндэх Rape	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females				
7.2.7a			Эрэгтэй Male				
7.2.7b			Эмэгтэй Female				
7.2.8		Бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл Physical or sexual violence	Эрэгтэй ба эмэгтэй Males and Females				
7.2.8a			Эрэгтэй Male				
7.2.8b			Эмэгтэй Female				

НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны үндсэн зорилго нь гэмт хэргийн талаарх тоон мэдээллийг гишүүн орнуудаас цуглуулах, эрүүгийн эрх зүйн тогтолцоог сайжруулах чиглэлээр дүн шинжилгээ хийх, мэдээллийг дэлхий дахинд тархаах, судалгааны үр дүнгээр эрүүгийн эрх зүйн тогтолцооны тодорхой шат бүрийн талаархи мэдээллийн уялдаа холбоог хангах, бүх түвшинд нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг.

НҮБ-ын Гэмт хэргийн чиг хандлагын судалгааны мэдээлэлд үндэслэн дэлхийн хэмжээнд доорх тайланг эрхлэн гаргасан байна. Үүнд:

- 2019 онд Хүнийг алах гэмт хэргийн дэлхийн тайлан,
- 2020 онд Галт зэвсгийн дэлхийн тайлан,
- 2020 онд Хүн худалдаалах гэмт хэргийн тайлан,
- 2020 онд Ан амьтан худалдаалах хэргийн тайлан.

Дэлхий дахинд эрүүгийн эрх зүйн тогтолцоо, хууль дээдлэх ёс нь ялгаатай, олон талт шинж чанартай байдаг тул шударга ёсыг бэхжүүлэхийн тулд үндэсний статистикийн үйл ажиллагааг чиглүүлж чадах уялдаа бүхий үзэл баримтлал, тогтолцоог боловсронгуй болгох ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр ашиг, хууль зүйн туслалцаа авах,

туслалцаа үзүүлэх, хорихоос өөр төрлийн ялын хэрэглээ, үйл ажиллагааны үр дүн зэрэг асуудлын талаарх мэдээллийг уялдуулах хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Сүүлийн жилүүдэд холбогдох зарим үзүүлэлтийг хэмжих үзэл баримтлал, гарын авлагыг гаргасан дэвшил гарсан хэдий ч эрүүгийн хэргийн харьцуулалт, мэдээллийн хамралтыг сайжруулахын тулд гэмт хэргийн статистикт зориулсан гэмт хэргийн олон улсын ангиллыг эрүүгийн эрх зүйн тогтолцооны өөр өөр үе шатанд хэрэгжүүлэх, тухайн шатан дахь мэдээллийн уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ





НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Монгол Улсад 2021 онд бүртгэсэн гэмт хэргийн статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Нэг.Бүртгэсэн гэмт хэргийн төлөв байдал, үйлдэгч, хохирогчийн талаар

1. Монгол Улсад 2021 онд нийт 25429, Улаанбаатар хотод 16534 буюу 65.0.%, орон нутагт 8880 буюу 34.9%, бусад газарт буюу хилийн чанадад үйлдсэн 15 буюу 0.1% гэмт хэрэг бүртгэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд нийт 2365 хэрэг буюу 10.3 хувиар, нийслэлийн хэмжээнд 1901 хэрэг буюу 13.0 хувиар, орон нутгийн хэмжээнд 460 хэрэг буюу 5.5%-иар, бусад газарт 4 хэрэг буюу 36.4%-иар тус тус өссөн байна.

2. Цагдаагийн байгууллага 2021 онд 48017 хэрэгт хэрэг бүртгэлт, 8508 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 56525 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 21951 урьд оны үлдэгдэл хэрэг, 32419 энэ оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 45, урьд оны хэрэгсэхгүй болгосоноос сэргээсэн 2110 хэрэг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэрэг 20893 хэрэг буюу 58.6%-иар өссөн байна. Нийт шалгасан хэргийн 14543 буюу 40.6%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж, 15273 буюу 42.7%-ийг шүүхэд шилжүүлж, 2236 буюу 6.2%-ийг хэрэгсэхгүй болгож, 3246 буюу 9.1%-ийг нэгтгэн, 505 буюу 1.4%-ийг хэрэг бүртгэлтийн хэрэг нэгтгэж, нийт шалгасан хэргийн 63.3%, хуулийн анхны хугацаанд 83.3%-ийг шийдвэрлэсэн байна.

3. Монгол Улсын хэмжээнд 2021 онд зам тээврийн ослын шинжтэй 79260 дуудлага хүлээн авч 22482 зам тээврийн осол бүртгэн шалгасан байна. Зам тээврийн ослын шинжтэй дуудлага 13610, бүртгэгдсэн зам тээврийн осол 714 нэгжээр тус тус өссөн байна. Тухайн онд тээврийн хэрэгсэл, автомашины өсөлт 7.9-8.3% байхад зам тээврийн ослын шинжтэй дуудлага, бүртгэгдсэн зам тээврийн осол 19.8-20.7%-иар өсөв. Монгол Улсын хэмжээнд 2021 онд 22482 зам тээврийн осол бүртгэгдсэний 19218 буюу 85.4% нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

4. Прокурорын байгууллага 2021 онд 61217 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавьсан байна. Үүнээс хэрэгсэхгүй болгосон 1663, шүүхэд шилжүүлсэн 12582, нэгтгэсэн 6089, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан 15051, тухайн жил эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 10413 хэрэг байна.

5. Монгол Улсын хэмжээнд 2021 онд үйлдсэн гэмт хэргийн улмаас 24994 хүн хохирсон нь өмнөх оныхтой харьцуулахад 1944 хүн буюу 8.4%-иар өсжээ. Үүнээс 683 хүн нас барсан нь өмнөх онтой харьцуулахад 13 буюу 1.9%-иар өссөн байна. 2021 онд гэмт хэргийн улмаас 59 хуулийн этгээд хохирсон. 2021 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан 750.7 тэрбум төгрөгийн хохирлын 392.7 тэрбум төгрөг буюу 52.3%-ийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна.

6. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 2021 онд 17979 хүн, 5 хуулийн этгээдэд холбогдох 14182 хэрэг хүлээн авснаас 1 хуулийн этгээд, 1144 хүнд холбогдох 691 хэргийг прокурорт буцааж, 114 хүнд холбогдох 92 хэргийг түдгэлзүүлж, 326 хүнд холбогдох 175 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 1 хуулийн этгээд, 1252 хүнд холбогдох 912 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хуулийн этгээд, 144 хүнд холбогдох 67 хэргийг цагаатгаж, нийт 12068 хэргийг шийдвэрлэж 2 хуулийн этгээд, 13091 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, үүнээс 1560 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 190 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 11263 хүнд ял оногдуулсан байна. Үүнийг 2020 онтой харьцуулбал хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 10.4%-иар, ял шийтгүүлэгчдийн тоо 15.9%-иар тус тус буурсан дүнтэй байна.

7. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2021 онд улсын хэмжээнд 6179 хүн, 2 хуулийн этгээдийг торгох ялаар, 1518 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар, 2518 хүнийг

хорих ялаар, 1 хүнийг баривчлах ял тус тус шийтгэж, 63 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг, 15 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тус тус хэрэглэсэн байна.

8. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүд 2021 онд 2313 хэрэг хүлээн авч, 2105 хэргийг хянан шийдвэрлэж, 138 хэргийн үлдэгдэлтэй, 12 хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах прокурорын дүгнэлтийг хүлээн авч, 70 хэрэгт давж заалдах шатны шүүхээр хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гарсан байна. Давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо өмнөх оноос 597 хэргээр буюу 22.1 хувиар, үлдэгдэл хэргийн тоо 31 хэргээр буюу 18.3 хувиар тус тус буурчээ.

9. УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхим 2021 онд нийт 948 хэрэг хүлээн авч, 322 хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар, 55 хэрэгт Ерөнхий шүүгчид гомдол гаргасныг танилцуулж, албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн бөгөөд 529 хэргийг хянан буцааж, 2 хэрэгт Ерөнхий шүүгч дүгнэлт гаргаж, нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэсэн ба тайлант хугацааны төгсгөлд 40 хэргийн үлдэгдэлтэй байна.

10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллээр 2021 онд 3044 хүн хорих ял биечлэн эдэлсэн нь 2020 онд хорих ял биечлэн эдэлсэн хоригдлын тоотой харьцуулахад 1445 буюу 32.2 хувиар буурсан байна.

11. Авлигатай тэмцэх газар 2021 онд хуульд заасан харьяаллын 1543 үйлдэлтэй, 909 холбогдогчтой, 1307 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь өмнөх онтой харьцуулбал, 1.8%-иар буурсан байна.

12. Шүүхийн шинжилгээний байгууллагаас 2021 онд улсын хэмжээнд эрүү, иргэн, захиргааны хэрэг маргаантай холбоотой нийт 58424 шинжилгээ хийсэн байх ба 33631 буюу 57.6%-ийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 5836 буюу 27.1%-ийг тусгай шинжилгээ, 8766 буюу 15%-ийг криминалистикийн шинжилгээ, 191 буюу 0.3%-ийг шүүх эдийн засгийн шинжилгээ эзэлж байна. Энэ нь өмнөх оны шинжилгээний статистик үзүүлэлтээс 5945 шинжилгээгээр бага буюу 10.2%-иар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 2021 онд нийт 21953 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бөгөөд үүнийг өмнөх онтой харьцуулахад 5586 буюу 20.3%-иар буурсан байна. Хэргийн газрын үзлэгээр нийт 54668 ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэн ажилласан байна.

Хоёр.Бүртгэсэн зөрчлийн статистикийн талаар

1. Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд 2074412 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 202456 буюу 8.9%-иар, үүнээс 2069950 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 202396 буюу 8.9%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

